



ДЭЛХИЙН БАНК
ОУСБХБ • ОУХА | ДЭЛХИЙН БАНК ГРУПП



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



Монгол улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх (МУНЭХБ) ТӨСӨЛ

Дэд төслийн хэрэгжилтэд хийсэн Хөндлөнгийн үнэлгээний тайлан

Дэлхийн банкны захиалгаар олон улсын
зөвлөх Вадель Кабрера бэлтгэв.

2017 оны 11 дүгээр сар

Товчилсон үгийн жагсаалт

АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
БХАН	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг
БНБТ	Бүх нийт боловсролын төлөө! Үндэсний эвсэл
БЭОТ	Бүсийн эмчилгээ, оношлогооны төв
ДЕМО	Ардчиллын боловсрол төв
ИОК	Иргэдийн онооны карт
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МУНЭХБТ	Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь төсөл
МНЭММН	Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг

ТАЛАРХАЛ

Хөндлөнгийн үнэлгээ хийх явцад биднийг хүлээн авч цаг заваа гарган өөрийн үнэтэй санал, туршлагаа хуваалцсан орон нутгийн оролцогч талууд аймгийн удирдлага, ТББ-ын төлөөлөл, иргэд, үнэлгээний багийн гишүүдэд талархаж байна.

Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газрын ажилтнууд болон МУНЭХБ төслийн багийн хамт олонд техникийн болон захиргааны дэмжлэг үзүүлсэнд баярлалаа.

Үүнээс гадна судалгааны өгөгдөл цуглуулах, орчуулганы ажилд тусалсан Г.Пүрэвтогтоход тусгайлан талархаж байна.

Тайлангийн хураангуй

“Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төсөл нь илүү ил тод, хариуцан тайлагнадаг, үр дүнтэй улсын салбарын хөрөнгийн удирдлагыг үндэсний болон орон нутгийн түвшинд бий болгох зорилгоор 10 аймаг, нийслэлийн 3 дүүрэгт хэрэгжиж байна. Төслийг хэрэгжүүлэх стратеги нь иргэдийн оролцооны үйл явц, мэдээллийг ил тод, нээлттэй олон нийтэд хүргэх тогтолцоог сайжруулахын тулд орон нутгийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллага болон олон нийтийн хамтын ажиллагааг дэмжих юм. Аймгуудад хэрэгжсэн дэд төслүүдийг сонгохдоо тухайн аймгийн ядуурлын гаралт, нийгмийн эгэх хариуцлагыг хэрэгжүүлэхэд бэлтгэгдсэн байдал, эрүүл мэнд болон боловсролын шалгуур үзүүлэлт зэрэг холимог шалгуурыг харгалзжээ.

Уг хөндлөнгийн үнэлгээг төслийн дотоодын болон донорын тайланд тусгаж оруулах, дэд төслийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, давтан хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой төслийн шийдвэр гаргахад ашиглах зорилгоор гүйцэтгэв. Хөндлөнгийн үнэлгээг гүйцэтгэхдээ дэд төслүүдийг үнэлэх дараах байдлаар үнэлж цаашид хийгдэх алхмуудыг санал болгосон.

Үүнд:

- Нийгмийн эгэх хариуцлагын үйл явц
- Засаглал, төрийн үйлчилгээ, оролцогч талуудыг чадавхижуулах талаар бий болгосон үр дүн
- Тогтвортой байдлыг хангах механизмыг бий болгох зэрэг болно.

Говь-Алтай аймгийн дэд төсөл хэрэгжиж дуусаагүй байсан учраас энэ аймгаас бусад Дорнод, Говьсүмбэр, Хэнтий, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс болон Өвөрхангайд зэрэг аймгуудад хэрэгжсэн эрүүл, мэнд боловсролын нийгмийн эгэх хариуцлагын дэд төслийн үр дүнг баримтжуулсан.

Төслийн хэрэгжилттэй газар дээр нь очиж танилцах, орон нутгийн болон үндэсний ТББ, орон нутгийн төрийн албан хаагчид, орон нутгийн удирдлага, үйлчилгээний байгууллагуудтай ярилцлага хийх зэргээр их хэмжээний мэдээллээс төслийн туршлага, сургамжийг нарийвчлан тодорхойлсон.

Оролцогч талуудтай хийсэн ярилцлагаас үзэхэд анхан шатны эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ болон хүн амын тодорхой хэсэгт

чиглэсэн сүрьеэ, амны хөндийн эрүүл мэнд, түр оршин суугчдад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бүх оролцогч талуудаар үнэлүүлэн саналыг авч бүх оролцогч талуудын хамтын ажиллагааны хүчинд дэд төслүүдийг хэрэгжүүлсэн байна. Дэд төслүүд нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх үнэлгээний дүнг шийдвэр гаргагч, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад үйлчилгээ сайжруулах, тодорхой арга хэмжээ авах шийдвэр гаргуулах зорилгоор танилцуулж ажилласан байна.

Ихэнхи үйлчилгээ сайжруулах төлөвлөгөөнүүдийг (5 дэд төслийн хүрээнд) төрийн бус байгууллагын шууд оролцоотойгоор боловсруулсан бол бусад дэд төслүүд (4 дэд төсөл) нь төлөвлөгөөг боловсруулахдаа ТББ-ын тодорхой түвшний оролцоо, санал, зөвлөмжийг тусгажээ. Харин нэг төслийн хувьд худалдан авах ажиллагааны үйл явцыг сайжруулах зорилгоор төлөвлөлт болон гэрээний гүйцэтгэлд оролцох байдлаар өвөрмөц байдлаар ажиллажээ.

Бүх дэд төслүүд нийгмийн эгэх хариуцлагын санаачлага, үйл ажиллагааг төлөвлөсний дагуу амжилттай хэрэгжүүлсэн боловч

нийгмийн эгэх хариуцлагын талаарх ойлголт болон дэд төслийн хэрэгжилтийн чанар дээр онцлох ялгаатай байв. Ховд, Сэлэнгэ аймгууд хөндлөнгийн үнэлгээний бүх шалгуур үзүүлэлтийг сайн биелүүлж цаашид түгээн дэлгэрүүлэх, хэрэгжүүлэх боломжтой тодорхой туршлага, аргачлалын жишиг, загвар болжээ.

Бүх дэд төслүүд нийгмийн эгэх хариуцлагын санаачлагын үр дүнд төрийн үйлчилгээг сайжруулах, түгээн дэлгэрүүлэх, өргөжүүлэх бүрэн боломж, чадамжтай болохоо харуулсан бөгөөд тус хөндлөнгийн үнэлгээний үр дүнд цаашид сайжруулах үйл ажиллагааны чиглэлийг зөвлөв. Тайлангийн 3-р бүлэгт аймаг тус бүрээр төслийн хэрэгжилтийг дэлгэрэнгүй авч үзсэн бөгөөд мөн аймгийн түвшинд хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагаануудыг санал болголоо. Бүхэлд нь МУНЭХБ төслийн хүрээнд дараах санаачлага, үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Нийгмийн эгэх хариуцлагын талаар болон шийдвэр гаргах үйл явц, төрийн үйлчилгээ, засаглалд иргэдийн оролцоог хангах талаарх орон нутгийн удирдлага,

үүрэг хүлээгчдийн ойлголтыг гүнзгийрүүлэх

2. Төсөл хөтөлбөрийн төлөвлөлт, боловсруулалт хийх ерөнхий чадавхаас гадна хамтран шийдвэр гаргах, асуудлыг шийдвэрлэх зорилгоор төрөөс (засгийн газраас) хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөр, төрийн үйлчилгээний чанарын талаар нотолгоонд суурилсан, асуудалд чиглэсэн, үнэн зөв дүгнэлт, санал, зөвлөмжийг боловсруулах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх
3. Иргэдийн онооны карт (ИОК)-аас гадна Монголын нөхцөлд тохирсон нийгмийн эгэх хариуцлагын загвар, аргачлалыг танилцуулах, нэвтрүүлэх
4. Иргэдийн төрийн үйлчилгээний талаарх үнэлгээ, санал болон төрийн үйлчилгээний мониторингийн үр дүн, загварыг засаглалын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, засаглалын үйл явцын нэг хэсэг болгох талаар илүү албан ёсны, институцижуулах арга замуудыг хайх.

Гарчиг

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	2
ТАЛАРХАЛ	3
ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ	4
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ҮНДЭСЛЭЛ, ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	8
Үндэслэл, судалгааны зорилтууд	9
Үнэлгээний хүрээ	10
Аргачлал	12
ХОЁРДУГААР ХЭСЭГ: МУНЭХБ ТӨСӨЛ БОЛОН АЙМГИЙН ДЭД ТӨСЛҮҮД	14
Дэд төсөл хэрэгжүүлэгчдэд зориулсан сургалт	16
Дэд төслүүд	16
ГУРАВДУГААР ХЭСЭГ: ДЭД ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ	18
ДОРНОД АЙМАГ: ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДЭД ХҮРГЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ НЬ ТӨСӨЛ	20
ГОВЬСҮМБЭР АЙМАГ: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ХЭНИЙГ Ч ОРХИГДУУЛАХГҮЙ БАЙХ НЬ ТӨСӨЛ	26

ХЭНТИЙ АЙМАГ: ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТ ХЯНАЛТЫН МЕХАНИЗМЫГ НЭВТРҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ	31
ХОВД АЙМАГ: ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТ СУРГУУЛЬ	37
ХӨВСГӨЛ АЙМАГ: ХАМТЫН ОРОЛЦООТ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ТӨСӨЛ	44
СЭЛЭНГЭ АЙМАГ: СҮРЬЕЭГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ	48
СҮХБААТАР АЙМАГ: ХҮҮХДИЙН АМНЫ ХӨНДИЙН ӨВЧЛӨЛИЙГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ	54
УВС АЙМАГ: ХАМТЫН ХҮЧ ТӨСӨЛ	60
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ: ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТ СУРГУУЛЬ	66
ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	70
Гол сургамж, МУНЭХБТ-ийн дэд төслийн үр дүнг цаашид өргөжүүлэн нэвтрүүлэхэд анхаарах асуудлууд	73
Зөвлөмж	75
Хавсралт 1: Ярилцлагын удирдамж	78

НЭГДҮТГЭЭР ХЭСЭГ:

ҮНДЭСЛЭЛ,

ҮНЭЛТГЭЭНИЙ

ХҮРЭЭ,

СУДАЛГААНЫ

АРГА ЗҮЙ

Үндэслэл, судалгааны зорилтууд

Монгол Улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх (МУНЭХБ) төсөл нь 2015 оноос Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Дэлхийн банкны хамтарсан санхүүжилтээр 10 аймаг, нийслэлийн 3 дүүрэгт хэрэгжиж байна.

Төслийн зорилго нь нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлснээр илүү ил тод, хариуцан тайлагнадаг, үр дүнтэй улсын салбарын хөрөнгийн удирдлагыг үндэсний болон орон нутгийн түвшинд бий болгох бөгөөд үүний үүний тулд:

1. Иргэний нийгмийн байгууллагуудын төртэй хариуцлага тооцох чадавхийг бэхжүүлэх;
2. Мэдээллийг түгээх болон иргэдийн оролцооны механизмын үр нөлөө, тогтвортой байдлыг (эрх зүйн орчинд бий болгох) нэмэгдүүлснээр нийгмийн эгэх хариуцлагыг институцжүүлнэ.

Түүнчлэн ядуу болон эмзэг бүлгийн иргэдийн нийгмийн эгэх хариуцлагаар дамжуулан шийдвэр

гаргах үйл явц дахь оролцоо нэмэгдэж болон эрүүл мэнд, боловсролын чанартай үйлчилгээг хүртэнэ.

10 аймгийн дэд төслүүд хэрэгжиж дуусч байгаатай холбогдуулан Дэлхийн банкнаас хэрэгжилтийн үйл явц, амжилтад нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор хөндлөнгийн үнэлгээг хийв. Үнэлгээний зорилго нь нийгмийн эгэх хариуцлагын үйл явц, үр дүн, үр нөлөө болон тогтвортой байдлыг хангах талаар үнэмлэхүй амжилт гаргасан дэд төслүүдийг тодруулах байв. Хөндлөнгийн үнэлгээний үр дүнг дараах 2 үйл ажиллагаанд ашиглана. Үүнд:

1. Төслийн дотоодын болон донорын тайланд тусгаж оруулах;
2. Дэд төслийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, давтан хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой төслийн шийдвэр гаргахад ашиглах;

Үнэлгээний хүрээ

Ар Ти Ай Интернэйшнэлийн А. Веттерберг, Д.В.Бринкерхофф, Ж.С. Хертц нарын “Засаглал ба төрийн үйлчилгээ: Нийгмийн эгэх хариуцлагыг олон салбарт хэрэгжүүлэх нь” судалгаанд суурилан хөндлөнгийн үнэлгээний хүрээг тодорхойлсон. Тус судалгаа нь нийгмийн эгэх хариуцлагыг эрүүл мэнд, боловсрол, орон нутгийн засаглалын хариу үйлдэл үзүүлэх чадавхи болон төрийн үйлчилгээ гэх мэт төрөл бүрийн чиглэлд хэрэгжүүлсэн 6 төслийг судалсан. Судлаачдын ашигласан төслүүдийг сонгосон элементүүд нь улс орны онцлог, нөхцөл байдлаас хамаарахгүйгээр бүх төсөлд түгээмэл давтагдах шалгуур шинжүүд байсан учраас хөндлөнгийн үнэлгээний хүрээний суурь болгож авсан. МУНЭХБ төсөлтэй төстэйгээр, 10 аймгийн дэд төсөл хэрэгжүүлэгчид нийгмийн эгэх хариуцлагыг орон нутгийн түвшинд засаглал, шийдвэр гаргах үйл явц, төрийн үйлчилгээг хүргэх байнгын институцижсэн (хэрэгжүүлэх байгууллага, бодлого, хэрэгжүүлэх механизм бий болсон байх) арга зүй болгохоор зорьсон. Иймээс А. Веттерберг, Д.В.Бринкерхофф, Ж.С. Хертц нарын судалсан 6 төслийн

хэрэгжилтийн үнэлгээгээр гарч ирсэн элементүүд нь дэд төслийн хэрэгжилтийн үйл явцыг үнэлэх болон төслийн үр дүнг хэмжихэд адилхан шалгуур болж тавигдсан.

А. Веттерберг, Д.В.Бринкерхофф нар нийгмийн эгэх хариуцлагыг сонгогчдын саналын хайрцагас илүү иргэд төрд хариуцлага тооцох олон тооны үйл ажиллагаа, механизмын цогц гэж тайлбарласан. Тэд мөн цааш нь тайлбарлахдаа нийгмийн эгэх хариуцлага нь иргэдийг төртэй харьцах боломжийг бий болгодог ба энэ нь сайн засаглалыг бий болгоход хувь нэмрээ оруулдаг бөгөөд ардчилсан үнэт зүйлсэд нөлөөлдөг гэж үзсэн.

Хэрэглээний талаас нийгмийн эгэх хариуцлага нь зорилгод хүргэх хэрэгсэл юм. Олон улсын хөгжлийн салбар нийгмийн эгэх хариуцлагыг иргэд өөрсдийн хэрэгцээ, үзэл бодлоо илэрхийлэх иргэдийн төртэй харилцах болон төрийн албан хаагчид өөрсдийн хийсэн сонголт болон үйлдэлдээ хариуцлага хүлээх үйл явцын нийлбэр гэж үздэг.

Нийгмийн эгэх хариуцлагын талаар олон улсын хөгжлийн салбарын хандлагыг харгалзан үнэлгээний хүрээнд нийгмийн эгэх хариуцлагыг макро болон микро нөхцөл байдлын хүчин зүйлсээс ихээхэн хамааралтай байхаар авч үзсэн. Эдгээр хүчин зүйлсэд түүх, үйл явц, нийгэм-улс төрийн бүтэц, боломжит нөөцүүд болон чадавхи зэргийг авч үзсэн.

Хэдийгээр эдгээр хүчин зүйлсээр нөхцөл байдал хязгаарлагдахгүй байж болох боловч нь эдгээр нь нийгмийн эгэх хариуцлагын санаачлага, үр дүнг тодорхойлж, тогтвортой байдлыг хангахад нөлөө үзүүлдэг байна.

Иймээс нийгмийн эгэх хариуцлагыг эрэлт (иргэд, ИНБ) болон нийлүүлэлтийн (төр, төрийн байгууллага) хоёр талд хэрэгжүүлэх нь стратегийн хувьд ач холбогдолтой гэж үзсэн. Нийлүүлэлтийн талд төрийн чадавхи, хариу үйлдэл үзүүлэх байдлыг авч үздэг бол эрэлтийн талд нийгмийн эгэх хариуцлагыг шаардах, хэрэгжүүлж буй иргэдийн чадавхийг авч үздэг байна (А. Веттерберг, Д.В.Бринкерхофф, 9-р бүлэг: Салбаруудын нийгмийн эгэх хариуцлагын практик: 6 кэйсийн үр дүн, 2016). Энэ нь иргэдийн оролцоог бодитой, боломжтой болгохоос гадна төрөөс иргэд өөрсдийн хэрэгцээ, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг бий болгох, төрөөс үүнд нь хариу үйлдэл үзүүлэх орчин бий болгох хоорондоо хамааралтай, паралель үйл ажиллагааны тухай юм.

Эрэлт болон нийлүүлэлтийн талд хэрэгжих нийгмийн эгэх хариуцлагын зарим жишээнээс дурьдвал гүйцэтгэлийн үнэлгээний болон хяналт үнэлгээний механизмууд, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах хороо, оролцоот төлөвлөлтийн үйл явц болон нөлөөллийн сургалтууд зэрэг юм.


А. Веттерберг, Д.В.Бринкерхофф нар нийгмийн эгэх хариуцлагын үр дүнг 1. засаглал 2. чадавхжуулах 3. төрийн үйлчилгээ гэсэн хүрээнд үнэлж тодорхойлсон. Судлаачид засаглалыг тодорхойлохдоо төр болон иргэдийн хоорондын харилцаа гэж авч үзсэн ба дараах жишээгээр засаглалын үр дүнг тодорхойлсон: (а) иргэдийг төрийн үйл ажиллагаанд оролцуулж буй механизмууд; (б) иргэдийн санаа тавьж буй асуудалд хариу үйлдэл үзүүлэх байдал нэмэгдсэн; (в) төр болон иргэдийн хоорондох харилцаа сайжирсан (г) төрийн гүйцэтгэл сайжирсан; болон (д) эмзэг бүлгийн иргэдийн эрх болон хамгаалалт хүчтэй болсон;

Чадавхжуулах хүрээнд дараах үр дүнгүүдийг тодорхойлсон: (а) иргэд шинэ боломжуудыг ашиглан дуу хоолойгоо илэрхийлэх боломжтой болох; (б) төрийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжтой болох; болон (в) иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи бэхжих зэрэг юм.

Төрийн үйлчилгээний хүргэлтэд дараах бодит үр дүн гарна гэж үзсэн. Үүнд: (а) орон нутгийн онцлогт тохирсон байдлаар төрийн үйлчилгээ хүргэх үйл явц сайжирсан (б) төрийн үйлчилгээний хүргэлтийг сайжруулах бодлого руу шилжсэн; болон (в) салбарын үр дүн сайжирсан талаархи баримтууд.

Үнэлгээний хүрээний эцсийн бүрдэл

хэсэг нь тогтвортой байдал бөгөөд энэ нь төсөл дууссаны дараа орон нутгийн оролцогч талууд нийгмийн эгэх хариуцлагын санаачлагыг үргэлжлүүлэх үйл явц гэж А. Веттерберг, Д.В.Бринкерхофф, Ж.С. Хертц нар тодорхойлсон. Тогтвортой байдлын жишээ нь (а) төрийн хариу үйлдэл үзүүлэх үйл явцын харагдах байдал; (б) хариу үйлдэл хийх төрийн нөөц (в) нийгмийн эгэх хариуцлагад үзүүлэх улс төрийн дэмжлэг; болон (г) төрийн үйлчилгээний талаар төрийн үүрэг, иргэдийн талаарх хандлага.



↓
ҮР ДҮНГҮҮД

Засаглал	Чадавхжуулах	Төрийн үйлчилгээ
<ul style="list-style-type: none"> • Иргэдийг төрийн үйл ажиллагаанд оролцуулж буй механизмууд; • Иргэдийн санаа тавьж буй асуудалд хариу үйлдэл үзүүлэх байдал нэмэгдсэн; • Төр болон иргэдийн хоорондох харилцаа сайжирсан 	<ul style="list-style-type: none"> • Иргэд шинэ боломжуудыг ашиглан дуу хоолойгоо илэрхийлэх боломжтой болох; • Төрийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжтой болох; • Иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи бэхжих 	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн онцлогт тохирсон байдлаар төрийн үйлчилгээ хүргэх үйл явц сайжирсан • Төрийн үйлчилгээг сайжруулах бодлого руу шилжсэн; • Салбарын үр дүн сайжирсан талаарх баримтууд

↓
ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

- төрийн хариу үйлдэл үзүүлэх байдал
- хариу үйлдэл хийх төрийн нөөц
- нийгмийн эгэх хариуцлагад үзүүлэх улс төрийн дэмжлэг
- төрийн үйлчилгээний талаар төрийн үүрэг, иргэдийн талаарх хандлага

Хөндлөнгийн үнэлгээний хүрээг өөрсдийн онцлогт дараах байдлаар тааруулсан:

Аргачлал

Хөндлөнгийн үнэлгээ нь тайлбарлах болон таамаглах байдлаар боловсруулагдсан. Тус үнэлгээ нь дэд төслийн бодит гүйцэтгэлийг баримтжуулах, дэд төсөл нь анхны төслийн баримт бичигт төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэхийг тодорхойлохоор зорьсон.

Мөн түүнчлэн нийгмийн эгэх хариуцлагын санаачлагыг үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлэхэд саад болж буй бэрхшээл, хүчин зүйлсийг тодорхойлохоос гадна дэд төслийн хүрээнд болон МУНЭХБ төслийн хүрээнд түгээн дэлгэрүүлэх, өргөжүүлэн хэрэгжүүлэх боломжтой дэд төслүүдийг олж тодорхойлох зорилготой байв.

МУНЭХБ төслийн дэд төслийн тэтгэлэг хүртэгчдийн (аймгууд) бүх төлөөллийг хөндлөнгийн үнэлгээнд оролцуулахаар төлөвлөсөн боловч өгөгдөл цуглуулах явцад оролцогчдыг сонгох болон ярилцлага хийх явцад зөвхөн тухайн үед судалгаанд оролцох боломжтой оролцогч талуудыг хамруулсан (жишээ нь боломжит түүвэрлэлт).

Аймгууд	Ажилласан өдрүүд/Ярилцлагууд	Байгууллагууд/Судалгаанд оролцогчид
Увс	2017 оны 9-р сарын 4-5	Орон нутгийн ТББ-ын зохицуулагч болон Иргэдийн хяналтын бүлгийн гишүүд АНЭ-ийн чанарын хэлтэс Аймгийн ЭМГ Аймгийн ЗДТГ
Ховд	2017 оны 9-р сарын 5-6	Сургуулийн захирал, Мянгад сумын ЗДТГ-ын дарга АБГ Аймгийн төвийн сумын сургуулийн захирал, Сайн дурын эцэг эхчүүдийн бүлэг, багш нар Орон нутгийн ТББ, төсөл хэрэгжүүлэгч (Бодлогын бүлэг) Аймгийн НБХ
Сэлэнгэ	2017 оны 9-р сарын 8	Сэлэнгэ аймгийн ИНБ-уудын сүлжээ Аймгийн НБХ Аймгийн ЭМГ АНЭ
Сүхбаатар	2017 оны 9-р сарын 11	Сүхбаатар аймгийн ИНБ-уудын сүлжээ Аймгийн ЗДТГ Баруун-Урт сумын ЗДТГ Аймгийн ЭМГ АНЭ
Хэнтий	2017 оны 9-р сарын 12	Орон нутгийн ТББ-ын зохицуулагч болон ИНБ-ын төлөөллүүд ӨЭМТ Аймгийн ЭМГ
Говьсүмбэр	2017 оны 9-р сарын 18	Орон нутгийн ТББ-ын зохицуулагч Аймгийн НБХ Аймгийн ЭМГ

Уг үнэлгээний хүрээнд үндэсний ТББ болон орон нутгийн ТББ-ын хамтрагчид болон орон нутгийн төсөл хэрэгжүүлэгч дараах 3 гол төлөөллөөс ярилцлага авах байв:

- Орон нутгийн засаг, захиргаа (аймаг болон сумын түвшний, боломжтой байвал)
- ТББ-ын зохицуулагч болон иргэдийн хяналтын (мониторингийн) бүлгийн гишүүд
- Үйлчилгээ үзүүлэгчид (Сургууль, эмнэлгүүд)

Дэд төслийн үнэлгээний мэдээлэл, өгөгдлийг нүүр тулсан ярилцлага, төслийн оролцогч талуудын уулзалт, цаг хугацаа болон замын бэрхшээлээс шалтгаалан очиж амжаагүй аймгуудаас утсаар ярилцлага хийх зэрэг хэлбэрээр цуглуулсан. Судалгаанд оролцогчдод Дэлхийн банкнаас имэйлээр мэдэгдэж, ярилцлагын орчуулгыг дотоодын зөвлөх Г.Пүрэвтогтох болон бусад орчуулагчид гүйцэтгэсэн.

Нүүр тулсан ярилцлага болон бүлгийн ярилцлагыг дараах төслийн аймгуудад гүйцэтгэсэн.

Утасны ярилцлагыг дараах аймгийн төлөөлөлтэй хийв.

Өвөрхангай	2017 оны 9-р сарын 14	Аймгийн НБХ Аймгийн БГ Сумын сургуулийн захирал Орон нутгийн ТББ-ын зохицуулагч
Дорнод	2017 оны 9-р сарын 14	Аймгийн НБХ АНЭ Орон нутгийн ТББ-ын зохицуулагч
Хөвсгөл	2017 оны 9-р сарын 16	Аймгийн ЗДТГ-ын хяналт, шинжилгээ- үнэлгээний хэлтэс Аймгийн НБХ ӨЭМТ АНЭ Орон нутгийн ТББ-ын зохицуулагч
Говь-Алтай	2017 оны 9-р сарын 16	Орон нутгийн ТББ-ын зохицуулагч АБГ

Эцэст нь үндэсний ТББ-уудтай төслийн өөрчлөлтийн онол, орон нутгийн хамтрагч байгууллагуудад тэдний үзүүлсэн дэмжлэгийг тодруулах зорилгоор фокус бүлгийн ярилцлагыг хийсэн.

2017 оны 9-р сарын 15-нд болсон уулзалтад Транспэйрэнси Интернэшнэл Монголиа, Бүх нийт боловсролын төлөө! үндэсний эвсэл, Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг, Монфемнет, БХАН зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцсон. Ардчиллын боловсрол төв ТББ-тай 2017 оны 9-р сарын 17-нд уулзав.

ХОЁРДУГААР

ХЭСЭГ:

МУНЭХБ

ТӨСӨЛ БОЛОН
АЙМГИЙН ДЭД

ТӨСЛҮҮД

Төслийн хүрээнд тавьсан зорилтуудыг биелүүлэх, өмнө хэрэгжсэн нийгмийн эгэх хариуцлагын чиглэлийн төслүүдийн туршлага дээр үндэслэн МУНЭХБ төсөл нь орон нутгийн дэд төсөл хэрэгжүүлэгчдийн нийгмийн эгэх хариуцлагын чадавхийг бэхжүүлэх, орон нутгийн иргэдийн бүлгийн тулгамдсан асуудлаа хамтдаа шийдвэрлэх сонирхол, ойлголт, чадавхийг сайжруулах ингэснээр сайн засаглалыг бий болгон иргэдийг чадавхжуулж төрийн үйлчилгээг сайжруулах, эдгээрийн үр дүнг ядуу иргэдэд түлхүү хүртээх зорилгоор орон нутгийн түвшинд оролцогч талуудтай түлхүү хамтран ажилласан.

Энэ зорилгын хүрээнд 10 аймгийн дэд төслийг орон нутгийн засаг захиргаа, төрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай (эрүүл мэнд, боловсролын салбарт) үр дүнтэй хамтын ажиллагаа бий болгох боломжийг бүрдүүлэх, тэдний чадавхийг бэхжүүлэх, санхүүжүүлэх, техникийн дэмжлэг үзүүлэх зорилгоор сонгосон.

Энэ хүрээнд МУНЭХБ төслөөс хэрэгжүүлсэн гол ажлууд:

1. Олон улсын болон үндэсний сургалтын байгууллагатай (ANSA болон Удирдлагын Академитай хамтран) хамтран нийгмийн эгэх хариуцлагын сертификатын сургалтын загварыг боловсруулж хэрэгжүүлсэн.
2. Эрүүл мэнд, боловсролын салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нийгмийн эгэх хариуцлагын механизм болон санаачлагыг хэрэгжүүлэх тэтгэлэгийг олгосон.
3. Үндэсний ТББ-уудаас зөвлөн туслах болон техникийн дэмжлэгийг үзүүлсэн.

Дэд төсөл хэрэгжүүлэгчдэд зориулсан сургалт

Дэд төсөл хэрэгжүүлэхээс өмнө, 26 үндэсний ТББ-ын төлөөлөл, 10 орон нутгийн ТББ-ын төлөөлөл, 10 орон нутгийн төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн нийт 46 хүнийг нийгмийн эгэх хариуцлагын 3 өдрийн сургалтад хамруулсан.

Тус сургалтын загварыг

ANSA-EAP болон Удирдлагын Академи хамтран боловсруулж хэрэгжүүлсэн бөгөөд сургалтын зорилго нь “эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг сайжруулахын тулд орон нутгийн төрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх нийгмийн эгэх хариуцлагын арга, хэрэгслийг өөрийн

онцлогт тохируулан тодорхойлох, ялгаж ойлгох, сонгох” оролцогчдын чадавхийг бэхжүүлэх байв.

Сургалтын үеэр нийгмийн эгэх хариуцлагын ойлголт болон дэд төсөлд хэрэгжүүлж болохуйц төрийн санхүүгийн арга хэрэгслийн талаар оролцогчдод мэдлэг олгосон юм.

Уг сургалт нь МУНЭХБ төслийн чадавхи бэхжүүлэх ажлын хүрээнд үндэсний болон орон нутгийн ИНБ-ын нийгмийн эгэх хариуцлагын санаачлагыг хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх зорилготой байв.

Нийгмийн эгэх хариуцлагын сургалтын гол сэдвүүд (2016 оны 10-р сар)

- Төр болон ИНБ-тай ажиллах туршлага
- Нийгмийн эгэх хариуцлага нь сайн засаглалд хүргэх аргачлал болох нь
- Нийгмийн эгэх хариуцлагын арга, хэрэгслүүд
- Аймгийн дэд төсөлд хэрэглэж болох нийгмийн эгэх хариуцлагын хэрэгслүүд

Дэд төслүүд

МУНЭХБ төсөл эхлэх үеэр төслийн тэргүүлэх чиглэл болох ядуурлын түвшин, нийгмийн эгэх хариуцлагыг хэрэгжүүлэх бэлэн байдал, эрүүл мэнд болон боловсролын үзүүлэлт зэргийг шалгуур болгон 10 аймгийг сонгосон байна. Эдгээр нь Дорнод, Говь-Алтай, Говьсүмбэр, Хэнтий, Ховд, Хөвсгөл, Сэлэнгэ, Сүхбаатар, Увс, Өвөрхангай зэрэг аймгууд юм. Эдгээр аймгуудын оролцогч талууд нь хэд хэдэн чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаанд хамрагдсаны үр дүнд нийгмийн эгэх хариуцлагын санаачлагын загвар боловсруулах, хэрэгжүүлэх боломжтой болсон. Дэд төслийн сэдвийг тодорхойлохдоо удирдамжид заасны дагуу энэ нь орон нутгийн тулгамдсан асуудал буюу орон нутгийн хэрэгцээнд нийцсэн асуудал байх ба эдгээр асуудлаар оролцогч талууд харилцан зөвшилцөлд хүрсэн байх нөхцлүүд байв. Аймгийн оролцогч талуудтай уулзаж дэд төсөл хэрэгжилтийн явцад зөвлөн туслах үндэсний ТББ-ыг өөрсдийн саналаар сонгох боломжийг олгосон юм.

Арван дэд төслийн 7 нь эрүүл мэндийн салбарт үлдсэн 3 нь боловсролын салбарт хэрэгжсэн. Ихэнхи төслүүд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлж дүгнэлт өгөхдөө ИОК-ын аргачлал (4 төсөл); БХАН-

ийн боловсруулсан “олон нийтийн оролцоот сургууль” загвар (2 төсөл); оролцогч талуудын сэтгэл ханамжийг хууль тогтоомж, бодлогын хүрээнд тавьсан стандартаар (худалдан авах ажиллагаа болон анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээн дээр); нэг төсөл гуравдагч талын буюу хөндлөнгийн үнэлгээгээр; 1 төсөл БНБТ эвслийн боловсруулсан “сайн сургууль” зэрэг аргачлалыг ашигласан.

Нийгмийн эгэх хариуцлагын аргачлалын хувьд нийт дэд төслүүд ерөнхийдөө эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлуудад, тэр дундаа сүрьеэ, амны хөндийн эрүүл мэнд, түр оршин суугчдын үйлчилгээний чанар, хүртээмжид илүү нарийвчлан чиглэж олон талт оролцогч талуудын хамтын ажиллагаагаар дамжуулан үнэлгээ хийсэн. Үнэлгээний үр дүнг цуглуулж нэгтгэн шийдвэр гаргагчид, үйлчилгээ үзүүлэгчдэд төрийн үйлчилгээг сайжруулах төлөвлөгөө боловсруулах болон арга хэмжээ авах үндэслэл болохоор танилцуулсан байна. Дийлэнх үйлчилгээ сайжруулах төлөвлөгөөг ИНБ-ын шууд оролцоотойгоор боловсруулсан (5 төсөл) ба 4 төслийн хувьд төрийн үйлчилгээ үзүүлэгчид давамгайлсан ИНБ-ын зарим саналыг тусган боловсруулжээ. Нэг төслийн хувьд худалдан авах ажиллагааны төлөвлөлт болон гэрээний хэрэгжилтэд иргэдийн төлөөлөл оролцох байдлаар худалдан авах ажиллагааны үйл явцыг сайжруулахад чиглэсэн.

Дэд төслүүдийн товч танилцуулгыг үзүүлвэл:

Салбар	Аймаг	Арга, хэрэгсэл	Арга зүй
Эрүүл мэнд	Дорнод	ИОК	Оролцоот үнэлгээ, үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө
Боловсрол	Говь-Алтай	Сайн сургууль загвар	Оролцоот үнэлгээ ба төлөвлөлт
Эрүүл мэнд	Говьсүмбэр	ИОК	Оролцоот үнэлгээ, үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө
Эрүүл мэнд	Хэнтий	ӨЭМТ стандарт, хяналтын хуудас, иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа	Оролцоот үнэлгээ, хамтарсан үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө
Боловсрол	Ховд	Олон нийтийн оролцоот сургуулийн загвар	Бодлогын шинжилгээ, оролцоот үнэлгээ, (сургуулийн түвшний) оролцоот төлөвлөлт
Эрүүл мэнд	Хөвсгөл	3-дагч талын хяналт, үнэлгээ	Оролцоот үнэлгээ, үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө
Эрүүл мэнд	Сэлэнгэ	ИОК	Оролцоот үнэлгээ, хамтарсан үйлчилгээ сайжруулах төлөвлөгөөний төлөвлөлт
Эрүүл мэнд	Сүхбаатар	ИОК	Оролцоот үнэлгээ, үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө
Эрүүл мэнд	Увс	Худалдан авах ажиллагааны хяналтын хуудас/Гэрээ, иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа	Оролцоот худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хяналт, үнэлгээ
Боловсрол	Өвөрхангай	Олон нийтийн оролцоот сургуулийн загвар	Оролцоот үнэлгээ, хамтарсан (сургуулийн түвшний) төлөвлөлт

Дэд төслүүд нь Улаанбаатарт төвтэй үндэсний ТББ-ын техникийн дэмжлэг, зөвлөмжийн үр дүнд хэрэгжсэн болно. Ардчиллын боловсрол төв нь Дорнод, Сэлэнгэ, Сүхбаатар аймгуудад ажилласан бол БХАН нь Өвөрхангай, Ховд аймгуудад, МНЭМН нь Хөвсгөл, Говьсүмбэрт, Монфемнет байгууллага нь Хэнтий аймагт, Транспэйрэнси Интернэшнэл Монголиа Увс аймагт ажилласан бол БНБТ эвсэл Гов-Алтай аймагт тус тус ажиллажээ.

ГУРАВДУГААР

ХЭСЭГ:

ДЭД

ТӨСЛИЙН

ҮНЭЛТЭЭ

Нэгдүгээр хэсэгт дурьдсаны дагуу энэ бүлэгт нийгмийн эгэх хариуцлагын элементүүдийн (үр дүнгүүдийн) дагуу дэд төслийн хэрэгжилтийг үнэлэн баримтжуулав.

Дэд төсөл бүр гурван үндсэн хэсгээс бүрдэнэ:

- Төлөвлөсөн үр дүн, зорилго (төслийн анхны баримт бичигт төлөвлөсний дагуу) болон одоогийн бодит гүйцэтгэл;
- Нийгмийн эгэх хариуцлагын санаачлагын дагуу богино болон дунд хугацаанд дэд төслийн хүрсэн үр дүн (Нийгмийн эгэх хариуцлагын механизм, Засаглал, Иргэдийг чадавхжуулах, Төрийн Үйлчилгээ, Тогтвортой байдлын үр дүнгүүд);
- Боломж, давуу талуудын үнэлгээ – сайжруулах зөвлөмж;

ДОРНОД АЙМАГ: ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДЭД ХҮРГЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ НЬ ТӨСӨЛ

Дорнод аймаг “Эмзэг бүлгийн иргэдэд хүргэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах” дэд төслийг “Ардчиллын боловсрол төв” (ДЕМО) ТББ-ын дэмжлэгээр хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн ИНБ-ын эвсэлтэй хамтран тус дэд төсөл нь эмзэг бүлгийн иргэдэд хүргэж буй эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах зорилго тавьжээ.

Төслийн зорилтот бүлэг нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжгүй Дорнод аймгийн төвийн 1,2,8-р багийн 2922 ядуу иргэд байв.

Дорнод аймаг нь 76,500 хүнтэй буюу 22,900 өрхтэй, эдгээрийн 56,8% нь аймгийн төвд, 11,5% нь сумын төвд, 31,7% нь хөдөө амьдардаг байна.


Дорнод аймаг нь дундаж наслалт хамгийн багатай аймгуудын нэг бөгөөд иргэний бүртгэлийн бичиг баримт дутуу, байнгын хаяггүй, ядуу зэргээс шалтгаалан эмзэг бүлгийн иргэд эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүйтэй холбоотойгоор

ядуу иргэдийн нас баралтын түвшин өндөр байдаг байна.

Дэд төслийн хүрээнд эрүүл мэндийн төвүүдөөс хүргэж буй эрүүл мэндийн үйлчилгээний хүргэлт, илтөд байдлыг үнэлэх замаар эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт тавьсан. Ингэхдээ ИОК-ын судалгааны үр дүнд суурилан төрийн үйлчилгээний байгууллага хамаарал бүхий оролцогч талуудын хамтаар нэн ядуу, ядуу болон эмзэг бүлгийн иргэдэд эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх “Үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө” боловсруулахаар төлөвлөсөн. Төсөл эхэлсэний дараа орон нутгийн ИНБ-ын эвсэл Аймгийн ЗДТГ-тай Харилцан Ойлголцлын Санамж бичиг байгуулсан ба санамж бичгийн дагуу 12 иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, 8 иргэн, ИНБ-ын эвслийн 3 гишүүн, ЗДТГ, НБХ, АЗМГ, Нийгмийн даатгал, Бүсийн Эмчилгээ, Оношлогооны төвийн (БЭОТ) холбогдох албан

тушаалтнууд, Аймгийн ИТХ-ын НБД-ын бүрэлдэхүүнтэй төсөл хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдсан.

Төсөл эхлэх үеэс ИНБ-ын эвсэл Нийгмийн Халамжийн хэлтэс болон Нийгмийн даатгалын хэлтсээс гаргаж өгсөн эмзэг бүлгийн иргэдийн талаар маш сайн мэдээлэлтэй байсан боловч эдгээр иргэд наад захын эрүүл мэндийн үйлчилгээг хүртэх боломжгүй байдгаас гадна иргэд эмнэлэгт үзүүлэх цаг авахын тулд дор хаяж 3-4 удаа очдог, цаг авсны дараа эмчид үзүүлэхээр олон цаг хүлээдэг талаар олж мэдсэн.



Төслийн баг дэд төслийг эрүүл мэндийн үйлчилгээний хүргэлт, чанар, хүртээмжийг сайжруулах болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд иргэдийн оролцоог хангах боломж гэж үзсэн. Харин орон нутгийн засаг захиргааны зүгээс дэд төслийн хүрээнд 219 иргэнийг эрүүл мэндийн даатгалд хамруулах тодорхой зорилт тавьсан.

Дээр дурьдсан зорилтуудад хүрэхийн тулд дэд төсөл дараах гол ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. ДЕМО ТББ-аас 40 иргэнд 3 өдрийн ИОК-ын арга зүйн сургалт зохион байгуулсан. Сургалтын сүүлийн өдөр иргэд хууль эрх зүйн орчныг судалж, ИОК ашиглан үнэлгээ хийх гол асуудлуудыг тодорхойлсон ба нийгмийн даатгал бодит байдал дээр хэрхэн хэрэгждэг талаар судлахаар ажлаа эхэлсэн.
2. Төслийн оролцогч талуудтай тохиролцсоны дагуу, ИОК-ын судалгаа нь иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртэхтэй холбоотой хүндрэл бэрхшээл болон эрүүл мэндийн ажилтны өвчтөнтэй харилцаж буй ёс зүй, хандлагад чиглэсэн. Судалгааны хүрээнд 5 гол асуудлыг авч үзсэн. Үүнд: 1.Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй, хандлага; 2.Эмнэлгийн ажилтны ажлын ачаалал; 3. Нийгмийн

эрүүл мэндийн боловсрол; 4. Эмнэлгийн цаг авах үйлчилгээ; 5. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт; Тус судалгааг 2 өрхийн эрүүл мэндийн төв (ӨЭМТ) болон БЗОТ дээр хийсэн байна.

3. ИОК-ын судалгаанд 112 эмч, эмнэлгийн ажилтан, Багийн Засаг даргын ажлын албанаас тодорхойлсон 234 эмзэг бүлгийн иргэд хамрагдсан.
4. ИОК-ын дүнг хэлэлцэх, “Үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө” боловсруулах нүүр тулсан уулзалтыг зохион байгуулсан. БЗОТ/АНЭ нийт ажилтнуудад зориулан мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулсан ба эмнэлгийн захиралтай хамтран үйл ажиллагааны төлөвлөгөөг удирдамжийн дагуу боловсруулсан.
5. 3 сарын “үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд ИОК-ын судалгаа болон нүүр туулсан уулзалтын үеэр хэлэлцэгдсэн асуудлууд шийдвэрлэгдсэн. Онцлох ажлуудыг дурьдвал:

Төрийн үйлчилгээний байгууллагын зүгээс (БЗОТ/АНЭ): Эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын ачааллыг багасгах дүрэм, журамд өөрчлөлт

оруулсан ба өвчтөнд цаг товлох үйлчилгээг хөнгөвчилсөн. Үйлчлүүлэгчдэд зориулсан цаг товлох 2 утас, эрүүл мэндийн үйлчилгээ, үйлчилгээний журмын талаарх мэдээллийг иргэдэд хүргэсэн. Зөвлөх эмч нар ажлын өдрүүдийн аль нэгд өөрийн хариуцсан тасаг, хэлтэст үзлэг, оношилгоо хийхээр болсон ба хөдөөгийн иргэдэд цаг товлохгүйгээр үзлэг хийхээр болсон.

Энэ шинэ системийг нэвтрүүлсэнээр 1450 иргэнд эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн ба эрүүл мэндийн ажилтны ёс зүйг дээшлүүлэхийн тулд Үндэсний эрүүл мэндийн хөгжлийн төвөөс багш урьж авчирч ажилчдад сургалт зохион байгуулсан.

Дэд төслийн богино, дунд хугацааны үр дүн

Тайлангийн эхний хэсэгт дурьдсаны дагуу дэд төсөл тус бүрийн нийгмийн эгэх хариуцлагын үр дүнгүүдийг бий болгоход оруулсан хувь нэмрийг үнэлэн баримтжуулсан байдлыг үзүүлвэл:

1. Төрийн байгууллагын эрэлт, нийлүүлэлт, хариуцан тайлагналтыг сайжруулахад чиглэсэн НЭХ-ын үйл ажиллагааг төлөвлөсөн байдал

Иргэд болон үйлчилгээ үзүүлэгч хоёр тал ИОК-ын судалгаанд хамрагдсанаар эрүүл мэндийн үйлчилгээг хүргэхэд тулгарч буй бэрхшээлийг ялангуяа эрүүл мэндийн ажилтны ёс зүй болон хандлагын талаарх хоёр талын ялгаатай хандлагыг тодорхойлсон.

Талуудын ялгаатай хандлага, ИОК-д өгсөн үнэлгээний оноог тооцохгүйгээр оролцогч талууд ИОК-ын судалгааны үр дүнд өөрсдийн саналыг илэрхийлсэн явдал нь нүүр тулсан уулзалт дээр өрнөсөн хэлэлцүүлгийн эхлэл болсон.

ИОК-ын тусгай шалгуур үзүүлэлт болон үнэлгээний хүрээ нь хэлэлцүүлэг зохион байгуулах болон эрүүл мэндийн ажилтны ёс зүй, ажлын ачаалал, цаг товлох, эрүүл мэндийн боловсрол, нийгмийн даатгалын системийн талаар

хамтарсан үйл ажиллагаа төлөвлөх хэмжүүр болсон.

Орон нутгийн засаг захиргаа, үйлчилгээний байгууллага, ИНБ-ын эвслийн төлөөл нийт 52 хүн 3 сар хэрэгжүүлэх “үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө”-г боловсруулсан. Тус төлөвлөгөөнд 25 төрлийн үйл ажиллагааг хариуцах байгууллагын хамт тодорхойлсон.

2. Орон нутгийн засаглал, иргэдийг чадавхжуулах, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажил

Засаглал: Аймгийн нийгмийн даатгалын хэлтэс эмзэг бүлгийн 148 иргэнийг нийгмийн даатгалд хамруулан төрийн үйлчилгээний талаар мэдээллийг хүргэсэн. Төрийн албан хаагчид төрийн үйлчилгээг зөвхөн төрийн хариуцах ажил биш бөгөөд иргэний оролцоо нь [үйлчилгээтэй холбоотой] асуудлыг хамтран тодорхойлох, шийдвэрлэх гарцыг хамтдаа хайх, [хамтран] хэрэгжүүлэх, мэдээллийг дээрээс доош чиглэлд иргэдэд хүргэх суваг гэдгийг ойлгосон. Нийгмийн бодлогын хэлтэс нь дэд төслийн хүрээнд төрийн үйлчилгээний хүргэлттэй холбоотой зөрчил, дутагдал, гомдолд анхаарлаа хандуулсан. ИНБ-ын хамтрагч байгууллагатай хамтран ажиллаж тэднийг сонссоноор “иргэдийн хэрэгцээнд нийцсэн бодлого хөтөлбөрийг боловсруулах” боломжийг бий болгосон.

Төрийн талаас хариуцсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулах үүрэг бүхий аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс, сумын ЗДТГ-ын төлөөлөл бүхий 7 хүний бүрэлдэхүүнтэй (байнгын бус) ажлын хэсгийг байгуулсан.

Чадавхжуулах: Дэд төслийн хүрээнд тус тусын зорилго, чиглэл бүхийн 8 ТББ нийгмийн эгэх хариуцлагыг сайжруулах зорилгоор нэгдэн хамтран ажилласан. Төрийн байгууллага эдгээр ИНБ-ын эвсэл, эвслийн гишүүн ТББ-уудыг төрийн ажлыг гүйцэтгэх чадавхитай хамтрагчид гэж үнэлсэн ба нийгмийн бодлогын хэлтсийн ажилтан тэднийг “төрийн албан хаагчдаас илүүтэйгээр бодит амьдралд тулгамдсан асуудлыг олж харах боломжтой” гэж үнэлжээ.

ИНБ-ын сүлжээний гишүүдээс 1 гишүүн нь судалгааны арга зүй болон судалгааны ажлын зарим туршлагатай байсан ба ИОК нь бүх гишүүдийн хувьд шинэ зүйл байв. Үндэсний хамтрагч ДЕМО ТББ-ын онцолсноор төсөл хэрэгжүүлэгчид арга зүйг хурдан хугацаанд эзэмшиж, харилцааны ур чадварын давуу талаа ашиглан орон нутгийн төрийн албан хаагчид болон үйлчилгээний байгууллагатай үр дүнтэй хамтран ажиллаж чадсан.

ИНБ-ын гишүүд нь иргэдэд 1. эрүүл мэндийн үйлчилгээний стандартууд (жишээ нь өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нэн тэргүүнд үйлчилгээг хүртэх талаар) 2. Нийгмийн даатгалын хамрах хүрээ, нийгмийн даатгалын сангаас

(Бодит түүвэр) Иргэдийн үнэлгээ, зөвлөмж

(Үйлчилгээг үзүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхээс өмнөх асуулгын судалгааны үр дүн)

Үнэлгээний талбар	Үнэлгээ
Эрүүл мэндийн боловсрол олгох үйлчилгээ	35.5 (Ядуу)
Харилцаа Эмч нарын ёс зүй	39.4 (Ядуу)
Цаг товлох үйлчилгээ	31.9 (Ядуу)

Зөвлөмж:

- Олон нийтэд зориулсан сургалтыг сард нэг удаа сонирхолтой хэлбэрээр зохион байгуулах
- Орон нутгийн телевизороор эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөр цацах
- Эмч, сувилагч нарт зориулан НСС сургалт зохион байгуулах
- Тогтмол үнэлгээг хийх

үйлчлүүлэгч өөрөөс төлсөн зардлыг нөхөн төлүүлэх тухай хууль эрх зүйн баримт бичиг, дүрэм журмын талаарх иргэдийн ойлголтыг сайжруулах аргыг ашигласан. Иргэний нийгмийн байгууллагын зөвлөлийн гишүүд аливаа тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлох, тэдгээрийн шийдлийг эрэлхийлэх төрийн үйл ажиллагаанд оролцоо чухал болохыг ухаарч ойлгосон байна.

Үйлчилгээ үзүүлэх: Эхний үнэлгээний дараа хоёр асуудал дээр үйлчилгээ үзүүлэгчдийн өөрсдийгөө үнэлсэн онооноос доогуур үнэлгээг иргэд өгсөн байсан. Иргэд эмчийн үзлэгийн цаг авах болон эмнэлгийн ажилтны ёс зүйн талаар сэтгэл ханамжгүй байсан.

БЭОТ-ийн холбогдох албан тушаалтнууд ИОК-ын судалгаагаар гарч ирсэн асуудлуудыг шийдвэрлэх талаар тодорхой алхам, арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Хэдийгээр иргэд, ИНБ-уудыг “үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө”-г боловсруулахад оролцуулаагүй боловч тэдний саналыг асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааны хүрээг тодорхойлоход ашигласан ба хоёрдахь удаагийн үнэлгээгээр эдгээр асуудлууд дээр иргэд өндөр үнэлгээг өгсөн (иргэдийн сэтгэл ханамж 35.6%-с 54% хүртэл нэмэгдсэн). Энэ хүрээнд дараахь ажлуудыг гүйцэтгэсэн:

- Иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний талаарх санал хүсэлтийг тэмдэглэх санал, хүсэлтийн дэвтрийг эмнэлэг дээр байршуулсан;
- Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, хандлагыг сайжруулахад чиглэсэн сургалтуудыг зохион байгуулсан;
- Эрүүл мэндийн үйлчилгээний хүргэлтийг сайжруулах журам боловсруулсан ба иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээний талаарх

мэдээллийг хүргэх механизм бий болгосон;

- Эмзэг бүлгийн иргэдэд хүргэх эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх нээлттэй өдөрлөгийг зохион байгуулсан;
- Шүдний тоног төхөөрөмж, нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох болон ахмад настны хүлээлгийн өрөөг тохижуулах санхүүжилтийг шийдвэрлэсэн;

3. Тогтвортой байдлыг хангах механизм.

Аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулдаг хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанаас гадна төрийн үйлчилгээний байгууллагаас жилд нэг удаа хөндлөнгийн үнэлгээг хийж байхаар шийдвэр гарсан. Тус үнэлгээг ямар эх үүсвэрээр санхүүжүүлэх нь одоогоор тодорхойгүй байгаа боловч аймгийн ОНХС-н санхүүжүүлэлтээр шийдвэрлэхээр тусган саналыг ИТХ-д өргөн барьсан.

Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсээс ИНБ-ын мониторинг/хяналт-шинжилгээг одоогийн дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоонд нэвтрүүлэх, 2018 оны төсөвт тусгах асуудлыг судлаж байна. Ярилцлага хийх явцад энэ талаар тодорхой шийдвэр гараагүй байсан болно.

Үнэлгээ, зөвлөмж

Орон нутгийн ТББ-ын сүлжээ нь орон нутгийн удирдлага, үйлчилгээний байгууллагатай сайн харилцаатай байж [үр дүнтэй] хамтран ажиллаж чадсаныг энд тэмдэглэх нь зүйтэй. Хэдийгээр ИОК-ын арга зүй, технологиор дамжуулан нийгмийн эгэх хариуцлагыг хэрэгжүүлэх нь тэдний хувьд шинэ зүйл байсан боловч тэд ИОК-ын судалгааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн. Хэдий сайн зүйлс олон одоогоор байгаа ч нийгмийн эгэх хариуцлагыг ирээдүйд илүү үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах асуудлыг шийдвэрлэж ажиллах нь чухал юм:

- Нийгмийн эгэх хариуцлагын талаарх онол болон аргачлал нь харьцангуй шинэ ойлголт боловч орон нутгийн ИНБ-ыг зөвхөн аргачлал, бэлтгэсэн асуулга, хэрэгслийг хүлээн авагч/хэрэглэгч талаас биш тэднийг аргачлалыг өөрсдөө бие даан боловсруулдаг оролцогч болгох талаар үндэсний ТББ-ын зүгээс технологийг дамжуулах нь чухал юм. Мөн орон нутгийн ИНБ-уудын хувьд НЭХ-ын талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх, бусад туршлагаас суралцах хэрэгцээ ажиглагдлаа.
- “Үйлчилгээг сайжруулах төлөвлөгөө”-нд тусгагдсан ихэнхи ажлууд нь эмнэлгийн (үйлчилгээний байгууллагын)

хариуцан хэрэгжүүлэх ажлууд байсан бөгөөд эдгээр ажлууд нь бараг бүхэлдээ эмнэлгийн ажилтны ёс зүй, хандлагыг сайжруулахад чиглэсэн байсан.

- ЗДТГ-ын санаачлан байгуулсан салбар дундын ажлын хэсэг нь үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулах үүрэгтэй байсан боловч 148 иргэнийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын талаар хууль тогтоомжийг таниулах, сурталчлахаас өөрөөр үйлчилгээний чанарыг сайжруулах талаар барьцтай, тогтвортой ажлыг холбогдох байгууллагууд хэрхэн хийх талаар тодорхойлоогүй.
- Иргэдийн хяналтыг одоогийн (хяналт-шинжилгээ, үнэлгээний/институцийн) тогтолцоонд нэвтрүүлэх саналтай хэдий ч энэ талаар тодорхой зорилго, хэмжүүрийг тодорхойлоогүй байгаа бөгөөд иргэдийн хяналтыг зөвхөн одоо хэрэгжиж буй хөтөлбөр, төрийн үйлчилгээний талаар мэдээлэл түгээх аргачлал гэж харахаас хэтрэхгүй, нийгмийн эгэх хариуцлагын талаар болон нийгмийн эгэх хариуцлагын засаглалыг сайжруулахад оруулж буй хувь нэмрийн талаар гүнзгий ойлголт хараахан бүрдээгүй байна.

Дорнод аймгийн оролцогч талууд нийгмийн эгэх хариуцлагын санаачлагын тогтвортой байдлыг цаашид хангахад дараах зөвлөмжүүдийг хүргүүлж байна:

- НЭХ-ын арга хэрэгслийн хэрэглээ болон боловсруулалтад орон нутгийн ИНБ-ыг оролцуулан, хариуцуулан ажиллуулснаар орон нутгийн оролцогч талууд цаашид төрийн бусад хөтөлбөр, үйлчилгээнд иргэдийн хяналт үнэлгээг хийх бүрэн чадамж, итгэлтэй болох юм. Цаг хугацаа болон нөөцийн хувьд маш шахуу байсныг ойлгож болох боловч нийгмийн эгэх хариуцлагын талаар илүү туршлагатай байгууллагын (жишээ нь УБ хотод байршилтай эсвэл хамтарсан байгууллагуудаар) зөвлөгөө, удирдамжийн дагуу асуулгыг орон нутгийн оролцогч талууд өөрсдөө ашигласан арга хэрэгслээ боловсруулсан бол илүү тустай үйл явц болох байжээ.
- Иргэдийн оролцоо болон нийгмийн эгэх хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэрэгсэл болохынхоо хувьд ИОК нь өөрийн сул болон давуу талуудтай. Оролцогч талууд эхлээд төрийн үйлчилгээ үзүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа өнөөгийн нөхцөл байдлаа судлан, тулгамдаж байгаа асуудлаа тодорхойлоод түүний дараа тухайн асуудалтай шууд уялдах тохиромжтой аргыг авч ашигласан бол илүү үр дүнд хүрэх байжээ. Иргэдийн онооны картын арга төрийн үйлчилгээ, хөтөлбөрийн талаарх санал бодлыг тандахад тустай ч энэ аргыг хэрэглэхдээ эх олонлогийг төлөөлөх түүврийн хэмжээг зөв тодорхойлох нь

хэрэгцээгүй зардлыг багасган, тулгамдаж байгаа асуудлыг энгийн аргаар түргэн шуурхай тодорхойлох боломжтой байдаг. Дэд төсөл нь нийгмийн даатгалд бүртгэлгүй байдлаасаа хамааран иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртэж чадахгүй байна гэсэн үндсэн асуудалд анхаарал хандуулж байсан. Тиймээс нийгмийн аудит (иргэдийн онооны картын арга нь ч бай)-ын арга хэрэгсэл ашиглан даатгалд хамрагдахгүй байгаа иргэдээ тодорхойлоод дараа нь тухайн иргэдийг даатгалд хамруулах талаар холбогдох байгууллагуудтай ярилцах хэрэгтэй байжээ. Дорнод аймгийн дэд төслийн хувьд эрүүл мэндийн даатгалд хамрагдах шаардлагатай 260 эмзэг бүлгийн иргэдийг тодорхойлохын тулд

(төслийн үр дүнд 148 иргэнийг нийгмийн /ЭМД/ даатгалд хамруулсан) тулд шаардлагагүй үйл ажиллагаа, зардал гаргажээ (жишээ нь ИОК-н судалгаанд 1120 хүнийг хамруулсан гэх мэт).

- Иргэдийн санал хүсэлтийг тодорхойлох, тусгах арга механизмыг одоогийн [хяналт-шинжилгээ, үнэлгээний/институцийн] тогтолцоонд дараагийн санхүүгийн жилээс нэвтрүүлэх санаачилгад анхаарал хандуулах нь чухал. Ингэхдээ энэ санаачлагыг илүү албан ёсны, системчилсэн хэлбэрээр, мөн ИНБ-ын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг илүү тодорхой болгосноор өнөөгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоонд нэвтрүүлэх боломжтой юм.

Дорнод аймгийн нэгдсэн үнэлгээ

Нийгмийн эгэх хариуцлагын механизм	Үр дүн			Тогтвортой байдал
	Засаглал	Чадавхжуулах	Төрийн үйлчилгээ	
✓ X	✓	✓ X	✓	✓
Эрүүл мэндийн даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэхийг тулд бусад нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслийг ашиглах (жишээ нь нийгмийн аудит)				

ГОВЬСҮМБЭР АЙМАГ: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ХЭНИЙГ Ч ОРХИГДУУЛАХГҮЙ БАЙХ НЬ ТӨСӨЛ

Говьсүмбэр аймаг дэд төслийг Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгийн (МНЭМН) дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн. ИОК-ын аргачлалаар эрүүл мэндийн ажилтнуудын ёс зүй, хандлага, зан үйлийн талаар иргэдээс судалгаа авч эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл мэндийн ажилтны талаарх иргэдийн сэтгэл ханамжгүй байдлыг шийдвэрлэх зорилготой тус төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, шатлал хооронд өвчтөн шилжүүлэх тогтолцоог сайжруулах үндсэн зорилтуудыг тавьсан.

Аймгийн нэгдсэн эмнэлэг (АНЭ), сумын эрүүл мэндийн төвүүд, өрхийн эрүүл мэндийн төвөөр (ӨЗМТ) үйлчлүүлэгч иргэд урьдчилан цаг авахгүйгээр аймгийн нэгдсэн эмнэлгээр үзүүлэх, зөвлөгөө авах 2009 оны 307-р журмыг хэрэгжилтийг дэмжих зорилгоор иргэдийн саналыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор ашигласан.



Дэд төслийг дэмжигчдийн зүгээс Говьсүмбэр аймгийн иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар мэдээлэл дутмаг, эрүүл мэндийн санхүүжилт бага, эрүүл мэндийн үйлчилгээнд иргэдийн оролцоо бага зэрэг шалтгаанаас хамааралтайгаар шаардлагатай иргэд эрүүл мэндийн үйлчилгээг авч чаддаггүй гэж үзсэн.

Эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж зохих стандартын шаардлага хангахгүй байгаа олон

шалтгаан байгаа боловч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудлыг оролцогч талууд гол асуудал гэж тодорхойлсон. Учир нь иргэд үзлэгийн цаг авахад үүсдэг хүндрэл, эмнэлгийн ажилтны таагүй харилцаа, иргэдийн сэтгэл ханамжгүй байдлыг судлан үйл ажиллагаагаа сайжруулдаггүй, ажлын өндөр ачааллаас үүдэлтэй стресс, дарамтыг өвчтөнд гаргах гэх мэт хүндрэлийг биеэр мэдэрч туулдаг байна.

Төсөл эхлэх үеэр эрүүл мэндийн ажилтнууд иргэдийн үнэлгээний дүгнэлтийг эсэргүүцсэн боловч яваандаа зорилготой, зохион байгуулалттай үйл явцын үр дүнд иргэдээс гарсан санал болох эмзэг бүлгийн иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх, иргэдэд ТББ-р дамжуулан зохион байгуулалттай, хамтарсан эрүүл мэндийн мэдээллийг түгээх шаардлагатай зэргийг ойлгосон.

Дэд төслийг АЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан ба ажлын хэсгийг ахалсан. Тус аймагт ИНБ-ын эвсэл албан ёсоор хараахан бий болоогүй боловч тус дэд төслийг орон нутгийн 4 ТББ хамтран хэрэгжүүлсэн. Аймгийн ЗД-ын захирамжаар төсөл хэрэгжүүлэх ажлын хэсгийг ЗДТГ, АЭМГ, ӨЭМТ, ТББ, иргэдийн төлөөлөлтэй байгуулсан. ИОК-ын судалгаагаар гарсан эрүүл мэндийн ажилтны ёс зүйг сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд ажлын хэсгээс дараах гол ажлуудыг зохион байгуулсан:

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид тулгамдсан асуудлыг тодорхойлох уулзалтыг орон нутгийн иргэдтэй хийсэн. 2 удаагийн уулзалтын үр дүнд орон нутгийн байгууллагууд, төрийн албан хаагчдын саналаар дэд төслийн хүрээг нарийвчлан тодорхойлсон.
2. МУНЭХБ төслийн хамтрагч байгууллага болох Ардчиллын боловсрол төв (ДЕМО) ТББ-ыг урьж ИОК-ын арга зүйн сургалтыг зохион байгуулсан.
3. Хоёр судалгааны баг ажиллуулсан. Эхний баг АНЭ дээр нөгөө баг ӨЭМТ дээр ажилласан. АНЭ дээр эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй, зан үйл, мэргэжлийн үр чадвар, эрүүл мэндийн үйлчилгээ,

хөтөлбөрийн талаар мэдээллийн хүртээмж, хүний нөөцийн хангамж, үзлэгийн цаг авахад зарцуулж буй хугацаа зэргийг үнэлсэн. ӨЭМТ дээр эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй, зан үйл, харилцаа хандлага, хүний нөөцийн хангамж, шатлал хооронд өвчтөн шилжүүлэх тогтолцоо зэргийг үнэлсэн. Нийт 1800 иргэд судалгаанд хамрагдсанаас 1003 нь АНЭ-г, 797 нь ӨЭМТ-г үнэлсэн ба нийт эмнэлгийн ажилчдын 37,6 хувь нь судалгаанд оролцсон байна.

4. “Үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө” боловсруулах нүүр тулсан уулзалтад АЗДТГ, АЭМГ, иргэд, ТББ-ын төлөөлөл 25 хүн оролцсон.
5. “Үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө”-нд тусгагдсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн. Орон нутгийн ТББ-с эмнэлгийн ажилчдын ёс зүй, зан хандлагыг өөрчлөх, дэд төслийн хэрэгжилтэд тэдний дэмжлэгийг авахын тулд хариу талархлын арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. АЭМГ-ын зүгээс иргэд өөрийн биеэр оочерлож цаг авахгүйгээр эмнэлгийн үзлэг, оношлогооны цаг авах боломжтой цахим бүртгэлийн системийг нэвтрүүлсэн ба харилцагч, өвчтөнүүдэд чиглэсэн үйлчилгээ, эмнэлгийн ажилтны ёс зүй зэрэг цуврал сургалтуудыг нийт ажилтнуудад зохион байгуулсан.

Дэд төслийн богино, дунд хугацааны үр дүн

Тайлангийн эхний хэсэгт дурьдсаны дагуу дэд төсөл тус бүрийн нийгмийн эгэх хариуцлагын үр дүнг бий болгоход оруулсан хувь нэмрийг үнэлэн баримтжуулсан байдлыг үзүүлвэл:

1. Төрийн байгууллагын эрэлт, нийлүүлэлт, хариуцан тайлагналтыг сайжруулахад чиглэсэн НЭХ-ын үйл ажиллагааг төлөвлөсөн байдал

Төсөл хэрэгжиж эхлэх үеэс төслийн баг төслийн зорилго болон эрүүл мэндийн үйлчилгээг хүргэхэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлоход иргэдийг оролцуулахад анхаарч ажилласан. Аймгийн ЗД-ын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд иргэд, ИНБ-ын оролцоог хангахад ач холбогдол өгч тэдний оролцоог хангаж ажилласнаас гадна ЗДТГ, ЭМГ, ӨЭМТ-н холбогдох албан тушаалтны төлөөллийг хангасан.

ИОК-ын судалгаанд иргэдийн оролцоог хангахыг ихэд чухалчилсан ба судалгаанд зорилтот эмзэг бүлгийн иргэд, ядуу иргэдийн оролцоо өндөр байсан. Ажлын хэсгийн баталсан үнэлгээний шалгуур үзүүлэлт, бүрдэл бүхий 5 асуудлын хүрээнд эрүүл мэндийн

үйлчилгээг иргэд болон үйлчилгээ үзүүлэгчид (0-100 оноогоор) үнэлсэн. Эдгээр 5 үнэлгээний хүрээ нь: эрүүл мэндийн ажилтнуудын ёс зүй, зан үйл, мэргэжлийн ур чадвар, эрүүл мэндийн үйлчилгээ болон засгийн газраас хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөрийн талаар мэдээллийн хүртээмж, эрүүл мэндийн үйлчилгээг авахад зарцуулж буй цаг, шатлал хооронд өвчтөн шилжүүлэх тогтолцоо (ӨЗМТ-д хамааралтай) зэрэг болно.

Судалгаанд оролцогч иргэд бүх асуултуудад “сайжруулах шаардлагатай” гэж хариулсан нь үйлчилгээ үзүүлэгчдийн өөрсдийн үнэлгээнээс бага байв. (жишээ нь эрүүл мэндийн ажилтны ёс зүй дээр үйлчилгээ үзүүлэгчид 100-с 87 оноог өөрсөддөө өгсөн бол иргэд 41 оноо өгсөн байв.)

“Үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө” боловсруулахад орон нутгийн ТББ-ын төлөөлөл, АЗДТГ, АЭМГ, АНЭ-ийн удирдлагууд оролцсон. Төлөвлөгөөнд 8 гол ажил төлөвлөсөн ба үүнд: ёс зүйн хороо байгуулах, эмнэлгийн ажилтны хандлага, зан авирыг сайжруулах сургалтуудыг зохион байгуулах, хүний нөөцийн хангамжийг сайжруулах (байнгын үйлчлүүлэгчдээс гадна түр оршин суугчдад эмнэлгийн тусламж үйлчилгээ хүргэх) зэрэг багтсан.

2. Орон нутгийн засаглал, иргэдийг чадавхжуулах, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажил

Засаглал: Нийгмийн бодлогын хэлтсээр дамжуулан АЗДТГ төслийн

үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж нүүр тулсан уулзалтад идэвхитэй оролцсон. “Үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө”-ний дагуу АЭМГ болон АНЭ-ын хариуцан хэрэгжүүлэх үйл ажиллагааны биелэлтэд хяналт тавих үүргийг АЗДТГ хүлээсэн.

Нүүр тулсан уулзалт, хэлэлцүүлгүүдийн үеэр эмнэлэгт тулгамдсан асуудлуудын нэгээр зүрх судасны кабинеттэй болох асуудал байсан ба АЗДТГ-аас уг асуудлыг шийдвэрлэхийн тулд олон улсын донор байгууллагуудаас санхүүжилт хүссэн боловч амжилтгүй болсон. Тус кабинетийн өртөг нь орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх боломжгүй өндөр өртөгтэй учраас ЗДТГ-с ирэх оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулсан ба 2018 оны орон нутгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, орон нутгийн төсөвт мөн адил тусгахаар төлөвлөсөн байна.

Нийгмийн бодлогын хэлтэс нь ИОК/иргэдийн хяналт үнэлгээний талаар тодорхой ойлголттой болсон гэж үзэж байгаа бөгөөд өөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаандаа ИОК-н арга зүйг оруулахаар журмын төсөл боловсруулж аймгийн ИТХ-д батлуулахаар өргөн барьсан.

Чадавхжуулах: МУНЭХБ төсөл хэрэгжихээс өмнө Говьсүмбэр аймгийн ТББ-ууд нь хамтарч ажилласан туршлага байхгүй байсан. Төслийг хэрэгжүүлэгч ТББ нь бусад олон улсын байгууллагууд

болох ГОУХАН (GIZ), Мерси Кор гэх мэт байгууллагуудын төслийг хэрэгжүүлж байсан туршлагатай боловч засаглалын чиглэлээр бусад ТББ-уудтай хамтарч ажиллаж байсан туршлагагүй байв. ТББ-ын зохицуулагчийн дүгнэснээр орон нутгийн засаг захиргааг иргэдийн өмнө хариуцлага хүлээдэг болгох зорилгын үүднээс орон нутгийн ТББ-ууд нь дэд төслийн хүрээнд хамтарч ажиллах шаардлагатай болсон байна.

Төрийн үйлчилгээ: Говьсүмбэр аймгийн эрүүл мэндийн үйлчилгээг хүргэхэд тулгарч буй олон хүндрэл бэрхшээлүүдээс орон нутгийн оролцогч талууд (засаг захиргаа, ТББ-ууд) эмнэлгийн ажилтнуудын ёс зүйн асуудлыг гол асуудал болгон тодорхойлж үнэлгээ хийн санал зөвлөмж боловсруулсан.

АЭМГ-н зүгээс эрүүл мэндийн ажилтнуудын ёс зүйн асуудал нь цаг хугацаа шаардсан, мөн зарим суурь асуудлуудыг (нэмж эмнэлгийн ажилтнуудыг ажилд авах, цалинжуулах зэргээс гадна нийгмийн даатгалтай холбоотой асуудлууд гэх мэт) шийдвэрлэж байж сайжирна гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Хэдий байдал ийм байгаа боловч дэд төслийн хүрээнд нүүр тулсан уулзалтууд, ёс зүйн сургалтуудыг хийсний дараа 5 сарын дараа явагдсан хоёрдахь үнэлгээгээр судалгаанд оролцогчид өндөр үнэлгээ өгсөн байна.

Мөн түүнчлэн өнөөгийн байдлаар иргэдийн өгсөн үнэлгээ болон

үйлчилгээ үзүүлэгчдийн өгсөн үнэлгээний хооронд бага зөрүү гарсан гэж тэмдэглэсэн. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин энэ судалгаагаар тодорхой болсоноос гадна санал гомдол, хүсэлтийн тоо буурсан үзүүлэлттэй байна.

“Үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө”-нд тусгагдсан бүх ажлууд хараахан хэрэгжиж амжаагүй боловч тодорхой алхмууд хийгдсэн ба үүний нэг нь цахим бүртгэлийн систем юм. Энэ системээр ӨЭМТ-с АНЭ-т үзлэгийн цаг авах боломжтой болсон. АНЭ дээр байгуулагдсан ёс зүйн хороо нь ёс зүйн зөрчил гаргасан эрүүл мэндийн ажилтантай хариуцлага тооцох журмын төслийг боловсруулсан байна. Үйлчлүүлэгчиддээ бүрэн анхаарал тавьж үйлчлэхийн тулд ӨЭМТ-ын дарга ажлын цагаар нийгмийн сүлжээ ашиглахыг хориглож интернэт холболтыг түр хориглох аргаа хэмжээ авч ажилласан байна. Ёс зүйн салбар хороо нь дүрмийн дагуу ажилласнаар эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлагыг өөрчлөх, соён гэгээрүүлэх арга хэмжээг тасралтгүй хийх боломж нөхцөлөөр хангагдана.

Тус хороо нь 2018 оноос эхлэн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээ ёс зүйн хэм хэмжээг зөрчих зөрчлөөс урьчилан сэргийлэх, зөрчлийг арилгуулах зэрэг арга хэмжээг тасралтгүй хийх боломжтой болсон.

3. Тогтвортой байдлыг хангах механизм.

Орон нутгийн ТББ-уудын хувьд орон нутгийн захиргаа, төрд хүргэх санал боловсруулах, дуу хоолойгоо хүргэхэд чадавхиа улам сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Эрүүл мэндийн үйлчилгээний хүргэлтийг үнэлэхэд тэд өөрсдийгөө эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд биш, мөн эрүүл мэндийн салбарын талаар өөрсдийгөө мэдээлэл дутуу гэж үнэлэн эргэлзэж байсан. Гэвч тэд өмнө нь ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийн дэд төсөл хэрэгжүүлж байсан учраас орон нутгийн захиргаатай ажлын харилцаа тогтоон иргэдийн хяналт-шинжилгээний талаар өөрсдийгөө таниулах боломжтой байсан.

Цаашид (орон нутгийн засаг захиргаанаас) ОНХС-ийн төлөвлөлт, төсөв, гүйцэтгэлд иргэдийн оролцоог ханган (орон нутгийн ТББ-тай хамтрах) хүсэл эрмэлзэл байгаа болно.

Аймгийн ЗДТГ-ын зүгээс дэд төслийн тогтвортой байдлыг хангахын тулд 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний эрүүл мэндийн хөгжлийн хөтөлбөрт иргэдийн хяналт, үнэлгээг тусгах боломжийг судлаж байна.

АНЭ-ийн хувьд өмнө нь дотоод үнэлгээний үр дүнг олон нийтэд танилцуулдаггүй байсан ба учир нь уг ажлыг эмнэлгийн дотоод журмын нэг хэсэг гэж үзэж байсан.

Нийгмийн бодлогын хэлтсээс бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийг чухал оролцогч тал гэж хүлээн зөвшөөрөн аймгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд жил бүр хөндлөнгийн мониторинг/хяналт-шинжлгээ хийлгэх, үр дүнг олон нийтэд болон аймгийн ИТХ-д танилцуулснаар бодлого боловсруулах болон шийдвэр гаргах явцад иргэдийн саналыг тусгах боломжтой гэж дүгнэж байна.

ӨЭМТ-ийн хувьд ИОК-ыг өрхийн эмнэлгийн түвшинд ашиглах, орон нутгийн ТББ-р өрхийн эмнэлгийн үйлчилгээг жилд 2 удаа үнэлүүлэх ба үнэлгээний үр дүнг олон нийтэд тайлагнах сонирхолтой байв.

Үнэлгээ, зөвлөмжүүд

Дэд төслийн оролцогч талууд Говьсүмбэр аймгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгамдсан олон суурь асуудлаас илүүгээр эрүүл мэндийн ажилтны ёс зүй, хандлагын асуудалд анхаарч уг асуудлыг шийдэхийн тулд тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласан.

Орон нутгийн удирдлага иргэдийн оролцоог ханган тэдний саналыг авах байдлаар асуудалд өнгөц хандаснаар эрүүл мэндийн үйлчилгээний хүргэлтэд стратегийн шийдэл олоогүй байна.

ЭМГ-ын холбогдох ажилтнуудтай

хийсэн ярилцлагын үеэр яагаад эрүүл мэндийн ажилтнууд өвчтөнүүдтэй харилцахдаа сөрөг зан үйл гаргадаг талаарх суурь шалтгааныг тэд ойлгож байсан.

АНЭ болон ӨЭМТ нь орон тооны дутагдалтай, санхүүжилт багатай, ажлын ачаалал ихтэй зэрэг нь эмнэлгийн ажилтны сөрөг зан үйлийг зөвтгөх шалтгаан биш боловч эдгээр шалтгааны улмаас эмнэлгийн ажилтнууд ажлын стрессээ өвчтөнд гаргаж тэдэнд үзүүлэх ёстой үйлчилгээгээ үзүүлдэггүй байна.

Нийгмийн эгэх хариуцлагыг цаашид үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах асуудлуудыг шийдвэрлэж ажиллах шаардлагатай:

- Засаглалын үйл явцад стратегийн шийдэл шаардсан аль ч салбарт асуудлыг шийдвэрлэх зорилго, аргачлалыг тодорхой болгох, иргэдийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамжгүй байдлыг шийдэх зорилгоор өнгөцхөн, түр зуурын шийдэл гаргахгүй байх.

Сайн дурын ажилтнуудыг зохион байгуулж ажиллуулах, томоохон судалгааг гүйцэтгэх, өгөгдөл цуглуулах, боловсруулах болон дүгнэлтийг танилцуулах, оролцогч талын саналыг тусгах зэрэг ажлууд нь техникийн мэдлэг, ур чадвар шаардахаас гадна хөрөнгө мөнгөний ихээхэн нөөцийг шаарддаг. ЭМГ-ын зүгээс АНЭ болон ӨЭМТ-ийн ажилтнуудын ёс зүй, хандлагын асуудал нь эрүүл

мэндийн салбарын томоохон суурь асуудлыг хөндөж байгаа гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Оролцогч талууд иргэдийг илүү стратегийн ач холбогдолтой, цогц асуудлыг шийдвэрлэхэд оролцуулахын тулд ОНХС-ын төлөвлөлт болон хэрэгжүүлэлтэд тэдний оролцоог хангаж ажиллахаас эхлэх нь чухал. Учир нь эдгээр ТББ-ууд нь энэ чиглэлээр ажиллах сонирхолтой бөгөөд иргэдийн саналыг авах техникийн ур чадвартай.

- Иргэдийн үүрэг, иргэдийн саналыг засаглал болон шийдвэр гаргах үйл ажиллагаанд тусгаснаар нийгмийн эгэх хариуцлагын санаачлага хэрэгждэг. Бүтээлч хамтын ажиллагааны хүрээнд иргэд болон төр өөрсдийгөө зөвхөн мэдээлэл дамжуулагч, түгээгч төдий гэж харахгүйгээр шийдвэр гаргахад оролцогч, хөтөлбөрийг

хэрэгжүүлэгч талууд гэж харах нь зүйтэй.

- Говьсүмбэр аймгийн хувьд төслийн цаашдын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн иргэдийн оролцоот хяналт үнэлгээний механизм нь бүх оролцогч талуудын хувьд санал нэгдсэн үнэт зүйл хараахан болж амжаагүй байна.

ТББ-ууд өөрсдийн ур чадварыг төрийн үйлчилгээ, хөтөлбөрийг үнэлэхэд хангалтгүй гэж харж байгаа бол харин төрийн зүгээс ТББ-уудыг мэдээлэл түгээх хэрэгсэл гэж харж байна. Үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд иргэд эмнэлгийн ажилтнуудад тулгамдсан асуудлыг ойлгосноор гомдол бага гаргана гэж үзэн дэд төслийг эмнэлгийн ажилтнууд болон иргэдийн хоорондын зайг багасгах арга хэрэгсэл гэж үзсэн.

Говьсүмбэр аймгийн нэгдсэн үнэлгээ

Нийгмийн эгэх хариуцлагын механизм	Үр дүн			Тогтвортой байдал
	Засаглал	Чадавхжуулах	Төрийн үйлчилгээ	
✓ X	✓ X	✓ X	✓	✓ X
Нийгмийн эгэх хариуцлагын талаарх ойлголт, чадавхийг гүнзгийрүүлэх				

ХЭНТИЙ АЙМАГ: ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТ ХЯНАЛТЫН МЕХАНИЗМЫГ НЭВТРҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ

Хэнтий аймагт анхан шатны эрүүл мэндийн тусламжийг бусад аймгуудын адил Өрхийн эрүүл мэндийн төвөөр (ӨЭМТ) дамжин үзүүлдэг бөгөөд эдгээр нь төрийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх хувийн, сайн дурын эрүүл мэндийн байгууллагууд юм. Үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээнд аймгийн Засаг дарга болон Эрүүл мэндийн газрын даргын гарын үсэг зурснаар баталгааждаг. Энэхүү гэрээнд гүйцэтгэлийн үнэлгээний тухай заалтууд орсон байх боловч тэдгээр нь бусад оролцогч талуудын санал,

дүгнэлтийг тусгаагүй байх бөгөөд уг гэрээг “ёс төдий” шинэчилсээр явдаг байна. Дэд төслийн хүрээнд хоёр ӨЭМТ-тэй хамтран ажилласан (эхнийх нь хүн ам ихтэй аймгийн төвд үйлчилдэг, хоёрдах нь аймгийн төвөөс алслагдмал ядуу иргэдэд үйлчилдэг) байна.

Хэнтийн дэд төсөл нь ӨЭМТ-ийн гүйцэтгэлийн үнэлгээнд гуравдагч талын хяналтын механизмыг нэвтрүүлснээр эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чанар болон хүртээмжийг сайжруулахыг зорьсон юм.

Эрүүл мэндийн яамнаас баталсан стандарт болон ӨЭМТ-тэй байгуулсан гэрээний заалтуудаас харахад, иргэд нь ӨЭМТ-ийн гүйцэтгэл, тус гэрээг үзэглэсэн хоёр тал болох аймгийн засаг дарга, Эрүүл мэндийн газрын гэрээний үүргийн биелүүлэлтийг үнэлэх эрхтэй байна. Үнэлгээний үр дүнг шинжлэн дүгнэж, ӨЭМТ-тэй байгуулсан гэрээг үнэлэх болон шинэчлэх явцад ашиглаж, мөн

Аймгийн засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд ч бас тусгасан байна.

Хэнтий аймгийн дэд төслийн хэрэгжилтийг нийслэлд үйл ажиллагаа явуулдаг Монфемнет ТББ-ын үндэсний сүлжээнээс удирдан зохион байгуулж, орон нутгийн ТББ, тус дэд төслийн хүрээнд үүсгэн байгуулагдсан мониторингийн багууд, гэрээний хугацаа нь дууссан хоёр (2) ӨЭМТ болон тэдгээрт хамаарах ЗДТГ-тай хамтран ажилласан юм.

Орон нутгийн ИНБ-ын сүлжээ нь 20 идэвхтэй гишүүдтэй ба, үүнээс 9 байгууллага нь хэрэгжилтийн багт сонгогдон, үүн дээр төслийн ӨЭМТ-үүд байрлаж буй багуудаас 10 хүн нэмж орон, нутгийн захиргааны 4 төлөөлөгч багтсан байна. Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, Нийгмийн Бодлогын Хэлтсийн дарга аймгийн Засаг даргыг төлөөлөхөөр сонгогджээ.

Хэнтийн дэд төслийг зураглан харахад...

Анхан шатны эрүүл
мэндийн тусламж
үйлчилгээний чанар,
хүртээмж муу



Гэрээний заалтуудад
нийцүүлэн анхан шатны
эрүүл мэндийн тусламж
үйлчилгээг сайжруулах

Хэрхэн: ӨЭМТ-тэй байгуулсан гэрээний холбогдох талуудын (ӨЭМТ, Аймгийн засаг дарга, ЭМГ) гүйцэтгэлийн үнэлгээнд 3-дагч талын хяналтыг оролцуулах

Хэнтий аймагт хэрэгжсэн МУНЭХБТ-ийн дэд төслөөр дамжуулан орон нутгийн ИНБ-ын сүлжээ нь эрүүл мэндийн үйлчилгээний хүргэлтийг сайжруулах, үйлчилгээ үзүүлэгч хувийн байгууллагуудтай байгуулсан гэрээг хянах үйл явцад иргэдийн оролцоог бэхжүүлэх боломжоор хангагдсан байна. Төслийн хэрэгжилтийн орон нутгийн багийн нэг хэсгийн хувьд, ИНБ-ын сүлжээний зохицуулагч нь төслийн нэлээд хэдэн чухал шийдвэрт хувь нэмэр оруулсан бөгөөд үүнд тухайлбал багийн гишүүдийг сонгох, асуудлыг тодорхойлох ба дэд төслийн төлөвлөлт зэрэгт оролцсон юм.

Тус дэд төслийн хувьд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг дараах арга замаар дамжин сайжруулна гэсэн зорилт тавьсан байна:

- а) ӨЗМТ-ийн гэрээнүүдэд олон нийтийн оролцоот хяналтын механизмыг нэвтрүүлэх (үйлчилгээ үзүүлэгч 4 байгууллагаас 2-г сонгон);
- б) ИНБ-ууд болон иргэдэд мониторинг хийх арга зүйг сургах; мөн
- в) Бүтээлч оролцоогоор дамжуулан ӨЗМТ-ийн ил тод байдал, эгэх хариуцлагыг сайжруулах.

Дээр дурьдсан зорилтуудад хүрэхийн тулд төслийн хэрэгжилтийн ба удирдлагын баг дараах чухал үйл ажиллагаануудыг зохион байгуулсан байна:

1. Гурван талт гэрээний заалтуудын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг хянаж үзэв. Ийнхүү хянасны дараа, гэрээнд нэгэнт заасан байгаа тул олон нийтийн оролцоот хяналтын механизмыг нэвтрүүлэх шийдвэр гарсан. Үүнд Өрхийн эрүүл мэндийн төв, Аймгийн Засаг дарга ба Аймгийн Эрүүл Мэндийн Газар зэрэг гэрээнд оролцогч талуудыг орон нутгийн ТББ-ын түншлэгчдээс зохион байгуулах судалгаагаар дамжуулан үнэлэхийг иргэдээс хүссэн юм. Судалгааны дүнгүүдийг нэгтгэж, эдгээр нь ӨЗМТ-ийн гүйцэтгэлийн нийт үнэлгээний 50% -ийг иргэдийн үнэлгээ бүрдүүлсэн.
2. Иргэдийн оролцоот хяналтыг хэрхэн зохион байгуулах тухай гарын авлага, удирдамжийг боловсруулсан. Энэ ажлын нэг чухал хэсэг бол хамтран ажиллагч Монфемнет ТББ-аас судалгааны дизайныг гаргаж, аргачлалыг боловсруулсан явдал байв. Судалгааны дизайны туршилтыг 40 оролцогчдын дунд туршиж үзсэн байна.
3. Хяналтын багуудыг бий болгож, тэдний чадавхыг бэхжүүлэв.
4. Орон нутагт хэрэгжүүлэгч багийн олон нийтийн оролцоот бүлэг нь орон нутгийн зураглал гаргаснаар эмзэг бүлгийн иргэдийн байршил, шинж чанаруудыг тодорхойлж, ялангуяа түр оршин суугчдыг олж тогтооход тусалсан юм.

Ийнхүү зураглал гаргахын зэрэгцээ оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг авсан бөгөөд энэ нь гурван талт гэрээнд хавсаргасан үнэлгээний аргачлалтай адилхан шалгуур үзүүлэлтүүдтэй байв. Гүйцэтгэлийн гэрээнүүдийг дөнгөж шинэчлэн гарын үсэг зурсан, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг үнэлэх цаг арай болоогүй байсан ч гэсэн эдгээр зүйлсийг хийсэн юм.

5. ӨЗМТ-ийн үзүүлдэг үйлчилгээ/хөтөлбөрүүдээс хамааран иргэдийг таван бүлэгт хуваан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналтыг хэрэгжүүлэв. Эдгээрт: шинээр төрсөн хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, ахмад настнууд, түр оршин суугчид ба эмзэг бүлгийн иргэд багтаж байлаа.
6. Үйлчилгээ/Гүйцэтгэл сайжруулах хамтын ажиллагааны төлөвлөгөөг гаргав.

Дэд төслийн богино, дунд хугацааны үр дүн

Энэхүү тайлангийн 1-р хэсэгт өгүүлсэнчлэн, дэд төсөл бүрийг баримтжуулж, гарсан үр дүнг нь нийгмийн эгэх хариуцлагын үр дүнтэй арга барилыг нэвтрүүлэх хэдэн чухал үзүүлэлтүүдийн дагуу үнэлэн дүгнэсэн юм. Эдгээрийг дараах байдлаар баримтжуулсан болно:

1. Төрийн байгууллагын эрэлт, нийлүүлэлт, хариуцан тайлагналтыг сайжруулахад чиглэсэн НЭХ-ын үйл ажиллагааг төлөвлөсөн байдал

Хамтын ажиллагааны гол хэсэг бол Аймгийн Засаг дарга, Эрүүл Мэндийн Газраас ӨЭМТ-тэй байгуулж буй анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гурван талт гэрээ юм. Орон нутгийн оролцогчид үндэсний түншлэгч Монфемнет ТББ-ын удирдамжтайгаар гэрээний одоогийн заалтууд болон бусад холбогдох хууль журам, Эрүүл Мэндийн яамнаас гаргасан бодлогын баримт бичгүүдийг үзэж хянасан. Үйлчилгээ үзүүлэгч дөрвөн байгууллагаас хоёрыг нь гэрээг сунгах хугацаа болсон байсан учир, тэд тус хоёр гэрээг хянаж, олон нийтийн оролцоот үнэлгээг хийх заалтуудыг тус гэрээнүүдэд оруулж, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хийх аргачлалыг үндсэн гэрээнд хавсралтаар оруулсан юм. Орон нутгийн зураглалыг гаргаж, судалгаа хийснээр хяналтын бүлэг нь ӨЭМТ-ийн үйлчилгээний хүргэлтэнд гарч буй саад бэрхшээлүүдийг тодорхойлж, тэдгээрийг Эрүүл Мэндийн яамнаас гаргасан стандарт, шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулж үзсэн. Судалгааны үр дүнгээс харахад, ӨЭМТ-үүд нь Аймгийн ЗДТГ, ЭМГ, Багийн Засаг дарга ба орон нутгийн ТББ зэрэг холбогдох талуудтай хамтран Үйлчилгээг сайжруулах төлөвлөгөөг гаргасан байна.

Энэ нь ӨЭМТ-үүдэд дараа нь гэрээнд заасанчлан хийгдэх гүйцэтгэлийн үнэлгээн дээрээ илүү дээр оноог авахад туслах байх хэмээн найдаж байна.

2. Дунд хугацааны үр дүн: Иргэд чадавхжих, орон нутгийн засаглал болон эрүүл мэндийн үйлчилгээ сайжрах чиглэлээр гарсан тодорхой үр дүн

Засаглал: Дэд төсөл нь Аймгийн Засаг Дарга ба Аймгийн Эрүүл Мэндийн Газрын бусад асуудлын талаарх эгэх хариуцлага, хариуцлагыг нэмэгдүүлэв. Үүнд тухайлбал гэрээлсэн ӨЭМТ-д дэд бүтэц, тоног төхөөрөмж хангаж өгөх зэрэг багтах бөгөөд ингэснээр төрийн эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулна.

Судалгааны анхны үр дүнг ЗДТГ болон ЭМГ-т танилцуулахад Сум ба Аймгийн захиргааны байгууллагаас асуудлыг шийдвэрлэх тал дээр идэвх зүтгэлтэй ажиллаж эхэлсэн төдийгүй үйлчилгээг сайжруулах төлөвлөгөөнд заасан үүрэг даалгаврыг биелүүлж эхэлсэн байна. Учир нь эдгээр нь хувийн үйлчилгээний байгууллагын эгэх хариуцлагаас хол давсан, төрийн байгууллагын гэрээний үүргүүдтэй холбоотой зүйлс байсан юм. Оролцогч талуудын оролцоог нэн чухалчилж байгаа учраас, Эрүүл Мэндийн Газраас гаргах 2018 оны Аймгийн Засан даргын Үйл Ажиллагааны төлөвлөгөөнд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулахад ИНБ-уудын оролцоог дэмжих, ИНБ-ын хамтын ажиллагааг сайжруулах талаар тодорхой заалтуудыг оруулан, төрийн зарим нэг үүргийг ИНБ-

Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаанаас харахад ӨЭМТ-ийн сайжруулах зүйлс:

- ӨЭМТ зай муутай байдаг учир, өрөөний зохион байгуулалт, хүлээлгийн корридор зэргээ аль болох тав тухтай болгох тал дээр анхаарах хэрэгтэй;
- Эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэхдээ, ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ба тэжээлийн дутагдалтай хүүхдүүдийг тогтмол гэрээр очиж үзэх, гэрийн хяналтанд оруулах нэг өдрийг тусгайлан гарга;
- Урьдчилсан үзлэг, вакцинжуулалтыг өрөөг тохижуул;
- Дуудлагаар явдаг эмч нарын багаж, хэрэгслийг шинэчил;
- Дасгал хөдөлгөөний өрөө нээж, иргэдэд байнга нээлттэй байлга;
- Эмч, сувилагчдын тоог нэм, лабораториор сургагдаж байгаа ажилтнуудыг байнгын ажилд ав;
- Өмнө нь сургагдсан сайн дурын ажиллагсдын чадавхыг бэхжүүлж, цаашид ажиллах урашууллыг өг

ууд болон мэргэжлийн холбоодоор дамжуулан гүйцэтгэхийг зөвшөөрсөн байна.

Аймгийн ЭМГ-ын хувьд иргэдийн хяналт, оролцоо гэдэг нь шинэ нэр томъёо, ойлголт юм. Эрүүл Мэндийн Газрын харъяа байгууллагуудын гүйцэтгэлийг үнэлэхээр иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол явуулдаг ч (улиралд нэг удаа), судалгааны үр дүнгээс хамаараад ямар нэг хариу арга хэмжээ авах эсэх нь тэдний мэдэлд үлддэг. Иргэд болон иргэдийн бүлэг судалгааны дизайныг гаргах, судалгааг хийх болон үр дүнг шинжлэхэд оролцдоггүй ба асуудлыг шийдвэрлэхэд бүр ч оролцоогүй байдаг учир тэдний одоогийн үйл ажиллагаанд эгэх хариуцлага тооцох арга байхгүй юм. Гэвч төслийн үр дүнгээс харахад, тус төслийн загварыг дуурайлгаж, төрийн бусад хөтөлбөр, үйлчилгээнд (ялангуяа эрүүл мэндийн) иргэдийн хяналтыг оруулах сонирхол их байна.

Чадавхжуулах: Орон нутгийн ИНБ-ын зохицуулагчийн ярьж байгаагаар, иргэд ба ялангуяа түр оршин суугчид өрхийн эрүүл мэндийн төв (багийн түвшинд байгаа) ба сумын эрүүл мэндийн төвийн үзүүлж буй үйлчилгээ болон үйлчилгээнүүдийн ялгааны талаар мэдлэггүй байна. Иргэд оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа авах үйл явцад оролцсоноор (цаашид мөн ӨЗМТ-ийн Гүйцэтгэлийн Үнэлгээнд оролцсоноор) үйлчилгээний талаар мэдлэгтэй болж, ӨЗМТ-ийн үзүүлж буй үйлчилгээний түвшин ба чанарын

талаар төрд тайлагнах боломжоор хангагдаж байна. Гурван талт гэрээнд чанарын болон цаг хугацааны талаар шаардлагууд орсон байдаг боловч, иргэд эдгээр шаардлагын талаар мэдээлэлгүй байдгийн улмаас хүлээн авч буй үйлчилгээнийхээ чанарын талаар төрд мэдээлэл өгч чадахгүй байна. Судалгааны үр дүнгээр дамжуулаад иргэд нь олон нийтийн хэрэгцээг хамтдаа тодорхойлж, үйлчилгээг сайжруулах төлөвлөгөөнд хувь нэмэр оруулах боломжоор хангагдаж, нийтийн ашиг тусын тулд ажиллаж чадсан байна.

Дэд төсөлд хамрагдсан иргэдийн бүлгүүд, ИНБ-ууд нь харилцан мэдээлэл солилцохын ашиг тусыг харсан тул цаашид энэхүү арга барилыг АНЭ, нийтийн аж ахуй үйлчилгээ, хог хаягдлын удирдлага болон боловсролын үйлчилгээг үнэлэхэд ашиглахыг хүсч байна. Тэд гэрээлсэн аливаа үйлчилгээний гүйцэтгэлд иргэдийн хяналт чухал гэдгийг харж байна. Тэдний хувьд энэ нь “иргэд өөрсдийнхөө эрхийг мэдэж авах, төрд итгэж эхлэх, иргэд шийдвэр гаргах үйл явцад оролцон, нөлөөлөх боломжоор хангагдахын” эхлэл юм.

Зарим иргэд төрийн гэсэн бүхий л зүйлсэд тун шүүмжлэлтэй хандаж байсан бол, тус үнэлгээнд оролцсон явдал нь төрөөс хэрэгжүүлж буй аливаа хөтөлбөр үр дүнтэй хэрэгжихэд иргэдийн өөрсдийн үүрэг хариуцлага чухал гэдгийг ойлгожээ. Тухайлбал нэг оролцогч, “Улс манай өрхийн эмнэлгийн бүх

асуудлыг шийдвэрлэж чадахгүй юм байна. Бидний өөрсдийн оролцоо маш чухал” гэж хэлсэн байна.

Төрийн үйлчилгээ: Өмнө дурьдсанчлан, олон нийтийн оролцоот механизмыг ӨЗМТ-тэй байгуулдаг гурван талт гэрээг 2017 онд хянаж, хэрэгжүүлэх үеэр оруулсан байна. Хянан засварласан тус гэрээнд үнэлгээний шинэ аргыг нэвтрүүлж, 80 хувиас доош үнэлгээ авсан аливаа зүйлсийг “сайжруулах шаардлагатай” хэмээх ангилалд багтааж, холбогдох талуудыг хариу арга хэмжээ авахыг шаардсан байна. Иргэдийн үнэлгээ нь нийт үнэлгээний 50%-ийг бүрдүүлнэ. ӨЗМТ-ийн хувьд эхний удаагийн үнэлгээгээр эмнэлгийн байр болон үйлчилгээний хувьд сайжруулах ёстой боловч урт хугацааны туршид шийдвэрлээгүй орхиж байсан асуудлуудыг гаргаж ирсэн. Судалгаагаар үр ашигтай мэдээ, мэдээлэл бий болж, үүнээс үүдэн холбогдох талууд Үйлчилгээг сайжруулах төлөвлөгөөгөр дамжуулан асуудлыг шийдвэрлэх гэж оролдсоор байна.

Гол хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд:

- Лабораторын үйлчилгээг сайжруулахын тулд оношилгооны аппаратыг баг болон сумын ОНХС-ийн хөрөнгөөр худалдаж авсан;
- Түр оршин суугчдын авсан үйлчилгээний санхүүжилтийг хангаж өгөх механизмуудыг бий болгох (тэд аймгийн төвд түр оршин сууж байгаа учир тэдгээрийн зардлыг харъяа багаас

нь төлж байх, учир нь тэдний очиж үйлчлүүлж байгаа төвийн ӨЭМТ-үүдэд тэдэнд үйлчлэх зардлыг багтаагаагүй байдаг.); мөн,

- ӨЭМТ-өөр үйлчлүүлж байгаа өвчтөнүүдийн цахим мэдээллийн санг үүсгэх, үүнд түр оршин суугчдын мэдээллийг бас оруулах.

3. Тогтвортой байдлыг хангах механизмын талаар.

Аймгийн Эрүүл Мэндийн Газрын даргын ярьж байгаагаар, ӨЭМТ нь эхлээд иргэдийн хяналтыг төдийлөн таатай хүлээж аваагүй байна. Гэвч тэдэнд иргэдийн хяналт нь гэрээний бусад талуудыг

хариуцлагад дуудсанаар тэдний үйл ажиллагаа, үйлчилгээний хүргэлтийг сайжруулахад туслах юм гэдгийг тайлбарласны үр дүнд төслийг дэмжиж ажиллахад ятгаж чадсан байна. Одооны байдлаар бүх оролцогч талууд (ИНБ, төрийн байгууллагууд, үйлчилгээ үзүүлэгчид) төрөөс санхүүжүүлж байгаа хөтөлбөр, үйлчилгээнүүдийг хянах шаардлагатай гэдгийг мэдэх болсон. Эрүүл Мэндийн Газар нь тус аргачлалыг бусад ӨЭМТ, мөн сумын эрүүл мэндийн төв, үндэсний болон аймгийн түвшинд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдэд ашиглахаар шийдсэн.

Өвчнөөс урьдчилан сэргийлэх ба өвчнийг илрүүлэх ажиллагаа нь

олон нийтийн мэдлэг, мэдээллийг зайлшгүй шаардах тул, иргэдийн оролцоог олон нийтийн эрүүл мэндийн чухал хэсэг хэмээн харж байна. Эрүүл мэндийн газар нь өөрсдийн аймгийн туршлагаас харсан тул, иргэдийн хяналтыг гурван талт гэрээнд багтаах явдлыг дэмжиж, цаашид ч ийм бодлогыг Эрүүл Мэндийн Яаманд санал болгох төлөвтэй байна.

Үнэлгээ, зөвлөмжүүд

Гэрээт үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас дэд төслийг дэмжиж ажилласан тул төсөл нь зорьсон зорилтууддаа хүрч чадсан юм. Гэрээний заалтуудыг сүүлийн арван долоон жилийн турш мөрдөж байгаа боловч туршилтын хоёр ӨЭМТ нь гэрээний нэмэлт өөрчлөлтийг хүлээн авч, хянан засварласан гэрээнүүдэд олон нийтийн оролцоот гүйцэтгэлийн үнэлгээг оруулахыг зөвшөөрчээ.

Үүний зэрэгцээ ӨЭМТ-тэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээ нь өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үнэлгээнд олон нийтийн оролцоог оруулах стратегийн ач холбогдолтой механизм болж, үүнийг хэрэгжүүлэх үүд хаалгыг нээж өгөв.

Гүйцэтгэлийн гэрээ болон үнэлгээнд хамаарах нэг тал болж байгаагийн хувьд, Аймгийн Засаг Дарга болон

Иргэдийн оролцоог ӨЭМТ, төрийн байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээд оруулах заалтуудыг багтаасан шинэчилсэн гэрээ:

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нийгмийн Бодлогын Байнгын Хорооны шийдвэрээр томилогддог Бие Даасан Ажлын Хэсэг гэрээг хагас ба бүтэн жилээр байгуулж; гэрээг сунгах, цуцлах ба гэрээнд өөрчлөлт оруулах талаар шийдвэр гаргаж, батална.
- Бие Даасан Ажлын Хэсэг “ӨЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5292 – 2011, Монгол стандартын шалгуур үзүүлэлт ба шаардлагуудыг баримтлахаас гадна энэхүү Гэрээний 1, 2 дах хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийг дагана:
- ӨЭМТ-ийн үйл ажиллагааг “ӨЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5292 – 2011, Монгол стандартын шалгуур үзүүлэлт ба шаардлагуудын дагуу үнэлнэ;
- 1-р Хавсралтанд заасны дагуу, ОНОХ аргачлалын хүрээнд авсан арга хэмжээнүүд нь “ӨЭМТ-ийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5292 – 2011, Монгол стандартын 5, 6-р зүйлд заасан зарим шалгуур үзүүлэлт ба шаардлагуудад хүрсэн эсэх талаарх иргэдийн хийсэн үнэлгээг хувиар тооцож гаргах;
- 3.3.2-3.3.4 шалгуур үзүүлэлтүүдэд хамаарах нэгдсэн үнэлгээний 50% нь ОНОК-ын хүрээнд багтсан, үйлчилгээ хүлээн авч байгаа иргэдийн төлөөллөөр хийгдсэн үнэлгээ байх болно.

Аймгийн Эрүүл Мэндийн Газраас эгэх хариуцлагыг бас тооцож эхэлсэн бөгөөд үүний хариуд тэдгээр нь Үйлчилгээг сайжруулах хамтын ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх, мөн төр-хувийн хэвшлийн түншлэл шаардлагатай байж болох бусад хөтөлбөрүүдэд ИНБ-уудыг оролцуулахыг явдлыг дэмжсэн юм.

Олон нийтийн оролцоот хяналтын механизмыг нэвтрүүлэх Хэнтий аймгийн туршлагыг төрөөс гэрээлэн үйлчилгээ явуулж буй бусад хувийн байгууллагууд шууд авч ашиглаж болох юм (эрүүл мэнд болон бусад салбаруудад ч байж болно). Хэнтий аймгийн төсөл хэрэгжүүлэгч нар дараах асуудлуудыг шийдвэрлэхэд бас анхаарлаа хандуулж болох юм:

- ИНБ-уудын тэргүүлэгч байгууллага нь олон улсын болон олон талт байгууллагуудтай ажиллаж байсан арвин туршлагатай байж болох юм. Гэсэн хэдий ч, хэрэгжилтийн багт багтаж байгаа бусад байгууллагууд нь тухайн төслийнхөө нөхцөл байдалд илүү уягдаж байгаа юм.

Шинэчлэн засварласан гэрээнүүд нь МУНЭХБ дэд төсөл хэрэгжсэнээс ч хойш ашиглагдсаар байх тул ИНБ-ын сүлжээ нь төр болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас эгэх хариуцлага тооцох арга барилаа арай өөр өнцгөөс, орон нутагт ажиллаж байгаа байгууллагуудынхаа үүднээс харах хэрэгтэй юм шиг санагдаж байна.

- Төслийн удирдах багийнхан төслийн хэрэгжилтийн эхний үед үндэсний ТББ-ын санал болгосон шалгуурын дагуу сайн дурынхныг олж, ажиллуулах нь хүндрэлтэй байна гэсэн санааг илэрхийлж байсан.

Эхлээд судалгаа авах, харилцааны ур чадварыг эзэмшсэн орон нутгийн ИНБ, сайн дурын иргэдийг авч ажиллуулахыг хүсч байснаа, сайн дурынхныг тэдний оролцох хүсэл эрмэлзэл, гаргаж буй зориулалтынх нь үндсэн дээр сонгон авчээ. ИНБ-ын сүлжээ нь цаашид гуравдагч талын үнэлгээг үргэлжлүүлэн тогтвортой хийхийг хүсч байгаа бол нотолгоонд суурилсан оролцоог хангах (жишээ нь судалгаа), баталгаатай мэдээллийг хангаж өгөх чадавхаа бэхжүүлэх хэрэгтэй байна. Магадгүй эхний үед үүнийг үндэсний ТББ-ын зөвлөхүүдийн тусламжтайгаар хийх хэрэгтэй байж болох юм.

- Аймгийн Засаг Даргын Тамгын Газар болон Эрүүл Мэндийн Газарт хангаж өгсөн мэдээллийн дагуу тэдгээр байгууллагаас ямар арга хэмжээ авсан талаар тодорхой мэдээлэл байхгүй байна. Эдгээр нь гурван талт гэрээнд хамаарах талууд учраас үр дүнг илүү нарийн баримтжуулах хэрэгтэй.

- Тус туршлагыг бусад ӨЭМТ-үүд ба Сумын эрүүл мэндийн төвд нэвтрүүлэхийг хүсч байгаа ч гэлээ, иргэдийн оролцооны ашиг тусыг зөвхөн өвчнөөс урьдчилан сэргийлэх ба өвчнийг эрт оношлох талаар олон нийтэд мэдээлэл өгөх, кампанит ажлыг зохион байгуулахад оролцуулах байдлаар л хязгаарлаж байна. Төртэй хамтран ажиллагч байгууллагууд иргэдийн хяналтын ашиг тусыг ухаарч, төрийн бусад асуудлуудад энэ аргыг ашиглаж болох талаар илүү гүнзгий ойлголт авах хэрэгтэй байна.

Хэнтий аймгийн нэгдсэн үнэлгээ

Нийгмийн эгэх хариуцлагын механизм	Үр дүн			Тогтвортой байдал
	Засаглал	Чадавхжуулах	Төрийн үйлчилгээ	
✓	✓	✓ X	✓	✓
ИНБ-ын сүлжээ, гишүүдийг чадавхжуулах				

ХОВД АЙМАГ: ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТОЙ СУРГУУЛЬ

Ховд аймаг “Олон нийтийн оролцоот сургууль” дэд төслийг Монголын Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн (БХАН) хамтын ажиллагааны дэмжлэгээр хэрэгжүүлсэн. Дэд төслийн хүрээнд аймгийн төвөөс алслагдсан, орлого багатай, донор байгууллагын төсөлд хамрагддаггүй 10 сургуулийн засаглал, хөрөнгө, нөөцийн хуваарилалт, зарцуулалт болон олон талт шийдвэр гаргах үйл явцыг сайжруулахыг зорьсон.

Аймгийн төвийн оролцогч талуудын хийсэн нөхцөл байдлын үнэлгээгээр ихэнхи сургуулиуд засаглал, хөрөнгө, нөөцийн хуваарилалт, зарцуулалт, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах талаар иргэдэд мэдээлэл хүргэдэггүй, оролцоог хангадаггүй байна.

Сургуулийн орчны нөхцөл муу, хүүхдийн тоотой харьцуулахад хүний нөөц дутмаг, холбогдох оролцогч талуудын оролцоо, дэмжлэг сул, хуулийн дагуу багш, эцэг эхийн зөвлөл байгуулдаг боловч энэ бүтэц идэвхигүй ажилладаг зэргээс

үүдэн төслийн баг сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлт болон хяналт-шинжилгээнд оролцоог хангах механизм байхгүй буюу хангалтгүй байна гэж үзсэн. Энэ асуудлыг шийдэхийн тулд дэд төслийн хүрээнд олон нийтийн оролцоог сургуулийн үйл ажиллагаа, бодлого, дотоод журмын төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтад хангах зорилготой БХАН-ийн боловсруулсан “Олон нийтийн оролцоот сургууль”-ийн үнэлгээний аргачлалыг ашигласан.

Төсөл хэрэгжиж эхлэх үед аймгийн ЗДТГ-с төсөл хэрэгжүүлэх багийг ЗДТГ, АБГ, ТББ-ын төлөөллийг оролцуулан томилсон.



Төсөл хэрэгжүүлэх баг төслийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах зорилгоор бодлогын болон хэрэгжилтийн багийг зохион байгуулж ажилласан.

Бодлогын баг нь боловсролын газрын албан хаагчид, орон нутгийн ТББ-с бүрдсэн байсан бөгөөд аймгийн түвшинд сургуультай холбоотой хэрэгжиж буй боловсролын хууль, тогтоомж, бодлогыг цуглуулах, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх үүрэгтэй байв.

Судалгааны үр дүнд сургуулийн засаглал, үйл ажиллагаанд үр дүнтэй оролцоог хангах хууль тогтоомж, бодлогыг шинэчлэх, өөрчлөх боломжуудыг олж нээсэн.

Хэрэгжилтийн баг 20 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан ба 2 гишүүн бүр хамтдаа сум сургууль тус бүрт сургуулийн жижиг төсөлд дараах 3 үүргийг биелүүлж ажилласан: үнэлгээг хийх, сургуулийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө

боловсруулах, аймгийн ЗДТГ, аймгийн БГ болон БХАН-т тайлагнах/баримтжуулах;

Олон нийтийн оролцоотой сургуулийн менежментийн загвар, хамтаараа асуудал тодорхойлох болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахын тулд хийгдсэн ажлуудыг дараах 3 гол чиглэлд багцлан харуулж болохоор байна:

1. Бодлогын шинжилгээ

- Бодлогын болон эрх зүйн орчны барим бичгийн судалгаа хийх замаар хүчин төгөлдөр үйлчилж буй орон нутгийн болон үндэсний түвшний боловсролын бодлогын [хууль тогтоомж] заалтууд нь одоогийн нөхцөл байдал, сургуулийн хэрэгцээнд нийцэж буй эсэх талаар дүн шинжилгээ хийсэн.
- Тодорхой бодлогын хэрэгжилт, үр дүнгийн талаар олон нийтээс судалгаа авсан. Судалгаанаас олон нийт сэтгэл ханамжгүй байсан 2 гол асуудал нь: сургуулийн захирал, сургуулийн зөвлөлийг аймгийн ЗД томилдог байдал бөгөөд аймгийн боловсролын газарт томилгооны эрх мэдлийг шилжүүлэх санал дэвшүүлсэн байна.
- Сургуулийн засаглалд иргэдийн оролцоог бэхжүүлэх [бодлогын] төслүүдийг боловсруулсан.

2. Сургуулийн үнэлгээ болон сургуулийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх

- Багш, сурагчдыг оролцуулан дунд сургуулийн түвшинд тулгамдсан асуудлыг тодорхойлох хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Жишээ нь 1 сургууль дээр 5-6 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж нийтдээ 800 гаруй хүнийг хамруулсан.
- БХАН-ийн боловсруулсан үнэлгээний хэрэгсэл болон олон нийтийн оролцоотой сургуулийн үзэл баримтлалын талаар АБГ-с 10 сургуулиас сонгогдсон төлөөлөгчдөд зориулан сургалт зохион байгуулсан.
- Олон нийтийн оролцоот сургуулийн шалгуур үзүүлэлтийн дагуу судалгаа хийж үр дүнг багш нар, эцэг эхчүүдэд танилцуулсан. Судалгааны үр дүнг хамтаараа асуудлаа тодорхойлох, цаашдын үйл ажиллагаа төлөвлөх суурь болгож авч үзсэн. Хөндлөнгийн үнэлгээний ажлаар бидний зочилсон 1 сургууль дээр жишээ нь 500 хүн (эцэг эх, орон нутгийн төрийн албан хаагч, багш нар зэрэг) судалгаанд хамрагдсан байсан.
- Сургууль наад захын тулгамдсан асуудлаа шийдвэрлэх хөрөнгө, нөөцийн дутагдлаас шалтгаалан сургуулийн төслийн баг (сумын ЗД, сургуулийн захирал, багш нар, эцэг эхчүүд) хамтран ажиллах болон донорл байгууллагыг сургуулиас 10 км-ийн орчинд байрлах аж ахуйн нэгж, төрийн байгууллагаас хайсан.

- Сургуулийн орчинд болон хүүхдүүдэд тулгамдсан асуудлуудыг (жишээ нь хөндлөнгийн үнэлгээний үеэр зочилсон 2 сургуулийн хувьд дотуур байрны нөхцөл байдал, компьютер тоглоом, биллиардад хүүхдүүд донтох зэрэг асуудлууд байсан.) ойлгож мэдсэний дараа эцэг эхчүүд (ялангуяа малчин эцэг эхчүүд) сургуулийн үйл ажиллагаанд сайн дураараа, идэвхитэй оролцож (жишээ нь сургуулийн дотуур байр, хүүхдийн өрөөний засварын ажилд хувь нэмрээ оруулах, хүүхдийн өдөр тутмын зан үйлд хяналт тавих гэх мэтээр) эхэлсэн.

3. Аймгийн түвшинд болон сургууль дотооддоо туршлага солилцох үйл ажиллагаа

- Дэд төсөлд хамрагдсан сургуулиуд өөрсдийн туршлагаа баримтжуулан төсөлд хамрагдаагүй сургуулиуд хуваалцсан.
- Тодорхой сургуулиудын дэд төслийн амжилтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан олон нийтийн мэдээллийн аян зохион байгуулсан.

Дэд төслийн богино, дунд хугацааны үр дүн

1. Төрийн байгууллагын эрэлт, нийлүүлэлт, хариуцан тайлагналтыг сайжруулахад чиглэсэн НЭХ-ын үйл ажиллагааг төлөвлөсөн байдал

Бодлогын баг сургуулийн үйл ажиллагаатай холбоотой бодлого, зохицуулалтын орчинг судлан дүн шинжилгээ хийх боломжтой байсан. Тэд сургуулийн зөвлөлөөр дамжуулан оролцоог хангах хуулийн зохицуулалт байгааг олж мэдсэн. Гэсэн хэдий ч тэд энэ хуулийн өөр 1 заалт нь хэрэгжилтэд бэрхшээл учруулж байгааг эцэг эхчүүдийн дунд явуулсан судалгааны үр дүн болон оролцогч талуудын саналаас мэдэж авсан. Энэ эсрэг заалт нь Аймгийн ЗД сургуулийн захирал, сургуулийн зөвлөлийн гишүүдийг томилж байгаа явдал бөгөөд энэ томилгоо нь сургуулийн зөвлөл үр дүнгүй, идэвхигүй ажиллах шалтгаан болдог байна.

Бичиг баримтын судалгаа болон олон нийтийн [дунд явуулсан] судалгаагаар ЗД өөрийн улс төрийн намын хүмүүсийг томилдог байна. Бодлогын багийн (дэд төслийн) ахлагчийнхэлснээр бодит байдал дээр сургуулийн зөвлөл нь үйл ажиллагаа явуулах бодит эрх мэдэлгүй, идэвхи санаачлагагүй зөвхөн ЗД [хуралд]

үйлчилдэг ёс төдий бүтэц байдаг байна. Сургуулийн үйл ажиллагаа болон засаглалд олон нийт оролцох, нийтээр зөвлөлдөх боломж байдаггүй байна. Иймд эдгээр дүгнэлт, судалгааны үр дүнд үндэслэн дэд төслийн хүрээнд сургуулийн зөвлөлөөс хамаарахгүйгээр сургуулийн засаглалд олон нийтийн оролцоог хангах боломжуудыг нээж ажилласан байна.

Сургуулийн түвшинд зохион байгуулсан “Олон нийтийн оролцоот сургууль”-ийн үнэлгээгээр сургуульд тулгамдсан асуудлуудыг тодорхойлж эрэмбэлсэн байна. Дэд төсөлд 10 сургууль оролцсон боловч тодорхойлсон асуудлууд болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь сургууль, сум бүрээр харилцан ялгаатай, өөр байсан. Эдгээр асуудал тодорхойлох, эрэмблэх үйл ажиллагаанаас гадна сургуулийн хамт олон хамтдаа асуудлыг шийдвэрлэж ажиллаж чадсан (жишээ нь нэг сургууль 200 сурагч, 100 эцэг эх, багш ажилчдын хамтаар сургуулийн асуудлыг тодорхойлж дотор нь тэргүүлэх ач холбогдолтой асуудлуудаар эрэмблэн төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, олон нийтийн тусламжтайгаар цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа төлөвлөж чадсан). 10 сургууль дээр, судалгаанд оролцогчид сургуулийн үйл ажиллагаанд оролцож буй эцэг эхийн идэвхийн байдалд хамгийн бага оноог өгсөн. Тэргүүлэх ач холбогдлийг тодорхойлохдоо

[эрэмблэхдээ] сургуулийн онцлог, сурагчдын шаардлага хэрэгцээг харгалзсан. Нэг сургуулийн жишээн дээр хүүхдийн хөгжил, хүмүүжилд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, сургуулийн орчныг сайжруулах зэрэг (сандал ширээ, урлаг, соёлын арга хэмжээ явуулах урлагийн заал барих гэх мэт гэх мэт) нь гол асуудлууд байсан.

Сургуулийн дэд төслийн хүрээнд боловсруулж хэрэгжүүлсэн сургууль сайжруулах төлөвлөгөө нь олон талт оролцогчид буюу аймаг, сумын захиргаа, эцэг эхчүүд, олон нийт, бизнесийн байгууллагууд, ТББ-ыг татан оролцуулж тэдний дэмжлэгийг бий болгосон. Ингэснээр сургууль өөрийн хөрөнгө, нөөцөөр шийдвэрлэх боломжгүй олон тулгамдсан бодит асуудлууд дээр жишээ нь сургуулийн дотуур байрны засвар, сургууль дээр хүүхдийн чөлөөт цагаа өнгөрөөх байдалд хяналт тавих зэрэгт олон нийтийн анхаарлыг хандуулж бодит арга хэмжээ авч чадсан. Хүүхдүүдээ хичээлийн жил эхлэхэд сургуульд “орхиод” явдаг малчин эцэг эхчүүд сургууль дээр дэд төсөл хэрэгжсэнээр өөрсдийн дотоод нөөц бололцоогоо дайчлан оролцсон. Өөр нэг сургуулийн жишээн дээр эцэг эх, багш нар хийх ажлуудаа тусдаа төлөвлөн, эцэг эхчүүд хүүхдийн хүмүүжил, хөгжил, багш нар ЗЕШ-д бэлтгэл хэрхэн хангаж байгаад хяналт тавих гэх мэтээр өөрсдийн санаачлагаар ажилласан.

Зарим сургуулиуд хамтдаа шийдвэр гаргах үйл явц, хамтын оролцооны үр шимийг хүртэхээс гадна сургуулийн эцэг эхийн зөвлөл, дотуур байрны эцэг эхийн зөвлөлийг идэвхижүүлэн сургуулийн үйл ажиллагааны журам, дотоод хяналт үнэлгээний систем, сургуулийн төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэдийн оролцоог хангах зэрэгт өөрчлөлт оруулахаар ажилласан байна. Аймгийн түвшинд төслийн хэрэгжилтийн баг нь төсөлд хамрагдсан сургуулиудын сайн туршлага, сургамжийг түгээх зохион байгуулалтаар хангаж ажилласан. Төсөлд хамрагдаагүй сургуулиудад төслийн сургуулиудын сайн туршлагыг хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоот сургуулийн загварыг өөрийн сургууль дээр хэрэгжүүлэх саналыг хүргүүлсэн.

2. Дунд хугацааны үр дүн: Иргэд чадавхжих, орон нутгийн засаглал болон боловсролын үйлчилгээ сайжрах чиглэлээр гарсан тодорхой үр дүн

Засаглал: АБГ, сумын ЗД болон сургуулийн захирлын зүгээс ТББ болон олон нийтийн сургуулийн асуудлыг шийдвэрлэхэд оруулж буй хувь нэмэр, үүргийг хүлээн зөвшөөрсөн.

Эдгээр оролцогч талууд боловсролын үйлчилгээнд шудрага ёс тогтоох болон сургуулийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зэргээр нийгмийн эгэх хариуцлагыг ойлгож талархан дэмжиж байна.

“Өөрсдийн асуудлаа шийдвэрлэх гэдэг нь хөрөнгө мөнгө хайж санхүүжилт авахаас илүүтэйгээр олон нийтээрээ, хамтдаа тулгамдсан асуудлаа шийдэх тухай юм.”

-Ховд аймгийн Мянгад сумын ЗДТГ-ын дарга

Жишээ нь нэг сумын засаг дарга сургуулийн асуудлыг шийдэх өөрийн хандлагыг тэр чигт нь (засаглал болон төрийн үйлчилгээ талаас) өөрчилсөн. Хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд түүний үзэж буйгаар асуудлыг шийдэх талаар хөрөнгө мөнгө хайхад анхаарахаас илүү олон нийт тулгамдсан асуудлаа өөрсдөө шийдвэрлэх, олон нийттэй харьцах, орон нутгийн нөөц боломжийг ашиглах тухай гэж онцолсон юм.

Хамтарч асуудлыг шийдвэрлэх замаар орон нутгийн төсвийг нэмэгдүүлэхгүйгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжтой. Зөв зохион байгуулалт (үйл явц), дэмжлэгээр төрөөс (орон нутгийн захиргаа) малчин өрхүүд, олон нийт, орон нутгийн байгууллагын хувь нэмрийг хүртэх боломжтой.

Дэд төслийн хэрэгжилтээс бий болсон үр дүнгээс АБГ нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх, орон нутгийн бүтээлч хамтын ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд сургуулиудтай гэрээ байгуулсан бөгөөд сургуулийн зөвлөлөөс зохион байгуулах уулзалт хэлэлцүүлэгт сургуулийн менежерүүдийн идэвхитэй оролцоог

хангах чиглэлээр ажиллаж байна. АБГ хяналт-шинжилгээ хийх арга зүйд иргэдийг сургах, сургуулийн төсвийн төсөл боловсруулахад иргэд/эцэг эхийн оролцоог хангах, сургуулийн үйл ажиллагааны тайланг олон нийтэд танилцуулах, сургуулийн зөвлөл, эцэг эхчүүдэд аудитын тайланг хүргүүлэх зэрэг үйл ажиллагааны төсвийг АБГ-ын [хичээлийн жилийн] үйл ажиллагааны төсөвт тусгахаар төсөл боловсруулсан.

Чадавхжуулах: Сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлт, сургуулийн орчин нөхцөл байдлыг үнэлэх явцдаа эцэг эхчүүд сургууль дээр хүүхдүүддээ зориулан үр дүнтэй цагийг өнгөрүүлж ажилласан. Тэд хүүхдүүдээ их сургуульд орох илүү боломжтой болсон гэж үзсэн. Эцэг эхчүүдийн сэтгэлгээнд гарсан өөрчлөлт нь сургуулийн болон гэр бүлийн орчинд боловсролын ил тод, хариуцан тайлагнах үйл ажиллагааг нэхэх болсон явдал юм.

Эцэг эхчүүд мөн сургуулийн төлөвлөлт, засаглал, үйл ажиллагааны талаар мэдлэг туршлагатай болсон. Мөн сургуулийн менежерүүдэд тулгардаг үйл ажиллагаатай холбоотой хүндрэл бэрхшээлийг олж мэдсэнээр тэд юуг хийж чадах/чадахгүй болохыг ойлгож авсан. Нэг сургуулийн жишээн дээр гэхэд сургуулийн сурагчид компьютер тоглоомд донтсон учраас (энэ асуудлыг дэд төслийн хүрээнд шийдсэн) хүүхдүүд хичээлдээ бага цаг зарцуулдаг талаар эцэг эхчүүд олж мэдсэн.

Олон нийтийн (орон нутгийн иргэд) сургуульд тавих анхаарал, дэмжлэг идэвхижсэн байна. Түүнчлэн орон нутгийн төсөл хэрэгжүүлэгчид болон оролцогч талууд “бусад асуудлыг шийдвэрлэх” боломжтой гэсэн илүү итгэлтэй болсон.

Төрийн үйлчилгээ: Сургуулийн үйл ажиллагаа болон сургуулиас хэрэгжүүлсэн сайн дурын бусад үйл ажиллагаанд оролцох эцэг эхчүүдийн оролцоо нэмэгдсэнээр багш нар сургууль дээр хүүхдүүд чөлөөт цагаа (компьютер, биллиард тоглох) хэрхэн өнгөрөөж буйд хяналт тавих, цаг их шаардсан үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн.

Үүний үр дүнд багш нар багшлах арга зүй болон хичээлээ сайжруулахад илүү анхаарал тавих боломжтой болсон. Зочилсон 2 сургуулийн хувьд эцэг эхчүүдийн дүгнэснээр сургуулийн материаллаг болон сэтгэл зүйн орчин сайжирч сурах орчин бүрдсэнээр сургуулийн үйл ажиллагаа, сурлагын чанар сайжирсан.

3. Тогтвортой байдлыг хангах механизм

Ховд аймгийн дэд төсөл зарим сорилттой тулгарсан бөгөөд эдгээрийн нэг нь төслийн 10 сургууль нь аймгийн төвөөс алслагдмал зайд оршдог ба тэдэнтэй холбогдож төслийг хэрэгжүүлэхийн тулд төсвийн хувьд хүндрэлтэй байсан. Аймгийн төвөөс хол учраас мэдээлэл

АЙМГИЙН ИТХ-Д ӨРГӨН БАРЬСАН “ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТ СУРГУУЛЬ-ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭСГЭЭС

Хөтөлбөрийн зорилго: Хүүхдийг багаас нь хариуцлагатай, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, хамтран ажиллаж амьдрах, байнга суралцагч иргэн болж төлөвших гэр бүл, боловсрол, нийгмийн орчныг бүрдүүлж сургуулийг иргэдийн хөгжлийн төв болгон хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Хөтөлбөрийн зорилт

Сургуулийн хөгжилд олон нийтийн оролцоог өргөжүүлж, орон нутгийн иргэдийн хөгжлийн төв болгон хөгжүүлнэ.

Сургууль –хүний хөгжлийн төв болон хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой байдлыг хангах

Сургуулийн үйлчилгээнд иргэдийн хяналтыг буй болгон нийгмийн эгэх хариуцлагыг нэвтрүүлнэ.

Иргэдийн оролцоотой холбоотой гол үйл ажиллагаа:

- Төсөлд хамрагдаагүй 15 ЕБС-ийн төлөөлөлд ОНОС-ын чанарын үнэлгээ хийх арга зүйг эзэмшүүлэх бүсчилсэн сургалт зохион байгуулах
- Тухайн хичээлийн жилийн төлөвлөлтийн хэрэгжилтийг сургуулийн зөвлөл, иргэдэд тайлагнах
- Сургуулийн үйлчилгээ, төсвийн төлөвлөлт, зарцуулалтанд хяналт үнэлгээ хийх сургалтыг сум бүрийн иргэдийн төлөөлөлд бүсчлэн зохион байгуулах
- Жил бүр сургуулиуд тодорхой үйлчилгээний чанар, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэдийн хяналт үнэлгээ хийлгэж, тайлагнан, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах

түгээх, хуваалцахад мөн хэцүү байв. Бүх оролцогч талыг цуглуулан туршлага, сургамжийг хуваалцахад тэдний замын зардлыг хариуцжээ. Төслийн цаг хугацааны хувьд хичээлийн жилийн төгсгөл, зуны амралт таарсан зэргээс хамааран зарим сургууль дээр эцэг эхчүүд, сурагчдыг цуглуулахад хүндрэл гарч байсан байна.

Хэдий тийм боловч дээр дурьдсан жижиг хүндрэлийг тооцохгүйгээр төслийн баг санаачлагын урт хугацаанд тогтвортой үргэлжлэх

талаар зарим арга хэмжээ авч ажилласан.

Сургуулийн түвшинд дэд төслийг цаашид үргэлжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн ба зарим сайн дурын бүлгүүд [сурагчдын] зан үйл, сурагчдыг хөгжүүлэх талаар ажиллахаар болсон. Сургуулийн захирлын хувьд эдгээр механизмыг сургуулийн хөгжлийн бодлогын хэсэг болгох сонирхолтой байгаа. Бас нэг сургуулийн жишээн дээр сургуулийн

захирлын манлайлал дор оролцогч талууд сургуулийн дотоод дүрэм журамд өөрчлөлт оруулж эхэлсэн ба энэ өөрчлөлт нь багш нарыг дотуур байрны хүүхдүүдэд анхаарал хандуулах, дотуур байрны нөхцөлд анхаарах талаар заалтууд тусгах юм.

Мөн түүнчлэн тэд [сургуулийн удирдлагаас] сургууль болон олон нийт, хүүхдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар сургуулийн удирдлага, багш нарын үр дүнгийн гэрээнд өөрчлөлт оруулахаар төлөвлөж байна.

Аймгийн түвшинд асуудлыг доороос дээш төлөвлөх процессыг [үйл явцыг] нэвтрүүлэх талаар АБГ маш тодорхой ойлголттой байгаа бөгөөд олон нийтийн оролцоот сургуулийн загварыг бүх сумдад хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулсан. Тус дэд хөтөлбөрийг төслийн хүрээнд хэрэгжүүлсэн бодлогын судалгааны үр дүнгийн хамтаар аймгийн ИТХ-р хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлсэн байгаа бөгөөд АБГ-ын удирдлага болон ТББ-ын төлөөлөгчид энэ дэд хөтөлбөрийг батлагдана гэдэгт итгэлтэй байгаа.

Туршлага хуваалцах 10 сургуулийн үр дүнгийн хэлэлцүүлэгт Ховд аймгийн бусад сумдын сургуулиуд оролцсон. Төсөл хэрэгжсэн 10 сургуулийн туршлага, баримтжуулалт дээр үндэслэн загварыг бүх сургуулиудад хэрэгжүүлэхийн тулд юу хэрэгжих боломжтой, юуг хэрэгжүүлэхэд тохиромжгүй талаар бусад сургуулиуд нэгдсэн ойлголттой болсон.

Сургуулийн түвшний дэд төслүүдийн хувьд өмнө нь бусад байгууллагатай харьцаж хөрөнгө нөөц босгох / сайн дурынханы оролцоог ашиглах, хувийн хэвшил, бусад байгууллагын хандив зэрэг/ боломжийг бүрэн ашиглаж чаддаггүй байсан бол одоо тэд ирээдүйд шаардлагатай үйл ажиллагааг зохион байгуулах, хамтран ажиллах талаар шинэ итгэл үнэмшилтэй болсон.

Эцэст нь аймгийн удирдлага, орон нутгийн засаг захиргааны зүгээс төслийн хэрэгжилтээс бий болсон иргэдийн оролцооны ач холбогдол, үр нөлөөг олж харсан бөгөөд орон нутгийн нөөцөөс 160 сая төгрөгийг дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд зориулан хуваарилахаар шийдсэн.

Үнэлгээ, ЗӨВЛӨМЖҮҮД

Ховд аймагт хэрэгжсэн дэд төсөл нь маш сайн баримтжуулсан, орон нутгийн түвшинд (аймагт) болон үндэсний хэмжээнд түгээн нэвтрүүлэх боломжтой, БСШУЯ-д санал болгохуйц үр дүнтэй загвар юм. Ховд аймагт хэрэгжсэн загвар нь дараах давуу талуудтай байсан. Үүнд:

- Сургуулийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам болон хэрэгжилтийг судлан сургуулийн зөвлөл нь сургуулийн удирдлагатай хариуцлага тооцох боломжгүй талаар тодорхой

заалтууд, хэрэгжилтийн зөрүүг гаргаж ирсэн. Төсөл хэрэгжүүлэгчид сургуулийн зөвлөлийг хараат бус байдлаар томилогдсон нөхцөлд сургуулийн засаглалын эрх мэдлийн тэнцвэрийг хангах хөшүүрэг болно гэж үзсэн ба [хараат бус байдлыг хангахын тулд] үүний тулд аймгийн ЗД сургуулийн захирал болон сургуулийн зөвлөлийг томилохгүй байхыг санал болгосон.

- Орон нутгийн захиргаа (сумын болон аймгийн түвшний), иргэний нийгмийн байгууллагууд, олон нийт, эцэг эхчүүд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд хамтран хэрхэн ажиллаж болох, асуудлыг хэрхэн шийдвэрлэж болохыг дэд төслийн туршлага харууллаа. Энэ хамтын ажиллагааны хэлбэр 10 сургуулийн хүрээнд төрөл бүрийн нөхцөл байдал дунд хэрэгжсэн. Төслийн хүрээнд магадгүй [асуудлын мөн чанараас хамааран] боловсрол болон үүнтэй хамааралтай бодит асуудлаар оролцогч талуудыг татан, хамтарч ажиллаж байсныг энд онцолмоор байна. Эцэст нь “хүүхэд өсгөхөд (боловсролтой болгох) бүх тосгоноороо [сумаараа] хөдлөх” шаардлагатай гэсэн хэлц байдаг билээ. Дэд төсөл нь эцэг эхчүүдийг идэвхижүүлж, нөөц бололцоог нь дайчлан хүүхдийнх нь боловсролын асуудалд анхаарлыг нь хандуулсан бол орон нутгийн байгууллагууд/ аж ахуйн нэгжүүдийг орон

нутгийн сургуулиа дэмжих хүсэл сонирхлыг нь хөгжөөсөн.

- Төслийн загвар нь ямар ч нөхцөл байдалд хэрэгжүүлэх боломжтой загвар бөгөөд холбогдох үйл ажиллагааг тэр дор нь төлөвлөх боломжийг олгодог. Оролцогч талууд төслийн хүрээнд юу хэрэгжиж болох, юу хэрэгжих боломжгүй талаар төрөл бүрийн сургуулийн жишээгээр баримтжуулалт хийн [цаашид үргэлжлүүлэн] хэрэгжүүлэхэд бэлэн орчинг бий болгосон.

Гэсэн хэдийгээр аймаг болон төслийн зүгээс дараах асуудлыг анхааран шийдвэрлэх нь чухал. Үйл ажиллагааны хувьд сургуулийн түвшний ихэнхи дэд төслийн хүрээнд эцэг эхчүүдийг идэвхижүүлж үйл ажиллагаандаа татан оролцуулснаас гадна тодорхой стратеги зорилготойгоор хамтаараа асуудлыг шийдвэрлэхэд анхаарах шаардлагатай.

Сумдын алслагдмал байдлаас шалтгаалан АБГ болон ТББ-ууд мэдээлэл түгээх, хуваалцах, туршлага солилцох илүү үр дүнтэй арга хэрэгсэл, сувгийг олох хэрэгтэй.

Мөн хамгийн чухал нь сургуулийн төслийн баг болон оролцогч талууд нийгмийн эгэх хариуцлагын санаачлагын хүрээнд боловсролын үйлчилгээг хүргэх нь төр болон төрийн хэрэгслүүдийн үндсэн үүрэг хэвээр үлдэнэ гэдгийг ойлгох шаардлагатай юм.

Ийм учраас, АБГ, сургуулийн менежерүүд, үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрүүд нь боловсролын үйлчилгээнд тулгамдсан асуудал, хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх хэрэгтэй. Эцэг эхчүүдийн оролцоо хэдий чухал боловч энэ нь эцсийн зорилго биш юм. Сургууль дээр хэрэгжсэн дэд төслүүдийн олонхи нь засаглалын түвшин бүрт төрийн байгууллага/оролцогч талуудаас хариуцлага тооцоход [нэхэх] чиглэсэн байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Ховд аймгийн нэгдсэн үнэлгээ

Нийгмийн эгэх хариуцлагын механизм	Үр дүн			Тогтвортой байдал
	Засаглал	Чадавхжуулах	Төрийн үйлчилгээ	
✓	✓	✓	✓	✓
Аймгийн түвшинд бүх сургуульд хэрэгжүүлэх, үндэсний хэмжээнд бодлого боловсруулахад баримтжуулах				

ХӨВСГӨЛ АЙМАГ: ХАМТЫН ОРОЛЦООТОЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ТӨСӨЛ

Хөвсгөл аймгийн “Хамтын оролцоотой эрүүл мэндийн үйлчилгээ” нэртэй дэд төслийг Монголын нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгийн (МНЭМН) түншлэлийн хүрээнд хэрэгжүүлсэн. Аймгийн Засаг даргын гаргасан тушаалын дагуу төсөл хэрэгжүүлэгч баг Нийгмийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн газар, АНЭ, Мөрөн сумын оролцогч Өрхийн эрүүл мэндийн төв болон төслийн зохицуулалтыг хариуцагч орон нутгийн ТББ-ын төлөөлөгчдөөс бүрдсэн. Аймгийн судалгаанд оролцогсдын үзэж буйгаар Хөвсгөл аймгийн төвд (ялангуяа Мөрөн сум) 6 сараас дээш хугацаатай амьдардаг түр оршин суугчдын тогтмол урсгал байдаг. Эдгээр түр оршин суугчид ихэвчлэн өөрсдийн албан ёсоор бүртгэлтэй сумын эрүүл мэндийн төв бус харин аймгийн төвийн эрүүл мэндийн үйлчилгээ, хөтөлбөрүүдийг хүртэх хэрэгтэй болдог.

Аймгийн төвд бүртгэлгүй оршин суугчид Мөрөн сумын Өрхийн эрүүл мэндийн төвөөс (ӨЗМТ) эрүүл мэндийн албан тусламж үйлчилгээ авч чаддагүй шалтгаан нь тэдний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөр Мөрөн сумын


ӨЗМТ-с бус харин өөрсдийнх нь оршин суудаг орон нутгийн ӨЗМТ/ сумдын төсвөөс гарах ёстой.

Хэрэв түр оршин суугчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэрэгтэй болвол тэд гуравдугаар шатлалын АНЭ-т очих хэрэгтэй авч тэдэнд энэ талаар хангалттай мэдээлэл байхгүй эсвэл эмч, сувилагч болон бусад эрүүл мэндийн мэргэжилтнүүд дутмаг байдгаас үүдэн хангалттай зорьж очдоггүй.

Хөвсгөл аймгийн дэд төслийн зорилго нь түр оршин суугчдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртэмжийг сайжруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлал хоорондын үйлчлүүлэгч шилжүүлэх тогтолцоог зөв зүйтэй хэрэгжүүлэх боломжоор хангах байв.

ДЭМБ-ын “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчимд үндэслэсэн хөндлөнгөөс хянах аргыг ашиглан оролцогч талууд мөн түр оршин суугчид АНЭ, Мөрөн сумын ӨЗМТ-ийн үйлчилгээний талаар санал дүгнэлт өгөх боломжтой байв. Ялангуяа төсөл эмнэлгийн орчин болон хүлээгдлийн цагийн талаарх өвчтөнүүдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд туслах зорилготой байв.

Хөвсгөл аймгийн дэд төслийн хураангуй



Юугаар:

Хөндлөнгийн хяналт ашиглан
Түр оршин суугчид болон үйлчилгээ үзүүлэгчдэд иргэдийн зүгээс үйлчилгээний талаар өгсөн санал дүгнэлт ба үнэлгээ

Орон нутгийн зохицуулагч баг, түншлэгч ТББ-ын дэмжлэгтэйгээр дараах гол үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн:

1. Дэд төслийн гол анхаарах зүйлс болон загвар хийцийг шийдэхийн тулд гол оролцогч талуудын хооронд хэлэлцүүлэг зохион явуулж аймгийн албан тушаалтнууд, эрүүл мэнд, боловсролын салбарын үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд ба орон нутгийн ТББ-ын зүгээс оруулсан хувь нэмэрт үндэслэн эрүүл мэндийн салбарт үргэлжлүүлэн анхаарлаа хандуулах шийдэлд хүргэсэн.

2. Түр оршин суугчдын тоо болон тэдний талаарх мэдээллийг цуглуулах судалгаа хийв.
3. ТББ болон Эмнэлгийн чанар хариуцсан хэлтэс оролцогч талын сэтгэл ханамжийн судалгааг 2017-оны 1-р сард 392, АНЭ-р үйлчлүүлэгчид, 3-р сард 390, АНЭ-р үйлчлүүлэгч-200, Өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэгч-190, 5, 6-р сард 390, АНЭ-р үйлчлүүлэгч-200, Өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэгч-190 хүнийг хамруулсан судалгаагаар эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, эмчийн цаг ашиглалт, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, тэдэнд тулгарч байгаа бэрхшээлийг тодорхойлсны гадна 2017 оны 3 дугаар сард АНЭ-ийн 270, ӨЭМТ-ийн төвийн 46, нийт 314 эмч ажилчдын сэтгэл ханамж, тэдгээрт тулгарч буй бэрхшээлийн дэлгэрэнгүй судалгаа дүгнэлт хийсэн.
4. Үнэлгээний үр дүнг хэлэлцэхээр нүүр тулсан уулзалтуудыг зохион байгуулсан. Үүнд Аймгийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, Сумын захиргаа, АНЭ, ӨЭМТ-үүд, иргэд болон ТББ-ууд оролцсон.
5. Эрүүл мэндийг хүсэмжлэх зан үйлийг нэмэгдүүлэх иргэдэд чиглэсэн болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд болон бусад иргэдэд эрсдлийг зохицуулах эсвэл бууруулахад нь туслах мэдээлэл, боловсролын

сургалтуудыг зохион байгуулсан.

6. Төслийн хэрэгжилтийн үр дүнгийн танилцуулгыг аймгийн захиргаа, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, иргэний нийгмийн зөвлөл ба түүний гишүүн ТББ-уудад хийсэн. Аймгийн 24 сумын Засаг дарга, аймгийн хэлтэс агентлагийн дарга, аймагт үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын төсөл хөтөлбөрийн нэгжийн удирдлага, ажилтнууд, иргэдэд танилцуулга хийсэн.

Дэд төслийн богино, дунд хугацааны үр дүн

Дараагийн хэсгүүдэд дээр жагсаасан дэд төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнг баримтжуулж, илүү үр дүнтэй нийгмийн эгэх хариуцлагын санаачлагын хүрээнд үр дүнд хамгийн чухал элементүүд, агуулгын хүчин зүйлүүдээр нь дүн шинжилгээ хийсэн ба үүнд:

1. Төрийн байгууллагын эрэлт, нийлүүлэлт, хариуцан тайлагналтыг сайжруулахад чиглэсэн НЭХ-ын үйл ажиллагааг төлөвлөсөн байдал

Оролцогч талын сэтгэл ханамжийн судалгааны бүтэц ба арга барил нь холбогдох төр засгийн байгууллагуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд тулгарч буй асуудлуудыг сонсож, тодорхойлох боломж олгосон. Үйлчилгээ үзүүлэгч

байгууллагууд үнэлгээг таашааж буй шалтгаан нь ИНБ-ын хийсэн хөндлөнгийн үнэлгээ “илүү бодит, оновчтой” тул өөрсдийн үзүүлж буй үйлчилгээгээ сайжруулахад түлхэц болно гэдэгт итгэдэг. ИНБ-ууд болон иргэд судалгааны үр дүнгийн хийц загвар, засаг захиргаа болон дүн шинжилгээний нэг хэсэг байсан учраас тэд мөн адил эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хийсэн асуудлыг шийдвэрлэх яриа хэлэлцээрийн нэг хэсэг байсан.

2. Дунд хугацааны үр дүн: Иргэд чадавхжих, орон нутгийн засаглал болон эрүүл мэндийн үйлчилгээ сайжрах чиглэлээр гарсан тодорхой үр дүн

Засаглал: Судалгаа явуулснаар аймгийн төр засгийн нэгжүүд дэх түр оршин суугчдыг тогтоож, суурьшлыг нь тодорхойлох боломж олгосноос гадна сум бүрийн өвчтөнүүдэд илүү үр дүнтэй үйлчилгээ хүргэх боломж олгосон. Иргэд аймгийн төвд зургаан сараас илүү хугацаатай суурьшвал тэд түр оршин сууж буй сумын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах эрхтэй болдог. Хэрэв түр оршин суугч ӨЭМТ-с эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авбал ӨЭМТ тухайн оршин суугчийн “бүртгэлтэй” сумын эрүүл мэндийн төвөөс нөхөн төлбөр авах тухай журмын төслийг аль хэдийнэ төслийн зохицуулагч баг боловсруулсан. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын

санхүүжилт нь нэг хүний тоонд ногдох хэмжээгээр байдаг ба санхүүжилт нь сүүлийн гурван жилд бүртгэгдсэн оршин суугчдын нийт тоонд үндэслэсэн байдаг учраас түр оршин суугчид өөрсдийг нь хүлээн авч буй сумын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртсэнээр ӨЗМТ-ийн нөөцөд дарамт учруулж байна. Судалгааны үр дүн болон түр оршин суугчдын талаарх мэдээллийн санг ашиглан аймгийн эрүүл мэндийн газар харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд сумын захиргаанаас нөхөн төлбөр авах нэхэмжлэл гаргах үндэслэлтэй.

Түр оршин суугчдад зориулсан санхүүжилтын тухай улсын хэмжээний хууль эсвэл бодлого байхгүй байгаа нь олон талаар үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дунд төсвийн хуваарилалт, хэрэглээний талаар маргаан үүсгэж байна. Төслийн хэрэгжилт нь оролцогч талуудад эдгээр асуудлуудыг тодорхойлох боломж олгосноос гадна аймгийн оролцогч талуудыг ЭМЯ болон УИХ-ын Нийгмийн бодлогын хороонд асуудлаа тавихад түлхэц болсон.

Чадавхжуулах: Үнэлгээний үеэр тайлагнасан үр дагавар байхгүй.

Төрийн үйлчилгээ: Оролцогч талын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс харахад үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд алхам хийж, өөрчлөлтийг эхлүүлснээр сэтгэл ханамжийн гурван судалгааны явцад (нэг нь үйлчилгээ сайжруулах төлөвлөгөөний өмнө) Мөрөн сумын эмнэлэг ба Өрхийн эрүүл мэндийн

төвд өгсөн ерөнхий үнэлгээ аажмаар сайжирсан. 2017 оны 1 сард явуулсан эхний судалгаагаар судалгаанд оролцогсдын 18% нь (392 оролцогч) АНЭ-ийг “Муу” гэж үнэлсэн бол дараа дараагийн судалгаагаар уг дүн их хэмжээгээр буурсан. Жишээлбэл 3 сард явуулсан судалгаагаар (390 оролцогч) судалгаанд оролцогсдын 3.9% нь эмнэлэгт “Муу” гэдэг үнэлгээ өгсөн. Хэдийгээр үнэлгээ сайжирсан явдал зөвхөн үйлчилгээ сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтээс улбаатай биш боловч орон нутгийн зохицуулагч ТББ, өвчтнүүд үйлчилгээ авахдаа цөөн удаа эмнэлэгт биеэр очих шаардлагатай болсон талаар мэдэгдсэнийг харахад хэрэглэгчид, өвчтөнүүд гарсан өөрчлөлтөөс ашиг хүртсэн байх талтай. Жишээ нь эмнэлгийн дүн шинжилгээ эсвэл лабораторийн үйлчилгээ авахдаа өвчтөн өмнө нь эмнэлэгт 5-с дээш удаа биеэр очих шаардлагатай байсан нь одоо 2-5 удаа болж буурсан байна. Мөн цахимд цаг авахдаа дугаарлалт, хүлээлт их байсныг өөрчилж, үйлчлүүлэгч очсон хугацаандаа шууд дугаар авдаг болсон учир цахим очер, дугаар хүлээхгүй болсон зэрэг хүлээлт чирэгдэлгүй болсон үр дүн гарч тогтворжсон.

Эмнэлгийн ажилтан мэргэжилтнүүд судалгааны үр дүнг зэрэгээр хүлээн авч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад хэрэгтэй санал дүгнэлт гэж үзсэн. Тэдний нэрлэсэн “Өөрчлөлтийг өөрөөсөө” хэмээх үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө боловсруулалт мөн хэрэгжилтийн ажил нь сайжруулах

асуудал бүрийн хүрээнд ажиллах багуудыг бүрдүүлсэн ба эдгээр нь: Харилцаа холбооны үр чадвар, ёс зүй болон эрүүл мэндийн ажилтны хандлагыг сайжруулах; өвчтөнүүдэд зөвлөгөө, зөвлөмж өгөх; орчныг сайжруулах; үйлчилгээний соёл; үйлчилгээний үр дүнтэй байдал ба цаг ашиглалт; мөн өвчтнүүдийг тогтмол эргэх.

ИНБ-ын хамтрагчид үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө боловсруулалтад судалгааны үр дүнг тусгаснаар үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах зарим түлхүүр үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн:

- Цахим бүртгэл болон үзлэг товлох системийг нэвтрүүлж хүлээгдлийн цаг, очерийг бууруулах;
- Өвчтөнүүдэд хэрэгцээ шаардлагадаа нийцсэн зөв эмчээ олоход туслах зурган танилцуулга бүтээх;
- Иргэдийн эрүүл мэндийн зөвлөх үйлчилгээг хариуцах, сэтгэл зүй-нийгмийн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийг илүү их хүсэмжлэх мэдээлэл түгээхэд чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн алба байгуулах, ба
- Ажилтнуудад өвчтөнүүдтэй харьцах харилцаагаа сайжруулах сургалт явуулах.

3. Тогтвортой байдлыг хангах механизмын талаар

Гурван оролцогч талууд, төр засгийн газар, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон ИНБ-ын төлөөлөгчид иргэний оролцоо болон хяналт шийдвэр

гаргалт, үйлчилгээ хүргэлтийн хувьд чухал хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөө нь оролцоо болон эгэх хариуцлага бүхий засаглалыг хангах тухай зүйл заалтыг тусгасан.

ӨЭМТ-ийн дарга оролцоот үнэлгээг илүү тогтмол хугацаанд хийх боломжтой гэж үзэж байгаа (жилдээ хоёр удаа). Өөр дурдвал зохих зүйл бол ИНБ-уудыг зөвхөн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын ажил хэргийг шүүмжлэгч бус иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл өгөх, олон нийтийн эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэнд хүсэмжлэх хандлагыг сайжруулах ажилд оролцох чухал хамтрагчид хэмээн харж буй байдал юм.

Үнэлгээ

Дэд төслийн туршлагыг түгээх, өргөжүүлэхээс өмнө хэд хэдэн сайжруулах зүйлс байна:

- Тогтолцооны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хүрэх зорилго, арга барилаа илүү тодорхой болгох шаардлагатай. Энэ нь зөвхөн иргэдийн сэтгэл ханамжгүй байдлыг бууруулахаас гадна өнгөн хэсгийн санаачлагууд бус илүү стратегийн төлөвлөгөөт, нэгдмэл шийдлүүдийг шаардана.
- Оролцогч талын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн болон асуудлыг шийдвэрлэх дасгал нь төсөл хэрэгжүүлэгч/зохицуулагч багт

эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжэд тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлох боломж олгосон ба үйлчилгээ сайжруулах санаачлагуудыг холбогдох албан газрууд дэмжиж байгаа боловч үйлчилгээ сайжруулах тал дээр хамтарсан, нэгдсэн хүчин чармайлтгүй байна. ИНБ-ууд төслийг хэрэгжүүлэн бүх шатны хэлэлцүүлэгт оролцож байсан боловч өөрсдөө үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө боловсруулалтад оролцоогүй учраас судалгааг мэдээллээр хангагч байдлаар ажилласан.

- Төрийн байгууллага, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын зүгээс ИНБ-ууд ба иргэдийн төлөөллийг өөрсдийн эрүүл мэндээ хэрхэн хамгаалах тухай олон нийтэд мэдээлэл түгээх арга хэрэгсэл гэж үзсэнийг анхаарах хэрэгтэй. ИНБ-ууд иргэдийн оролцоог төр засгийн үргэлжлэл буюу иргэдэд хүрч ажиллах арга хэрэгсэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөтөлбөрүүдийг

хүргэх бүрэлдэхүүн гэж үздэг тул таашаан хүлээн авах нь хязгаарлагдмал. Орон нутгийн ТББ-тай шууд хамтран ажилласан, туршлагажсаны хувьд төрийн байгууллагын зүгээс иргэд/ТББ-ыг чухал хамтран ажиллах түнш гэж үзэн хамтын шийдвэр гаргахад оролцуулах нь ач холбогдолтой.

- Түр оршин суугчдад зориулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний илүү урт хугацааны болон тогтвортой шийдэл нь улсын хэмжээнд бодлогын нөлөөллийн асуудал байж магадгүй - жишээ нь ЭМЯ болон УИХ – ӨЭМТ болон сумын эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн хуваарилалт болон санхүүжилтийн схемийг судлах хэрэгтэй. Төсөл хэрэгжүүлэгчид өрхийн эмнэлгийн санхүүжилт болон нэг өрхийн эмнэлэгт ногдох хүн амын тоон дээр асуудал байгааг хүлээн зөвшөөрч шийдэх гарцыг хайж буй боловч эдгээр асуудал нь үндэсний түвшинд шийдэгдэх асуудал юм.

Хөвсгөл аймгийн нэгдсэн үнэлгээ

Нийгмийн эгэх хариуцлагын механизм	Үр дүн			Тогтвортой байдал
	Засаглал	Чадавхжуулах	Төрийн үйлчилгээ	
✓	✓	X	✓	✓ X
ИНБ-уудыг нэгдсэн сүлжээний зохион байгуулалтад оруулах, чадавхийг бэхжүүлэх				

СЭЛЭНГЭ АЙМАГ: СҮРЬЕЭГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

Сэлэнгэ аймаг дэд төслийг Улаанбаатар хотод төвтэй Ардчилалын Боловсрол Төвийн (ДЕМО ТББ) дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн. “Сүрьеэгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” дэд төсөл нь сүрьеэгийн өвчний тохиолдлыг (улсад 2-рт ордог) бууруулах зорилготой байв.

Сэлэнгэ аймаг нь Орос улстай хил залгаа ба 6-7 сумд алтны уурхай үйл ажиллагаа явуулдаг. Үүнтэй холбоотойгоор тус аймгаар дайран гарах иргэдийн тоо болон уул уурхайд ирж очих хөдөлгөөний урсгалаас хамааран тус аймгийн хүн ам халдварт өвчин авах болон өвчнийг түгээх өндөр эрсдэлтэй орчинд амьдардаг.

2016 оны байдлаар 100 мянган хүнд сүрьеэгийн 18,2 тохиолдол бүртгэгдсэн ба бодит байдал дээр өвчлөл энэ тооноос өндөр байх магадлалтай. Сүрьеэгийн өвчлөлийг эмчлэхийн тулд аймгийн нэгдсэн эмнэлэг нийт өвчтөн хэвтэн эмчлүүлэх 25 ортойгоос сүрьеэгийн тасагт хамаарах 5 ор нь сүрьеэгийн


өвчтөнд зориулсан байдаг. АНЭ 180 хүнийг жилд эмчилдэг ба эдгээр өвчтөний 60 хувь нь орон нутгийнх байдаг. Эмнэлгийн орчин нөхцөл тааруу, эмнэлгийн ажилтны ачаалал их зэргээс хамааран төрийн үйлчилгээний хүртээмж муу, сүрьеэгийн өвчтөнүүд эмчилгээндээ ирдэггүй эсвэл эмчилгээгээ бүрэн хийлгэдэггүйгээс өвчний тархалт ихсэх магадлал өндөр байдаг байна.

МУНЭХБ төслийн хүрээнд орон нутгийн ИНБ-ын сүлжээний удирдлага дор аймгийн оролцогч талууд иргэдийн оролцоотойгоор ИОК-ын аргаар сүрьеэгийн тусламж үйлчилгээг үзүүлэгч болон хүртэгчдээр үнэлүүлэн

АНЭ-ийн сүрьеэгийн тасгийн хүргэж буй үйлчилгээний чанар болон хүртээмжийг сайжруулах зорилго тавьсан. Энэ зорилгод хүрэхийн тулд дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсэн.

Үүнд:

- Гол оролцогч талууд болох ИНБ-ын эвсэл төслийн санааг хамтаар хэлэлцэж төслийн нарийвчилсан чиглэлийг сонгосон. Эрүүл мэндийн салбарыг төсөл хэрэгжүүлэхээр сонгосны дараа аймгийн хэмжээнд сүрьеэгийн өвчний гаралт болон тархалтыг бууруулах зорилгоор аймгийн сүрьеэгийн тасгийн үйлчилгээг сайжруулахаар төслийн зорилтыг [гол чиглэлийг] тодорхойлсон.
- Орон нутгийн ТББ аймаг дахь сүрьеэгийн өвчлөлийн талаарх суурь судалгааг гүйцэтгэсэн.
- ДЕМО байгууллагатай хамтран ажиллах шийдвэрийг гарган ДЕМО-с иргэдийн оролцоотой үнэлгээ хийх арга зүй, зөвлөмжийг авсан. ИОК-ын арга зүй, судалгааны



загвар, хэрэгжүүлэх механизмын талаар ДЕМО-с 5 өдрийн сургалтыг аймгийн оролцогч талуудад зориулан зохион байгуулсан.

- 20 хүнтэй хэрэгжилтийн баг 3 багт хуваагдсан ба баг тус бүр үйлчилгээг үнэлэхдээ: хүний нөөцийн хүрэлцээ, тоног төхөөрөмж, хэрэгсэл, барилга зэрэг сонгон авсан үзүүлэлтүүдээр үнэлсэн. Үнэлгээнд 324 иргэн, 17 эмнэлгийн мэргэжилтнүүд оролцсон.
- Үнэлгээний дүгнэлтэд дүн шинжилгээ хийн үр дүнгийн талаар ойлголтоо нэгтгэх, хамтаараа асуудлаа шийдвэрлэх, “үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө” боловсруулахын тулд нүүр тулсан уулзалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж ажилласан.
- Үйлчилгээ сайжруулах төлөвлөгөөнд тусгагдсан нэн шаардлагатай ажлууд болон үнэлгээний шууд үр дүнд бий болсон шинэ санаачлагуудыг хэрэгжүүлсэн.

Эдгээрээс дурьдвал: сүрьеэгийн эсрэг олон нийтийн мэдээллийн компанит ажлууд, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, цогц эмчлэх төлөвлөгөөний талаар зөвлөх арга хэмжээнүүд, ЭМЯ болон Үндэсний халдварт өвчлөлийн төвийн санхүүжилтээр худалдан авсан зөөврийн үзлэг, оношлогооны төхөөрөмжөөр бүх сумдын иргэдэд сүрьеэгийн урьдчилан сэргийлэх

үзлэг, оношлогоог хийсэн зэрэг багтана. Явуулын оношлогоот ажлын үр дүнд 15 шинэ тохиолдлыг илрүүлэн бүртгэсэн.

Дэд төслийн богино, дунд хугацааны үр дүн

Дэд төсөл тус бүрийн хэрэгжилтийн гарц [бүтээгдэхүүн], үр дүнг баримтжуулсан бөгөөд эдгээрийг нийгмийн эгэх хариуцлагын санаачлагыг бий болгох нөхцөл байдал, бүрдлийг бий болгоход оруулсан хувь нэмрээр үнэлснийг доор харуулав:

1. Төрийн байгууллагын эрэлт, нийлүүлэлт, хариуцан тайлагналтыг сайжруулахад чиглэсэн НЭХ-ын үйл ажиллагааг төлөвлөсөн байдал

Төслийг хэрэгжүүлж эхлэх үеэс аймгийн ИНБ-ын зөвлөл нь бүх оролцогч талуудыг байлцуулан аймаг дахь сүрьеэгийн өвчний тархалт, өвчлөлтэй тэмцэх арга зам, ойлголтыг нэгтгэж чадсан. ИНБ-ын сүлжээний 19 хяналт үнэлгээний гишүүн, АЭМГ, АНЭ-ийн сүрьеэгийн тасгийн ажилтнуудын сүрьеэ өвчний талаар болон өвчнийг эдгээх алхмуудын талаарх ерөнхий ойлголтод суурилан ИОК-ын арга зүй, хэрхэн ашиглах талаар сургалтыг

зохион байгуулсан. Үнэлгээний хүрээнд барилга, байгууламжийн нөхцөл, хүний нөөц/мэргэжилтний хүрэлцээ, тоног төхөөрөмж, олон нийтийн сүрьеэгийн боловсрол болон диспансерийн [амбулаторийн] үйлчилгээг тус тус үнэлсэн.

ИОК-ыг ашиглан АНЭ-ийн сүрьеэгийн тасгаас сүрьеэгийн өвчтөнд үзүүлж буй үйлчилгээний талаар хэрэглэгчдийн үнэлгээ [санал], сэтгэл ханамжийн талаар мэдээлэл цуглуулсан. Судалгаанд 324 иргэн, 17 эмнэлгийн мэргэжилтэн оролцжээ. Судалгаанд оролцсон бүлгүүдийн үнэлгээ харилцан адилгүй байсан бөгөөд нүүр тулсан уулзалт, хэлэлцүүлгийн суурь хэлэлцэх мэдээлэл болсон юм. Иргэд сүрьеэгийн тусламж үйлчилгээг муу гэж үнэлсэн бол эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд боломжийн гэж үнэлжээ.

Үнэлгээний үр дүнгийн талаар оролцогчдын ойлголтыг нэгтгэх, хамтарсан яриа, хэлэлцүүлэг өрнүүлэх зорилготой нүүр тулсан уулзалтаар оролцогч талууд үнэлгээний зөрүүтэй байдлыг хүлээн зөвшөөрч үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө хамтран боловсруулсан байна. Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан талууд (ИНБ-ын сүлжээ, АЭМГ, ЗДТГ-ын төлөөлөл) сүрьеэгийн үйлчилгээнд тулгарсан асуудлууд, иргэдийн сэтгэл ханамжгүй байдлыг шийдвэрлэх арга замыг олохоор хариуцлага хүлээсэн.

2015 онд байгуулагдсан 28 гишүүн байгууллагатай ИНБ-ын сүлжээ нь орон нутгийн засаг, захиргаа, жижиг дунд бизнес эрхлэгчид, уул уурхайн компаниудын оролцоот 4 талт гэрээг байгуулж ажилласнаас хойш анх удаа засгийн газрын хөтөлбөр, төрийн үйлчилгээнд үнэлгээ хийн тулгамдсан асуудалд [объектив байдлаар] санал дүгнэлт гаргаж ажилласныг энд онцлон дурьдах нь зүйтэй.

Улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөхтэй (ЗД болон бусад томилогдсон албан тушаалтнууд өөрчлөгдөх тохиолдолд) хамааралгүйгээр тус гэрээ нь хүчин төгөлдөр хэвээр байх ба оролцогч талууд уул уурхайд хамтран ажиллагч орон нутгийн үйлдвэрлэгч (жишээ нь ногоочид), жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих юм.

2. Дунд хугацааны үр дүн: Иргэд чадавхжих, орон нутгийн засаглал болон эрүүл мэндийн үйлчилгээ сайжрах чиглэлээр гарсан тодорхой үр дүн

Засаглал: Орон нутгийн удирдлагын зүгээс иргэдээс орон нутагт шаардлагатай дэд бүтцийн хэрэгцээг тодорхойлох ОНХС-ийн хэлэлцүүлгийг багийн хурлаар хийж иргэдийн оролцоог хангаж ажилладаг болохоо аймгийн НБХ хэлсэн. Иргэдийг ОНХС-ийн төлөвлөлт болон хяналт үнэлгээнд оролцуулж буй боловч ихэнхидээ

дэд бүтэцтэй холбогдох санал дэмжигддэг байна.

МУНЭХБ төслийн хүрээнд хэрэгжиж буй дэд төслийн туршлага нь шинэ зүйл бөгөөд төслийн эхэн үед орон нутгийн удирдлагын хувьд төслийг ойлгоход бага зэрэг бэрхшээлтэй байсан. Тэдний ойлголтоор [төслийн/нийгмийн эгэх хариуцлагын] зорилго нь төрийн үйлчилгээг үйл явц гэдэг утгаар нь сайжруулах болон иргэд засаглалын нэг бүрэлдэхүүн болохын хувиар үүрэг хариуцлага [төрийн үйлчилгээг хүргэх] хүлээх явдал гэж үзсэн. Төслийн талаарх уламжлалт ойлголт нь “мөнгө”, дэд бүтцийн төсөл [материаллаг] хэлбэрээр байсан ба төрийн үйлчилгээ, үйл явцыг сайжруулах тухай биш байв. Орон нутгийн албан хаагчид төслийг ойлгоход тодорхой хугацаа зарцуулсан боловч эцэст нь тэд засаглал болон иргэдийн оролцооны талаарх ойлголт, хандлагаа өөрчилсөн байна. Аймгийн ЗДТГ-ын НБХ-ын ажилтны дүгнэснээр тэд иргэдийн оролцооны ач холбогдол, үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрүүдэд иргэдийн саналыг хэрхэн тусгах талаар олж мэдсэн байна.

Нөгөө талаар иргэд асуудал бүрт төрийг буруутгах, шүүмжлэх хандлагатай байсан. Дэд төсөл хэрэгжсэнээр иргэд асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх үйл явцад оролцож асуудлыг цогц байдлаар харж чадсан.

Эцэст нь төр болон хөгжлийн төслийн хувьд заавал санхүүжилт

шаардахгүйгээр асуудлыг шийдвэрлэн тодорхой үр дүнд хүрч болохыг, төсөл хэрэгжүүлэх өөр арга зам байдаг болохыг оролцогч талуудыг идэвхижүүлэн тэдний оролцоотойгоор асуудлыг хамтран шийдвэрлэснээр харуулж чадсан. Ялангуяа эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, сүрьеэгийн өвчлөлийг бууруулах талаар орон нутгийн удирдлага асуудлуудыг мэддэг байсан боловч өвчлөлийн гаралт, тархалтыг бууруулах талаар тодорхой амжилт гаргаж чадаагүй байв.

Дэд төслийн хүрээнд орон нутгийн удирдлага асуудлын чухлыг ойлгон холбогдох талуудын хамтын ажиллагааг хангаж иргэний нийгмийн байгууллагын цуглуулсан баримт нотолгоонд суурилсан иргэдийн санал, хэрэгцээг тусгасан юм. Цуглуулсан мэдээлэл дээр суурилан холбогдох агентлагууд (жишээ нь шинэ тохиолдол болон тархалтын нөхцөл байдал зэрэг дээр) хөтөлбөр болон үйл ажиллагааны зорилгыг чиглүүлэн тулгамдсан бодит асуудлыг шийдвэрлэхээр 2018 оны төсвийн төсөлд тусгажээ (Жишээ нь сүрьеэгийн барилга, оношлогооны төхөөрөмж худалдан авах, 4 ӨЗМТ байгуулах зэрэг саналууд).

Чадавхжуулах: Иргэд болон ИНБ-уудын хувьд нийгмийн эгэх хариуцлага нь цоо шинэ ойлголт байв. Аймаг дахь засаглалын үйл явц үргэлж дээрээс доош чиглэлтэй байсан бол дэд төслийн хувьд доороос дээш буюу энэ нь төрийн

тодорхой үйлчилгээнд иргэд үнэлгээ, санал дүгнэлт өгөх тухай байв. Өөрөөр хэлбэл иргэд зөвхөн төрийг буруутгах биш уг асуудалд өөрсдөө хариуцлага хүлээх тухай байв. ИНБ-ын сүлжээ нь төртэй адилаар асуудлыг тодорхойлоход оролцож, учир шалтгаанд дүн шинжилгээ хийн хариуцлага хүлээн ажилласан.

Төрийн үйлчилгээ: ИОК-ын үнэлгээ, нүүр тулсан уулзалтад оролцсон оролцогч талуудын санал, ИНБ-ын үйлчилгээ сайжруулах төлөвлөгөөний төсөл дээр үндэслэн АЭМГ болон АНЭ хамтран төрийн үйлчилгээг сайжруулах талаар тодорхой ажлуудыг хэрэгжүүлсэн.

АНЭ-ийн үйл ажиллагаанд ИНБ хяналт, үнэлгээ хийх явцад эмч эмнэлгийн мэргэжилтнүүд эхэн үедээ таагүй хандаж өөрсдийгөө хамгаалж байсан.

Учир нь иргэдийн өгсөн үнэлгээ тэдний өөрсөддөө өгсөн үнэлгээнээс доогуур байсан. Гэсэн хэдий боловч үүний дараа үйлчилгээ сайжруулах тодорхой ажлууд хийгдсэн. Энд онцлох нь:

- Иргэний нийгмийн байгууллага, эрүүл мэндийн салбарын ажилтнууд хамтран өвчлөл бууруулах, эмчлэх төлөвлөгөөг боловсруулж ИТХ-д танилцуулсан
- Сүрьеэгийн өвчтнүүдэд зориулсан сүрьеэгийн төв барих ажлыг багтаасан сүрьеэгийн үйлчилгээг сайжруулах цогц төлөвлөгөөний талаар албан ёсны шийдвэр батлагдсан
- Явуулын үзлэг оношлогоог бүх сумдад хийж шинэ өвчлөлийг илрүүлсэн. Явуулын оношлогооны төхөөрөмжтэй болсноор АНЭ

аймгийн бүх хүнд хүрэх боломжтой болж 17 сумын 16 сумын иргэдэд сүрьеэгийн оношлогоо хийв.

1. Сүрьеэгийн өвчлөлийн тархалтыг бууруулах, сүрьеэгийн талаар олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх олон нийтийн мэдээллийн компани арга хэмжээнүүдийг зохион байгуулав (эмэнд дасал болохоос урьдчилан сэргийлэх, ялангуяа төгс эмчилгээг хийх талаар).

3. Тогтвортой байдлыг хангах механизм

Сэлэнгэ аймаг дахь нийгмийн эгэх хариуцлагын санаачлагыг тогтвортой байлгах, түгээн дэлгэрүүлэхэд чухал 3 бүрдэл хэсэг байна. Эдгээр нь бодлогын орчин бий болж хариуцах байгууллага [институцийн] тодорхой болсон ба хэрэгжүүлэх механизм бүрдсэн, бүтээлч оролцооны суурь тавигдсан болон иргэдийн оролцоо, иргэдийн хяналтын талаарх хандлагад өөрчлөлт гарсан зэрэг болно.

- Үйлчилгээ үзүүлэгч байгууллага дан ганцаараа үйлчилгээ сайжруулах төлөвлөгөө боловсруулаагүй бөгөөд төлөвлөгөөг боловсруулахад хамааралтай бүх талууд оролцож саналаа өгсөн. Төслийн эхэн үед эмнэлгийн мэргэжилтнүүд өөрсдийгөө үнэлүүлж байхдаа эргэлзээтэй хандаж байсан хэдий ч одоо

Сэлэнгэ аймгийн ИНБ-ын эвслийн товч танилцуулга

Үүсэл

2015 онд 25-н гишүүн байгууллагууд нэгдэн орж байсан бол энэ оны 9-р сарын байдлаар 28-н ТББ, 15-н иргэний төлөөлөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын үйл ажиллагааны хураангуй

Сэлэнгэ аймгийн Иргэний нийгмийн байгууллагуудын холбоо нь/ИНБХ/ нь ашгийн төлөө бус нийгэмд үйлчилдэг байгууллагуудын нэгдэл бөгөөд “Хариуцлагатай нийгэм”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хариуцлагатай уул уурхай” хөтөлбөр, “Залуучуудын хөгжлийг дэмжье” гэсэн гурван хөтөлбөртэй.

Алсын хараа

Сэлэнгэ нутгийнхаа хөгжил дэвшлийн төлөө төр, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн байгууллагууд оролцсон олон талт түншлэлийг бий болгож иргэдийн нийгэм дэх бүтээлч оролцоог хангаж, чадавхижуулах замаар Төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, хяналтын тогтолцоотой болгоно.

уг төлөвлөгөөг ИТХ-р батлан албажуулсан.

- Сэлэнгэ аймаг 2015 онд байгуулагдсан ИНБ-ын эвсэл нь 28 ТББ, 15 гишүүнтэй албан ёсны иргэний нийгмийн байгууллагын сүлжээтэй. “Нэг зорилгын төлөө нэгдэж” олон нийтэд зөвшөөрөгдсөн байгууллага болох зорилготой тус байгууллага нь өнөөгийн байдлаар МУНЭХБ төслөөс гадна Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн “Орон нутгийн цогц хөгжил-түншлэл” төсөл болон Азийн Хөгжлийн банкны хөрөнгө оруулалттай “Сэлэнгэ аймгийн Жендэрийн нөхцөл байдал, институцийн дүн шинжилгээ” судалгааны төслүүдийг хэрэгжүүлсэн туршлагатай.
- Гурван оролцогч тал (орон нутгийн захиргаа, үйлчилгээ үзүүлэгч, ТББ-д) төрийн үйлчилгээ, засгийн газрын хөтөлбөрт иргэний оролцоог хангах, хяналт үнэлгээ хийх талаар талархан дэмжиж хандлагын өөрчлөлт бий болсон. Төслийн эхэнд тэд уг ойлголтыг бүрэн авахад бага зэрэг бэрхшээлтэй тулгарсан боловч дэд төслийн хэрэгжилтийн явцад аргачлал болон төслийн үр дүнд үйлчилгээ хэрхэн сайжирч иргэдэд

хүртээмжтэй болж байгаа талаар нарийвчилсан ойлголттой болсон. Одоогоор эрүүл мэндийн салбараас гадна бусад салбарт аргачлалыг хэрэгжүүлэх, шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог хангах, шийдвэрт иргэдийн саналыг тусгах, бодлого боловсруулах, хөгжлийн төслийг хэрэгжүүлэх талаар нэгдсэн сонирхол [ойлголт] бий болсон.

Үнэлгээ

Сэлэнгэ аймагт хэрэгжсэн дэд төсөл нь цаашид энэ туршлагыг түгээн дэлгэрүүлэхүйц хэд хэдэн шинж чанарыг агуулсан. Оролцогч талууд уг төслийн загварыг өргөн цар хүрээнд, өөр хөтөлбөрийн хүрээнд давтан хэрэгжүүлэх боломжтой. Загварын давуу талуудыг дурьдвал:

- Тулгамдсан асуудал, цар хүрээ, асуудлыг шийдэх аргачлалыг сайтар тодорхойлсон байлаа. Асуудлын төв нь [фокус] нарийн хүрээнд тодорхойлогдсон (жишээ нь эрүүл мэндийн салбарт тулгамдсан олон асуудлаас сүрьеэгийн өвчлөлийн тархалтыг бууруулах асуудлыг сонгосон нь) боловч асуудлыг тодорхойлох үйл явц нь тогтолцооны болон дүн шинжилгээ хийх чадварыг илэрхийлж байна. Тус дэд төсөл нь нэг дор олон асуудлыг шийдвэрлэх ‘хавх’-нд ороогүй. Үүний оронд тэд асуудал хичнээн том байсан ч зөвөөр хийх, бүтээлч оролцоо, хамтын асуудал шийдвэрлэх явцын талаар оролцогч талуудад зөв ойлголт өгөх талаар чухалчлан ажилласан.
- Аймгийн хөгжлийн төлөө зорилгын доор нэгдсэн албан ёсны ИНБ-ын сүлжээ байгууллагатай, уг сүлжээ хэрэгжүүлэгчээр ажилласан нь ойлголцол бий болгоход хялбар байснаас гадна өргөн хүрээнд хүрч ажилласан. ИНБ-ын сүлжээ нь хоёр харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд үйл ажиллагаа хэрэгжүүлсэн туршлагатай, үр дүн нь ямар байхаас хамаарахгүйгээр ижил зорилгын төлөө хамтран ажиллахаар зүтгэж буй орон нутгийн захиргаанаас хүлээн зөвшөөрөгдсөн албан ёсны түнш юм. Төсөл хэрэгжихээс өмнө тус сүлжээ [эвсэл] нь уул уурхайн үйл ажиллагаанд оролцсон болон нөлөөлөлд нь автсан талуудыг хариуцан орон нутгийн захиргаатай хамтран ажилласан туршлагатай. Улс төрийн нөлөөлөл, сонгуулиас хамаарахгүйгээр орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгч, уул уурхайн компаний хооронд бүтээлч хамтын ажиллагаа бий болгох зорилготой 4 талт хамтын ажиллагааны гэрээг аймгийн ЗДТГ-тай байгуулсан.

- Нийгмийн эгэх хариуцлагын үр өгөөж, зорилгын талаар тодорхой ойлголттой, илэрхийлэх чадамжтай. Үйлчилгээ үзүүлэгчид эхэндээ үнэлгээтэй холбоотойгоор өөрсдийгөө хамгаалж байсан боловч явцдаа олон нийтэд үйлчилгээний талаар мэдээллийг дутуу өгч байснаа хүлээн зөвшөөрсөн. Хамтрагч талууд бүгдээрээ хувь хүмүүс болон хамт олноороо хариуцлага хүлээх, алдааг засах талаар арга хэмжээ авахын чухлыг ойлгосон (жишээ нь асуудлыг шийдэхэд хэн юу хийх байсан боловч юу хийгээгүйг, хэн нэг нь хийж байгаа боловч хангалттай бус байгаа талаар, цаашид хэн нь юу хийх талаар тодорхой мэдээлэлтэй болсон).
- Орон нутгийн удирдлагын зүгээс асуудал хариуцсан хэлтэс, газрууд яаралтай арга хэмжээ авч шийдвэр гарган ажилласан (АЭМГ болон НБХ) бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөг үйлчилгээг хүргэгч байгууллагын түвшнээс гадна хөрөнгө оруулалт, хүний нөөц, тоног төхөөрөмжийн шинэчлэл шаардсан үйл ажиллагаанууд дээр аймгийн ЗДТГ-ын түвшинд тодорхойлон хэрэгжүүлж байна.

Сэлэнгэ аймгийн нэгдсэн үнэлгээ

Нийгмийн эгэх хариуцлагын механизм	Үр дүн			Тогтвортой байдал
	Засаглал	Чадавхжуулах	Төрийн үйлчилгээ	
✓	✓	✓	✓	✓
Нийгмийн эрүүл мэндийн бусад тулгамдсан асуудал, төрийн үйлчилгээ, хөтөлбөрийн хэрэгжилтэд дэд төслийн загварыг давтан хэрэгжүүлэх боломжтой.				

СҮХБААТАР АЙМАГ: ХҮҮХДИЙН АМНЫ ХӨНДИЙН ӨВЧЛӨЛИЙГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ

Сүхбаатар аймгийн дэд төслийг Улаанбаатар хотод төвтэй “Ардчиллын боловсрол төв” (ДЕМО) ТББ-тай хамтран хэрэгжүүлсэн. Эрүүл мэндийн газар, АНЭ, аймаг, сумын засаг даргын тамгын газрын гол албан хаагчдын хамт орон нутгийн ИНБ-ын эвсэл амны хөндийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж болон амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулахыг зорьсон.

Хүүхдийн амны хөндийн эрүүл ахуй муу байгаа асуудлыг иргэдийн санал дүгнэлтийн анхаарлаа хандуулсан гол асуудал хэмээн сонгож авсны шалтгаан нь буйлны өвчлөлийн тохиолдол нэмэгдэж, амны хөндийн эрүүл ахуйн доройтолтой холбоотой.

Дэд төслийн саналд дурдсан мэдээллийн дагуу аймагт 16 хүүхдийн шүдний эмч нар 10,456 хүүхэд бүхий 16 сургууль, 23 цэцэрлэгт үйлчилж байна. Үйлчлүүлж буй хүүхдийн тоо, хангалтгүй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж болон Эрүүл мэндийн хичээлийг суурь боловсролын хөтөлбөрөөс хассанаас үүдэн амны хөндийн эрүүл мэндийн асуудалтай


хүүхдүүд АНЭ-ийн ачааллыг нэмэх нь аргагүй байна.

Аймгийн нэгдсэн Эмнэлэг дөнгөж дөрвөн эмчтэй хоёр шүдний кабинеттэй атал 68,000 үйлчлүүлэгчдэд үйлчилж байгаа буюу аль хэдийнэ хүлээн авах хүчин чадал нь дээд цэгтээ тулаад байхад нэмж дарамт учруулж байна.

МУНЭХБТ дэд төслийн хүрээнд оролцогч талууд залуучууд, хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийн үйлчилгээ болон амны хөндийн эрүүл ахуйн боловсролыг ИОК ашиглан ийм төрлийн

үйлчилгээг оролцоот үнэлгээ ба харилцан мэдээлэл солилцсоноор сайжруулахыг зорьсон. Үүнийг бодит үйл ажил болгохын тулд Аймгийн Засаг даргатай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсны дараа доорхи түлхүүр ажлуудыг орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын манлайллын дор хэрэгжүүлсэн:

1. Аймгийн нөхцөл байдлыг тодорхойлох, үйлчилж буй бодлогыг дүгнэх, амны хөндийн эрүүл мэндийн дадал хэвшлийг зохицуулж буй хууль эрхзүйн болон бодлогын орчинг үнэлэхийн тулд 1000 хүүхэд, 90 эцэг эхчүүдийн төлөөллийг оролцуулсан анхан шатны судалгаа болон бүлгийн яриа хэлэлцүүлгийг аймагт зохион байгуулсан.
2. УБхотодтөвтэйДЕМОбайгууллагын удирдан зохион байгуулсан ИОК ашиглан оролцогч талуудын санал дүгнэлтийг цуглуулах сургалтанд Иргэний нийгмийн байгууллага болон төр засгийн орон нутгийн багийн гишүүд (нийт 20) оролцсон.



3. ИОК-н үнэлгээг 520 хүүхэд болон эцэг эхчүүд мөн 94 үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дунд явуулав. ИОК нь дөрвөн гол асуудлууд дээр оролцогчдын санал дүгнэлтийг авсан: амны хөндийн эрүүл мэндийн зан үйл ба дадал; амны хөндийн эрүүл мэндийн ажилтан мэргэжилтний хүртээмж (шүдний эмч, сувилагч); шүдний багаж, тоног төхөөрөмжийн хүрэлцээ болон сургууль, эрүүл мэндийн байгууллага, эцэг эхийн уялдаа холбоо.
4. Аймгийн төвийн 4 сургуулийн өсвөр үеийн нийт 2558 хүүхдээс 2522 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаас 45,5% буюу 1150 хүүхэд шүдний өвчлөлтэй гарсан (нийт өсвөр насны хүүхдийн 99%-г хамруулсан).
5. ИОК-ы судалгааны үрдүндүндэслэн хамтран боловсруулсан тулд үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, аймгийн засаг даргын тамгын газар болон эрүүл мэндийн газрын төлөөлөгчдийн хооронд нүүр тулсан уулзалт явуулж үнэлгээний үр дүнг тэнцвэржүүлж, асуудлын суурь шалтгаан болон зохистой үйл ажиллагааны чиглэлийг хамтран боловсруулсан Үйлчилгээ сайжруулах төлөвлөгөөний дагуу тодорхойлсон. Үйлчилгээ сайжруулах төлөвлөгөөнд нийт 22 үйл ажиллагааны саналыг тусгасан байна.

Дэд төслийн богино, дунд хугацааны үр дүн

Дээр жагсаасан дэд төслийн хэрэгжилт болон үйл ажиллагааны үр дүнг баримтжуулж илүү үр дүнтэй нийгмийн эгэх хариуцлагын санаачлагын гол элементүүд болон агуулгын хүчин зүйлүүдтэй жишиж үзсэн ба эдгээр нь:

1. Төрийн байгууллагын эрэлт, нийлүүлэлт, хариуцан тайлагналтыг сайжруулахад чиглэсэн НЭХ-ын үйл ажиллагааг төлөвлөсөн байдал

Хэрэгжүүлэгч багийн зүгээс санал болгож, төлөвлөсөн бодит үйл ажиллагаанууд нь аймагт засаглалыг сайжруулахад нийгмийн эгэх хариуцлагын арга барилыг турших боломж олгосон. Үүний үр дүнд бий болсон гол үр дүнгүүд нь:

- ИНБ-ын эвсэл, аймаг, төр засгийн төлөөлөгчид болон эмнэлгийн эмч нар дэд төслийн загвар, ИОК-р дамжуулан үнэлгээтэй холбоотой асуудлууд ба түүний шинж чанарууд, үйлчилгээ сайжруулах төлөвлөгөөний орцын бүтцийг боловсруулж санал гаргах ажлын нэг хэсэг болсноор хамтран асуудлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэсэн.
- ИОК-н судалгаа болон бүлгийн ярилцлага нь иргэд, үйлчилгээ

үзүүлэгч нарт үйлчилгээний чанар, эмнэлгийн тоног төхөөрөмж болон ажилтан мэргэжилтнүүд, нийтийн эрүүл мэндийн боловсролын механизмыг үнэлэх боломж олгосон. Судалгаа ба бүлгийн ярилцлага үр дүнг холбогдох талуудад объектив дүгнэлт өгөхөд ашигласан.

- Иргэдээс авсан харьцуулсан санал дүгнэлтийг нүүр тулсан уулзалтуудын үеэр үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хийсэн дотоод үнэлгээний үр дүнтэй тэнцвэржүүлсэн.
- ИНБ-ын эвсэл үйлчилгээ сайжруулах талаар зөвлөмжийн жагсаалтыг боловсруулан танилцуулсан. Эдгээрийг дараа нь төрийн холбогдох байгууллагууд хүлээн авч хэрэгжүүлсэн. Зөвлөмжийн жагсаалт 22 үйл ажиллагаа ба саналуудыг тодорхойлсон. Уг үнэлгээний тухайд зөвхөн гурван үйл ажиллагааг хэрэгжүүлэх үлдээд байна.
- Амны хөндийн эрүүл мэндийн аянг ИНБ-ын сүлжээтэй хамтран зохион байгуулж явуулсан. Энэ нь хоёр зорилготой байсан: олон нийтийн эрүүл мэндийн мэдээллийн аян буюу хүүхэд болон эцэг эхчүүдэд амны хөндийн зөв дадлын тухай боловсрол олгох; мөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хувьд сургуулийн хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийн асуудалтай хүүхдүүдийг оношлох, эмчлэх.

2. Дунд хугацааны үр дүн: Иргэд чадавхжих, орон нутгийн засаглал болон эрүүл мэндийн үйлчилгээ сайжрах чиглэлээр гарсан тодорхой үр дүн

Засаглал: Иргэд Нүүр тулсан уулзалт дээр ИОК-ын үр дүнг аймгийн удирдлага, шийдвэр гаргагч нарт баримт нотолгоотой танилцуулж нөлөөлснөөр аймгийн Засаг дарга А/493 тоот захирамж гаргаж хүүхдийн шүдний кабинет байгуулах, явуулын кабинетийн багаж төхөөрөмж худалдан авах 23,697,800 төгрөгийн эх үүсвэрийг ЗД-ын нөөц хөрөнгөөр шийдвэрлэсэн.

Засаг даргын тамгын газар үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээн дээр зөрүү байгаа гэдгийг мөн ИНБ-ын хяналт болон судалгааны дүн, бүлгийн ярилцлага баримтанд үндэслэн гаргасан зөвлөмжийг хүлээн зөвшөөрч, үнэлснээр уг ажил биелэлээ олсон.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд тулгарч буй бэрхшээлүүдийн талаарх санал дүгнэлтийг сонсох нь орон нутгийн засаг, захиргаа “зөв үйлчилгээг зөв хүмүүст зөв аргын дагуу хүргэх” боломж олгож байна хэмээн Засаг дарга хэлсэн. Төрийн үйлчилгээнд ТББ-ууд мониторинг хийх гэрээ байгуулсан ба энэ ажлын хүрээнд дэд төслийн хүрээнд чадавхижуулсан 46 иргэн оролцох боломжтой юм.

Чадавхжуулах: Төсөл боловсруулалт болон хэрэгжилтэд оролцох нь ИНБ-ын манлайлагчдын үзэл бодол, ойлголтыг нь өөрчилсөн. Нэгдүгээрт

“Хүмүүсийн санал дүгнэлтийг сонссоноор зөв үйлчилгээг, зөв хүмүүст зөв аргын дагуу хүргэх боломж олгож байна.”

- Сүхбаатар аймгийн Засаг дарга
З.Энхтөр

иргэдийн мэдэрч байсан тодорхой бэрхшээлүүдийн суур асуудлууд мөн төр засгаас нэгжүүддээ хангаж өгөх ёстой үйлчилгээний стандартуудын талаар ойлголттой байх нь манлайлагч нарт төр засгийн гүйцэтгэл, хөтөлбөр болон үйлчилгээг хянах, үнэлэх эх сурвалж бүхий мэдлэг, үндэс суурийг гаргаж өгсөн. Энэ нь иргэдэд нөлөөлж буй асуудлуудын талаар харилцан яриа, ярилцлага өрнүүлэх боломж олгосон. Түүнчлэн эс бөгөөс төрийн зүгээс хайхрахгүй өнгөрч болох асуудлуудын хувьд хэрхэн хамтдаа тунгаан бодож, хамтын үйл ажиллагааны хүчээр төр засгийг алхам хийхэд хүргэж буйд сайшаалтай хандсан.

Хоёрдугаарт эрх мэдэлтэн хүмүүсээс эгэх хариуцлага шаардах нь иргэдийн зүгээс өөрсдөөс нь хариуцлагатай байхыг шаардаж байсан. Энэ тохиолдлоор ялангуяа эрүүл мэндийн боловсрол, өвчнөөс сэргийлэх болон эрүүл мэндийг хүсэмжилж буй зан үйлийн тал дээр эрүүл мэндийг хэрхэн үйлчилгээ үзүүлэгч талууд болон үйлчилгээ хүртэгч талуудын хоорондох нийтлэг үүрэг хариуцлага гэж үздэгийг харуулсан. Түүнчлэн энэ нь сайн дүгнэлт гаргаж өгөх, мөн

зөвхөн хөтөлбөр эсвэл үйлчилгээг тодорхой зорилгогүйгээр үнэлдэг гэсэн зэмлэлээс зайлсхийхэд баримт шаардлагатай байдаг ба ялангуяа хэрэв эхэн үед орон нутгийн төр засгийн албан тушаалтнууд өөрсдөд нь ирж буй хариу үйлдлүүдийг таашаахгүй байгаа нөхцөлд.

Эцэст нь төр засагтай нягт ажилласнаар иргэд олон нийтийн салбарын үйл ажиллагааны талаар илүү гүнзгий ойлголттой болсон. Дэд төслийн хэрэгжилт нь тэднийг бүх асуудлыг нөөцийг хангаж өгснөөр шийдвэрлэхгүй харин нөлөөлөл, хамтын ажиллагаа болон хөтөлбөр, төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээ шаардлагад илүү нийцүүлэхийн тулд төр засагтай хамтран ажилласнаар шийдвэрлэнэ гэдгийг ойлгуулсан.

Төрийн үйлчилгээ: АНЭ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд ИНБ-ын сүлжээний зүгээс гаргасан зөвлөмжийг тусгасан. Эмнэлгийн захиргаа болон ажилтан, мэргэжилтнүүд асуудлыг нухацтай авч үзсэний шалтгаан нь хэдийгээр эмнэлэг болон Эрүүл мэндийн газар аль хэдийнэ мэдэж байсан боловч төсвийн хзгаарлалтаас үүдэн ямар нэг зүйл (жишээ нь, чанар болон ажилтнуудын талаарх шаардлагатай стандартууд) хийх боломжгүй гэж бодож байсан асуудлуудыг баталж, гаргаж өгсөн.

Судалгааны дүн болон бүлгийн ярилцлага нь Сум болон Аймгийн Засаг дарга нараас эмнэлэгт санхүүжилтийн дэмжлэг хүсэх хөшүүрэг болсон ба улмаар хоёр

тамгын газрын албан тушаалтнууд нийт 31.9 сая төгрөгийг (Аймгийн засаг даргаас 28.9 сая төгрөгийг, нэмж 3 сая төгрөгийг сумын Засаг даргаас) өгч шүдний тоног төхөөрөмж худалдан авах, өргөтгөл хийх, материаллаг баазыг нөхөн сэргээх, нэмж нэг мэргэжилтэн ажиллуулах боломжтой болсон. Баруун-Урт сум амны хөндийн эрүүл мэндийн хөтөлбөр батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хөтөлбөрийн үр дүнд аймгийн төвийн 4 сургууль үр шимийг хүртэх юм.

Түүнчлэн санал болгосон үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг хэсэг болгон эмнэлэг өөрийн ажилтнуудаа илүү мэргэшүүлэхийн тулд мэргэжлийн сургалтанд явуулах ба нийгмийн эрүүл мэндийн аяны шаардлага, зохион байгуулалтыг онцолж ажиллана (жишээ нь иргэдийг өвчлөхөөс сэргийлэх).

Хэдийгээр эмнэлэг ард иргэдээс хоёр, гурван гомдол, санал дүгнэлт авч хэвшсэн боловч тэд хэзээ ч дэд төслийн хүрээнд авсан шигээ ИНБ-даас бодитой, зохион байгуулалттай дүгнэлт авч байгаагүй.

Үүнийг үр дүнтэй гэж үзэн Эрүүл мэндийн газар болон эмнэлгийн албан тушаалтнууд иргэдийн оролцоог хэрхэн ижил байдлаар бусад хөтөлбөр, үйлчилгээнд (жишээ нь боловсролын асуудалд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх) хэрэгжүүлж болох талаар судлах сонирхолтой байна.

3. Тогтвортой байдлыг хангах механизмын талаар.

Дэд төслийг хэрэгжүүлэх цаг хугацаа болон нөөцийн хязгаарлагдмал байдлаас үл хамааран орон нутгийн оролцогч талууд санаачлагыг төслийн

хугацаанаас нь илүү урт хугацаанд хэрэгжих боломжтой болгож, орон нутгийн төр засгийн бусад хөтөлбөр, үйлчилгээнд хяналт тавьж, хамтран ажиллах зарим механизмуудыг бий болгож чадсан.

Албан ёсоор байгуулагдсан ИНБ-ын эвслийн эрх ба үүрэг хариуцлагын онцлогууд

4.1 ТББ-ууд Сүлжээнд төрийн бус байгууллагууд чөлөөтэй нэгдэх, сүлжээнд нэгдсэн байгууллагуудад эрх тэгш харилцах, нэгдсэн бодлого удирдамжаар хангах.

4.2 Төрийн бус байгууллагын тухай хуулийн дагуу байгуулагдсан, удирдах зөвлөл, хяналтын зөвлөлтэй, санхүү, хүний нөөцийн чадавхитай, эрх ашиг, сонирхлын зөрчилгүй байх.

4.3 Сүлжээ нь аймаг, орон нутгийн хөгжлийн гарцыг тодорхойлоход санал оруулах зөвлөлдөх, тодорхой асуудлаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах.

4.4 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, бүтээгдэхүүн нийлүүлэх үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх, холбогдох хууль тогтоомжуудыг сурталчлах, сургалт явуулах ажлыг төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах.

4.5 Хувийн хэвшлийн байгууллагуудад зах зээлийн эрэлт хэрэгцээ, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа авахад нь арга зүйн туслалцаа үзүүлж, жижиг дунд үйлдвэрлэл байгуулах төсөл болон бизнес төлөвлөгөө боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх, гадаад дотоодын хандивлагч байгууллагуудтай холбоо харилцаа тогтооход нь зуучлан туслах.

4.6 Хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд олон нийтэд төрийн нууцад үл хамаарах мэдээ, мэдээллийг шуурхай, ил тод, нээлттэйгээр хүргэх.

4.7 Төрийн зарим ажил үйлчилгээг иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх сонгон шалгаруулалтанд төсөл боловсруулж оролцох, салбар мэргэжлийн хүрээнд гэрээгээр санхүүжилт авч ажиллах.

4.8 Иргэдийн санал асуулга зохион байгуулах, хяналт шалгалт хийх, үр дүнг нийтэд мэдээллэх.

4.9 Төрийн байгууллагаас гаргасан шийдвэрийг сурталчлах, энэ талаар байр сууриа илэрхийлэх, мэдэгдэл гаргах.

Нэгдүгээрт ИНБ-ын эвслийн өөрийнх нь дотроос мөн төр засгийн хамтрагч талууд аль алинтай нь ажлын харилцааг бий болгож, бэхжүүлж чадсан. Түүнчлэн хамтарч ажиллах эерэг туршлагаас үүдэн (“ИНБ-ын нэг дуу хоолой” адил) төр засагтай хамтран тэд төрийн бусад хөтөлбөрүүд, үйлчилгээнүүдэд уг загварыг ашиглах хүсэлтэй байгаагаар илэрхийлсэн. Үнэндээ сумын төр засгийн гүйцэтгэл болон үйлчилгээг хянахын тулд орон нутгийн удирдлага аль хэдийнэ Үйлдвэрчний эвлэлтэй (ИНБ-ын сүлжээний гишүүн), 11 сумын Засаг дарга нартай гарын үсэг зурсан гэрээ байгаа. Түүнчлэн орон нутгийн төр засаг болон ИНБ-ын төлөөлөгчдийн үзэж буйгаар боловсрол, ус, Аймгийн нэгдсэн эмнэлгийн (сүрьеэгийн тасгаас гадна) үйлчилгээний чанар болон хүртээмжийг хянахад ийм төрлийн гэрээг ашиглаж болно.

Орлогч Засаг дарга загварыг бусад төсөл, хөтөлбөрүүдэд хэрэгжүүлэх хүсэлтэй буйгаа өөрөө илэрхийлсэн. Түүний хэлснээр ИНБ-ууд сумын төр засгийн нэгжүүдийн гүйцэтгэлийг үнэлэх төр засгийн бие даасан хамтран ажиллагчийн үүргийг гүйцэтгэж болно. Түүний үзэж буйгаар Эрүүл мэндийн газрын зүгээс санал болгосон үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн төр засаг

дэмжиж буй нь уг оролцооны үнэ цэнэд өөрөө итгэж буй хэрэг юм. Тэрээр уг төлөвлөгөөг батлуулж Зөвлөх хорооны баталгаажилтыг авахын тулд төлөвлөгөөг дэмжсэн. Эрүүл мэндийн газрын санал болгосон үйл ажиллагааны төлөвлөгөө нь иргэний хяналтын санаачлагыг саналдаа тусгасан.

Үнэлгээ, зөвлөмжүүд

Сүхбаатар аймгийн дэд төсөл нь уг туршлагыг аймгийн бусад үйлчилгээ болон хөтөлбөрт ашиглахад бэлэн болгож буйгаараа хэд хэдэн давуу талтай. Орон нутгийн төр засгийн нэгжийн хувьд иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулах тал дээр дур сонирхолтой, урьдчилсан ойлголттой мөнтэднийг оролцуулахыг хүлээн зөвшөөрдөг. ИОК-ын судалгаа болон бүлгийн ярилцлагаас авсан санал дүгнэлтээс үзэхэд ИНБ-ууд төр засаг хэдийгээр мэдэж байсан боловч хайхрахгүй байсан үйлчилгээний хүртээмжийн заагийн талаар арга хэмжээ авч, шийдвэрлэхийг зорьж мэдээллийг хөшүүрэг болгож байсан. Түүнчлэн ИНБ-уудын оруулах үүрэг хариуцлагыг талархан хүлээж авдаг учраас мөн эрүүл мэндийн салбарын зөвлөх шинэчлэлийн тэргүүлэгч адил байсан учраас эдгээр хүсэлтүүдийн

хувьд нэн даруй арга хэмжээ авахдаа ИНБ-ын оролцоо болон үүрэг амлалтыг бий болгох орон нутгийн бодлого, хөтөлбөрүүдийг баталж оролцоог үргэлжлүүлэх хүсэлтэй байгаагаар илэрхийлсэн. ИНБ-уудын хувьд арга хэрэгсэл, оролцооны явц болон оролцогч талуудын санал дүгнэлтийг цуглуулж, танилцуулах алхмуудын талаар хөгжсөн ойлголттой.

Дараах хэд хэдэн хэсгийг сайжруулах шаардлагатай байна. Үүнд:

- Хэдийгээр аймагт ИНБ-ууд зохион байгуулалттайгаар оршиж буй боловч тэд нэгдмэл байдал дээрээ үндэслэн үндэс сууриа цаашид бэхжүүлж, орон нутгийн төр засгийг хөтөлбөр, үйлчилгээнүүдийн хүртээмжийн (жишээ нь өөрийн үүрэг хариуцлагыг бодит үйл хэрэг болгох, дээрх хайрцгийг үзэх) тал дээр илүү эгэх хариуцлагатай болгоход санал нэгдэж ажиллах хэрэгтэй. Үүнтэй зэрэгцэн төр засгийг хянах мөн оролцуулахад илүү идэвхтэй манлайллыг бэхжүүлж, бий болгох хэрэгтэй. Хүчний тэнцвэр нь цаанаасаа үүрэг хариуцлага үүрч буй талууд руу хазайсан байдаг (орон нутгийн түвшинд сонгогдож, томилогдсон албан тушаалтнууд), иргэний нийгмийн байгууллага тоо болон техникийн мэргэшсэн

байдлаар уг хүчийг тэнцвэржүүлж болно. Тэдний ур чадвар зөвхөн нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгсэл ба арга барилын хувьд чухал байгаад зогсохгүй санал дүгнэлтийг үндэслэл болгон баримт цуглуулах, ялангуяа илүү ярвигтай, адармаатай хөтөлбөрүүд, үйлчилгээний хувьд (амны хөндийн эрүүл мэнд олон нийтэд хүчтэй асуудал мөн гэдэг нь ойлгомжтой боловч түүнээс илүү том, илүү яаралтай шийдвэрлэх асуудлууд байгаа бөгөөд тэдгээрт санал дүгнэлт өгч, тэдгээрийг сайжруулах хэрэгтэй).

- Эрүүл мэндийн газар болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд тэдиргэний нийгмийн байгууллагуудыг зөвхөн олон нийтийн эрүүл мэндийн талаар олон нийтийг хөдөлгөгч эсвэл мэдээлэл олгогч гэж харахаас илүү хөтөлбөр боловсруулалт, хэрэгжилтийг хамтран бүтээгч, эн тэнцүү талууд болон хамтран ажиллагчид гэдэг талаас нь харах хэрэгтэй.

Сүхбаатар аймгийн нэгдсэн үнэлгээ

Нийгмийн эгэх хариуцлагын механизм	Үр дүн			Тогтвортой байдал
	Засаглал	Чадавхжуулах	Төрийн үйлчилгээ	
✓	✓	✓	✓	✓ X
Хариу нэхэмжлэх чадавхийг нэмэгдүүлэх, ИНБ-уудын сүлжээ дуу хоолойг нэгтгэх				

УВС АЙМАГ: ХАМТЫН ХҮЧ ТӨСӨЛ

Увс аймаг “Хамтын хүч” дэд төслийг “Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ-тай түншлэн хэрэгжүүлсэн байна. Орон нутгийн ТББ-ын зохицуулагчийн манлайлал доор аймгийн засаг даргын тамгын газар, нэгдсэн эмнэлэг, орон нутгийн бусад ТББ-ууд гэсэн оролцогч талуудын дэмжлэгтэйгээр тус төслийн хүрээнд чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг сайжруулах чиглэлээр томоохон алхам хийгджээ.

Аймгийн нэгдсэн эмнэлэг худалдан авах ажиллагааг гардан зохион байгуулж, үнэлгээний комисс нь хамгийн бага үнийг санал болгосон талтай гэрээ байгуулснаар чанарын шаардлага хангаагүй эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авч улмаар энэ нь эмнэлгийн үйлчлүүлэгчид, өвчтөний хувьд эмнэлгийн үйлчилгээ, эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн талаарх сэтгэл ханамж муу болоход нөлөөлдөг болсон гэж Увс аймгийн иргэний нийгмийн байгууллагууд үзсэн байна. Энэ байдалтай уялдуулан худалдан авах ажиллагаанд хэдэн хэдэн асуудал үүсжээ. Иргэний нийгмийн байгууллагын хийсэн шинжилгээгээр нийлүүлэгч тал эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх хугацаагаа оройтуулах, нийлүүлж

буй эм нь гэрээнд заасан заалттай нийцэхгүй байх (чанарын шаардлага хангахгүй, эсвэл өөр эм сольж илгээх) зэрэг асуудал үүсч эдгээрт худалдан авж буй талын зүгээс хяналт тавих, хариуцлага тооцох боломжгүй байсан.

Дэд төслийн хүрээнд иргэний нийгмийн болон төрийн байгууллага зэрэг оролцогч талуудаас (үнэлгээний хорооны гишүүдийн үйл ажиллагааны гүйцэтгэл) худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хяналт шинжилгээн дэх оролцооны тухай судалгаа авсан. Мөн төслийн баг оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, гүйцэтгэлийн үнэлгээ (Худалдан авах ажиллагааны хуулийг үндэслэн), гэрээний хэрэгжилт\чеклистийн буюу нийлүүлэлтийг жагсаалттай нь тулгах зэрэг аргыг


ашиглан мэдээлэл цуглуулсан байна.

Улмаар харилцан ойлголцолын санамж бичигт гарын үсэг зурж төслийн удирдлагын багийг зохион байгуулжээ. Энэ багт аймгийн нийгмийн бодлогын хэлтэс, иргэдийн хурал, нэгдсэн эмнэлгийн болон эрүүл мэндийн газрын дарга нар төлөөлөл болон орсон байна. Хөндлэнгийн үнэлгээний баг байгуулагдан үүнийг орон нутгийн иргэний нийгмийн байгууллагаас сонгогдсон зохицуулагч тэргүүлэн ажилласан. Тэд үйл ажиллагаагаа зохион байгуулахдаа “Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ-ын зөвлөхүүдийн дэмжлэгийг авч ажилласан байна.

Төслийн хүрээнд дэвшүүлсэн зорилгоо биелүүлэхийн тулд дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

Төслийн үйл ажиллагаа эхлэхийн өмнө

1. “Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ-ын дэмжлэгээр асуудлаа тодорхойлох зорилгоор “Шийдвэр гаргалтын мод”-ны аргыг ашиглан нэгдсэн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагаанд тулгамдсан асуудлыг тодорхойлжээ. Энэ үйл явцын үр дүнд орон нутгийн



иргэний нийгмийн байгууллагын оролцогч талууд үндсэн асуудлаа тодорхойлон түүн дээрээ түшиглэн төслийн дизайныг боловсруулсан байна.

2. Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын зохицуулагч албан ёсны төлөөлөл болж улмаар төрийн байгууллагуудаас дэмжлэг авч төслийн удирдлагын баг болон ажлын хэсгийг байгуулжээ.
 3. Техникийн туслалцаа авах, Увс аймгийн худалдан авах ажиллагааг сайжруулахад дэмжлэг авах зорилгоор “Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ-ыг албан ёсоор үндэсний түншлэгч ТББ болгон сонгосон байна.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөлт
4. Худалдан авах ажиллагааны хяналтын чиглэлээр мэргэшсэн шинжээчийг ажиллуулж худалдан авах ажиллагааны арга, үйл явцад үнэлгээ хийлгэн, тавигдах тусгай нөхцөл, үнийн санал, худалдан авах ажиллагааны чанар, гэрээний бичиг баримтыг хэрхэн сайжруулах талаар зааварчлаг авжээ.
 5. Үнэлгээний хорооны үйл ажиллагаанд оролцож үнийн санал, тендерийн материал, гэрээний бичиг баримтыг хэрхэн хянах талаар зөвөлгөө өгсөн.
 6. Үнэлгээний хороодын гишүүдийн ажлын гүйцэтгэлийн талаарх судалгааг авсан байна. Худалдан авах ажиллагааны гадаад (хөндлөнгийн), дотоод хяналт

7. 20 сайн дурынхнаас бүрдсэн (орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн байгууллага тухайлбал эм зүйч г.м) гадаад хяналтын баг нь худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгсэл гэрээнд заагдсан нөхцөлийн дагуу нийлүүлэгдэх эсэхэд хяналт тавьсан. Энэ үйл ажиллагааны хүрээнд гэрээнд заасан нөхцөлийн дагуу бүтээгдэхүүн нийлүүлэх байдал, тоо ширхэг, чанар, бараа бүтээгдэхүүн нийлүүлж буй хугацааг хянаж, тухайн хяналтын үр дүнг төслийн удирдлагын багт утсаар болон мессежээр мэдээлж байсан. Гадаад хяналтын баг хяналтын ажлынхаа үр дүнг өгүүлэл болгон орон нутгийн сонинд нийтлүүлсэн байна.
8. Дотоод хяналтын баг нь эмнэлгийн эмч, мэргэжилтнээс бүрдсэн 15 гишүүнтэй. Энэ багийг нэгдсэн эмнэлгийн чанарын алба тэргүүлж эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлт, ашиглалт, хүртээмжийн байдалд хяналт тавьсан. Дотоод хяналтын үр дүнд тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэхээр ажилласан.
9. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулсан.
10. Аймгийн нэгдсэн эмнэлгийн удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй биечлэн уулзаж судалгааны үр дүнг танилцуулсан.

Дэд төслийн богино, дунд хугацааны үр дүн

Дэд төслийн хэрэгжилтийн богино хугацааны үр дүнтэй холбогдуулан дээр дурдсан үйл ажиллагааг баримтжуулан тэмдэглэсэн байна. Нийгмийн эгэх хариуцлагын санаачилгыг үр дүнтэй болгоход дараах элемент, хүчин зүйл нөлөөлжээ. Үүнд:

1. Төрийн байгууллагын эрэлт, нийлүүлэлт, хариуцан тайлагналтыг сайжруулахад чиглэсэн НЭХ-ийн үйл ажиллагааг төлөвлөсөн байдал

Бэрхшээлийн шинжилгээг хийж, оролцогч талуудын дунд сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулснаар нэгдсэн эмнэлгийн үйлчилгээ, эм эмнэлгийн хэрэгслийн талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлсон. Судалгааны үр дүнг нийгмийн бодлогын хэлтэс, иргэдийн хурал, нэгдсэн эмнэлгийн төлөөллөөс бүрдсэн төслийн удирдлагын болон хэрэгжүүлэгч багийн гишүүдэд танилцуулсан байна. Төслийн баг худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд нөлөө үзүүлж үнэлгээний хорооны гишүүдийн бүрэлдэхүүнийг Иргэдийн хурал, орон нутгийн иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн төлөөллөөр шинэчилсэн.

Дэд төслийн багийн зүгээс шинэчлэн зохион байгуулагдсан хорооны гишүүдэд техникийн үзүүлэлт, үнийн санал, тендер, гэрээний бичиг баримтыг нягтлан шалгахад туслалцаа үзүүлжээ. Хянан шалгах явцад тусгай шаардлагад (худалдан авах ажиллагааны тусгай маягыг ашиглах) үндэслэн худалдан авах ажиллагааны эцсийн шийдвэрийг гаргах, зөвхөн бага үнийн санал оруулж байгаа оролцогчидтой гэрээ байгуулах бус гол нь чанарын үзүүлэлтийг харгалзан үзэх шаардлагатай зэргээр өөрчлөлт хийх боломжоо тодорхойлжээ. Шинэчлэн зохион байгуулагдсан үнэлгээний хороо худалдан авах ажиллагаанд тавигдах тусгай шаардлагыг мөрдөж эхэлснээр энгийн маягт ашиглан худалдан авах ажиллагааг зохион

байгуулж хамгийн бага үнийн саналаар гэрээ байгуулан чанар муутай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах байдлыг таслан зогсоосон юм. Хяналт хийсний үр дүнд шинэчлэн боловсруулсан шаардлагыг мөрдөн 1.4 тэрбум төгрөгийн өртөгтэй худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Энэхүү шинэчлэлийн үр дүнд төслийн баг 189 сая төгрөгийн хэмнэлтийг гаргаж чаджээ.

Эргэн нягталж сайтар боловсруулсан гэрээний нөхцөл, орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын (гадаад) хяналтын багийн боловсруулсан хяналтын хэрэгсэл/жагсаалттай тулгах байдлаар гэрээний хэрэгжилтийн явц, үнэлгээний хорооны гишүүдийн ажлыг үнэлсэн байна. Иргэдийн хяналтын багийн санал тэр даруй шууд шийдвэр

гаргагчдад хүрч чанарын шаардлага хангаагүй эм, эмнэлгийн хэрэгслийн хүргэлтийг зогсоодог байсан. Учир нь тэд эмнэлгийн чанарын менежертэй (төслийн менежментийн багийн гишүүнээр ажилладаг) тул шууд холбогдож чаддаг байжээ. Хяналтын арга хэрэгсэлд тулгуурлан хүргэлт удаашрах, нийлүүлэлтийн жагсаалт дах эм, эмнэлгийн хэрэгсэл давхардан ирэх, гэрээнд заагдаагүй эм нийлүүлэх, эсвэл хямд үнэтэй эмээр жагсаалт дах эмийг солисон тохиолдолд нэн яаралтай эмнэлгийн менежерт иргэдийн хяналтын багийнхан мэдээлдэг байсан.

Хяналтын үйл ажиллагааны үр дүнг тодорхойлох зорилгоор хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн нэгдсэн эмнэлгийн удирдлагын багт зөвлөмж хүргүүлсэн ажээ.

Худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын талаарх гэрээний нэмэлт нөхцөл:

Худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын талаарх гэрээний нэмэлт нөхцөл:

Хэрэглэгч эм, эмнэлгийн хэрэгслийг шинжлүүлэх, шалгах эрхтэй. Энэхүү эрх нь заагдсан хугацаанд нийлүүлэгдсэн эм, эмнэлгийн хэрэгсэлээс хоёр удаа санамсаргүй байдлаар түүвэрлэн хэрэглэгчийн сонгосон лабороторт шинжлүүлэх бөгөөд үүнтэй холбогдох зардлыг нийлүүлэгч хариуцана. Хяналт тавих, турших зардал нийлүүлэгчийн гэрээний өртөгийн 0,01 хувиас илүү гарахгүй байна.

Техникийн шаардлагыг хангахын тулд нийлүүлэгч дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Нийлүүлэгч тал бүтээгдэхүүн нийлүүлэхээс 15 хоногийн өмнө бие даан шаардлага хангасан лабороторт эм, эмнэлгийн хэрэгслийн шинжилгээг хийлгэж, дүгнэлтийг бүтээгдэхүүний хамт илгээнэ.
2. Нийлүүлэгч холбогдох зардлыг гаргана.
3. Орон нутгийн иргэд, хэрэглэгчид багт орж ажиллан нийлүүлэгдэж буй эм, эмнэлгийн хэрэгсэл тендерийн бичиг баримтад дурдагдсан шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлан хүлээж авна.
4. Дүгнэлт гаргахдаа төлбөр төлөлтийг харгалзан үзнэ.

2. Дунд хугацааны үр дүн: Иргэд чадавхжих, орон нутгийн засаглал болон эрүүл мэндийн үйлчилгээ сайжрах чиглэлээр гарсан тодорхой үр дүн

Засаглал: Тендерийн бичиг баримт, үнийн саналыг хянах, үнэлгээний хороог шинээр зохион байгуулахад Эрүүл мэндийн газар дэмжлэг үзүүлэн ажилласан. Одоогийн байдлаар албан ёсны бодлогын баримт бичиг, дүрэм журам батлагдан гараагүй тул дэд төсөл хэрэгжиж дууссаны дараа нэгдсэн эмнэлэг тендер шалгаруулах, тендерийн бичиг баримтыг хянах, худалдан авах ажиллагааг зохион байгуулна гэж үзэж байна.

Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг төрийн албан хаагчид, төрийн үйлчилгээг үзүүлэгчид хүлээн зөвшөөрч түүнд тулгуурлан асуудлыг тодорхойлон үйл ажиллагаагаа төлөвлөсөн байдлаас үзэхэд иргэд\иргэний нийгмийн байгууллагууд засаглалын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох боломжтойг төрийн албан хаагчид ойлгож ухаарсан байна. Учир нь иргэдээс авсан судалгааны үр дүнд үндэслэн орон нутгийн засаг захиргааны нэгж эрүүл мэндийн үйлчилгээ болон эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагаанд хувиарлах төсвийн хэмжээг 200 сая төгрөг болгон нэмэгдүүлжээ.

Иргэд худалдан авах ажиллагаанд хяналт тавьж, худалдан авах ажиллагааны баримт бичгийн чанарыг сайжруулснаар орон нутгийн удирдлагын байгууллагын хувьд хэмнэлт гарч энэхүү хэмнэсэн мөнгөөрөө эмнэлгийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай нэмэлт зүйлсийг худалдан авахад зарцуулж чадсан байна. Худалдан авах ажиллагааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавьсаны үр дүнд эм, эмнэлгийн хэрэгсэл товлосон хугацаандаа нийлүүлэгдэх, нэгдсэн эмнэлгийн эм, хэрэгслийн чанар, хүртээмж сайжирсан байна.

Иргэд чадавхжсан нь: Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл шинэчлэн зохион байгуулагдсан үнэлгээний хорооны үйл ажиллагаанд биечлэн

оролцоноор худалдан авах ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцын талаар ойлголттой болжээ. Худалдан авах ажиллагааны хяналтын арга хэрэгсэл болох чеклисттэй \жагсаалттай тулгах\ болж, гэрээнд заасан техникийн нөхцөлийн дагуу эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэлтийг үнэлэх чадавх тодорхой түвшинд сайжран, техникийн нөхцөл шаардлага хангахгүй эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авахаас татгалзах, энэ тухайгаа тайлагнах чадавхтай болсон байна.

Үйлчилгээ үзүүлэх байдал: Аймгийн эрүүл мэндийн газрын санхүүгийн албаны дарга буюу үнэлгээний мэргэжилтний хэлснээр үнийн санал, техникийн нөхцөл, тендер, гэрээний бичиг баримтыг нягтлан шалгаж гүйцэтгэлийн хөндлөнгийн үнэлгээ хийлгэснээр үнэлгээний хорооны худалдан авах ажиллагааны ил тод байдал, үр дүн сайжирсан байна.

Энэ нь нэгдсэн эмнэлгийн хувьд төсвийн хуваарилалт нэмэгдэх, товлосон хугацаанд чанартай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад нөлөөлжээ. Нэгдсэн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх чадвартай холбоотойгоор орон нутгийн оролцогч талууд дараах зүйлийг ажигласан байна. Үүнд:

- Антибиотикийн нийлүүлэлт удаашрах хоцрох байдал арилсан
- Эмнэлгийн үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн

- Нялхсын эндэгдэл буурсан (өмнө жил 11 дүгээр байранд энэ жил 5 дугаар байранд эрэмбэлэгдэж байна)
- Иргэд өөрөөсөө эмнэлгийн зардал төлөх байдал буурсан

Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг эмнэлгийн томилон ажиллуулах системд суулгаж, судалгааны үр дүнд дүгнэлт хийн лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулан, эмнэлгийн дээврийг зассан байна.

3. Тогтвортой байдлын механизм:

Хянаж сайжруулсан тендер шалгаруулалтын бичиг баримтыг сумын эмнэлэг, өрхийн эмнэлгийн түвшиний худалдан авах ажиллагааны үр дүнг сайжруулахад дахин хэрэглэх байдлаар үйл ажиллагааны тогтвортой байдлаа төсөөлж байгаа юм байна. Судалгааны ярилцлагаас үзэхэд дээр дурдсан үйл ажиллагааг баталгаажуулсан, албан ёсны институтчилсан баримт бичиг байхгүй байлаа. Нөгөө талаар хяналт хийх нь иргэдийн хувьд нэмэлт ачааллыг бий болгож, төрийн байгууллагуудын хувьд нэмэлт нөөц шаардлагатай болж байна.

Одоогийн байдлаар аймгийн засаг даргын тамгын газар иргэдээс ирсэн санал, гомдлыг хүлээж авах нэг ажилтан ажиллуулж байгаа юм байна.

Үнэлгээ, зөвлөмж

Увс аймагт хэрэгжсэн дэд төсөлд зарим бэрхшээлтэй асуудал үүссэн байна. Иргэний нийгмийн байгууллагын зохицуулагчийн үзэж байгаагаар оролцогч талууд НЭХ-ийн талаар нэгдсэн ойлголт авч түүнийг хүлээн зөвшөөрөх байдал нэлээд сорилттой тулгаран улмаар төслийн хэрэгжилт удаашрахад нөлөөлсөн. Цаг хугацаанаас хамааран иргэний нийгмийн байгууллагын сайн дурынхны хяналт тавих идэвх аажмаар буурч байснаас гадна төслийн бодит хэрэгжилтийн үед гадаад, дотоод хяналтын баг өөр хоорондоо шууд хамтран ажиллах, нэгдсэн зохицуулалт хийх байдал хангалтгүй байжээ. Учир нь баг тус бүр тусдаа судалгаа авсан төдийгүй гадаад оролцогч талуудын хийсэн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг эмнэлгийн байгууллагын өөрсдийн хийдэг тогтмол судалгааны үр дүнгээр баталгаажуулсан байна. Энэ байдлыг үл харгалзан дүгнэн үзэхэд төсөл төлөвлөж байсан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн хүлээгдэж буй үр дүнд хүрч улмаар дараах давуу талууд бий болжээ. Үүнд:

- Аймгийн нэгдсэн эмнэлгийн худалдан авах ажиллагаа ил тод болж худалдан авах ажиллагааны бэлтгэл үйл явц, гэрээний хэрэгжилтэд иргэд оролцдог болж үнэлгээний хорооны гишүүдийн бүрэлдэхүүнд иргэд орж ажиллах болсон;

- Үндэсний ТББ-ын зүгээс техникийн болон экспертийн туслалцаа үзүүлснээр худалдан авах ажиллагааг сайжруулах боломжоо тодорхойлон, худалдан авах ажиллагааны асуудлыг дотор нь орж шалгах боломж бүрдсэн;
- Орон нутгийн хэрэгжүүлэгчдийн нэг нь өмнө нь иргэдийн хурлын гишүүнээр ажиллаж байсан нь нийгэм, улс төрийн капитал болж үүнийгээ ашиглан шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, нөлөө үзүүлж чадсан;
- Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьсан нь худалдан авах ажиллагааг сайжруулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, бараа материал нийлүүлэхэд иргэд оролцоноор эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлт сайжирсан.

Дэд төслийн үйл ажиллагааг өөр бүс нутаг, төрийн бусад үйлчилгээнд хуулбарлан хэрэглэхдээ доор дурдсан цөөн тооны султ талыг анхаарч, нягтлан үзэх шаардлагатай байна. Үүнд:

- Төслийн дизайн- худалдан авах ажиллагаа нь нарийн төвөгтэй, өндөр түвшний техникийн ур чадвар шаардагддаг учраас мэргэшээгүй болон сургалтад хамрагдаагүй хүмүүсийн хувьд худалдан авах ажиллагааг ухаарч ойлгох, тухайн үйл ажиллагаанд оролцоход ихээхэн цаг хугацаа шаардагддаг. Төслийн дизайныг иргэдийн оролцоонд чиглэсэн

стратегийн зорилт байдлаар боловсруулсан бол төслийг хэрэгжүүлэгчдэд илүү өгөөжтэй байх байжээ. Төсөл хэрэгжүүлэх хугацаа богино байхад худалдан авах ажиллагааны олон асуудлыг хамааруулан шийдвэрлэх оролдлого хийсэн нь уг төслийн хүрээнд худалдан авах ажиллагааг төлөвлөх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үйл явцын аль альнийх нь хувьд маш тодорхой, тогтвортой үр дүнд хүрч чадаагүй гэж үзэж байна.

- Үйл ажиллагааны болон хэрэгжилтийн механизм- Хяналт хийх зорилгоор оролцогч талууд өөр хоорондоо ялгаатай санал асуулга (оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, эмнэлгийн дотоод хяналтын чанарын судалгаа, гэрээний хэрэгжилтийн хяналт) авсан байдлаас үзэхэд төслийн оролцогч талууд өөрсдийн хүлээсэн үүргээ биелүүлэхэд чармайгаад харин өөр хоорондоо уялдаа холбоо багатай ажиллаж байсныг илтгэж байна. Төслийн удирдлагын багийн түвшинд зохицуулалт хамгийн сайн хийгдэж байсан бол үлдсэн гурван багийн хооронд зохицуулалт муутай байжээ.
- Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд болон иргэдийн (өөрсдийн хүсэл сонирхол, сэдэл тэмүүлэлд суурилан) зүгээс хийсэн хяналтыг үнэлэх, талархлаа илэрхийлэх механизм бий болгох.

Иргэдийн хяналт нь гэрээний хэрэгжилтийг хянах зорилготой нийцэх шаардлагатай. Гэрээний хяналт хийх нь техникийн сургалт зохион байгуулах зэргээр нөөц ихээр шаарддаг учраас илүү стратегийн (бүгдийг биш маш чухал цөөн зүйлд анхаарч) чиглэлээр хэрэгжиж, дэд төслийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг нь хангах зорилгоор хяналт хийж байгаа хүмүүсийг “урамшуулах” асуудлыг анхааран үзэх

- Худалдан авах ажиллагааны хуулийн зүйл заалттай уялдуулан үнэлгээний хорооны байнгын

тогтвортой үйл ажиллагааг хангах, үнийн санал болон тендерийн бичиг баримтыг хянах үйл ажиллагаа институцилагдаагүй байна. Одоогийн байдлаар шийдвэр гаргагчид улс төрийн хүсэл зориг гарган энэ үйл ажиллагааг үргэлжлүүлэх, тендерийн шалгаруулалт, гэрээний нөхцөлийг шалгах уламжлалт болон урьдчилан боловсруулсан шалгуур үзүүлэлт бүхий хүснэгтийг эргэн нягтлсаны дараа ашиглах, энэхүү өөрчлөлтийн тогтвортой байдлыг хангахад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг багасгах хэрэгтэй байна.

Нийгмийн эгэх хариуцлагын механизм	Үр дүн			Тогтвортой байдал
	Засаглал	Чадавхжуулах	Төрийн үйлчилгээ	
✓ X	✓	✓ X	✓	✓ X
Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гэрээний хэрэгжилтэд оролцох уялдааг сайжруулан, орон нутгийн ИНБ-уудад технологийг шилжүүлэх				


ӨВӨРХАНГАЙ АЙМАГ: ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТ СУРГУУЛЬ

Өвөрхангай аймаг “Олон нийтийн оролцоот сургууль” дэд төслийг Монголын Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн. Дэд төслийн хүрээнд аймгийн төвөөс алслагдсан, орлого багатай, донор байгууллагын төсөлд хамрагддаггүй 10 сургуулийн засаглал, хөрөнгө, нөөцийн хуваарилалт, зарцуулалт болон олон талт шийдвэр гаргах үйл явцыг сайжруулахыг зорьсон.

Төсөлд хамрагдсан нэг сургуулийн захирлын хэлснээр “Эцэг эхчүүд хүүхдийнхээ хичээл, сургуулийн байдлыг сонирхдоггүй, сургуулийн үйл ажиллагаанд ерөнхийдөө оролцдоггүй. Мөн ихэнхи малчин айлууд сургуулийн үйл ажиллагааны талаар мэдээлэлгүй, ангийн хуралд зөвхөн ээжүүд оролцдог. Аймгийн ихэнхи сургуулийн сургуулийн зөвлөл бараг ажилладаггүй.” Сургуулийн удирдлага болон оролцогч талуудын хувьд дэд төсөл нь БХАН-ээс боловсруулсан “олон нийтийн оролцоот сургуулийн” загварыг ашиглан эцэг эхчүүд, иргэдийг сургуулийн үйл ажиллагаа болон удирдлагын үйл ажиллагаанд оролцуулж сургуулийг хүний хөгжлийн төв болгох зорилготой юм.

Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд, дараах гол ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Төслийн хамтрагч БХАН оролцогчдод сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлт болон хяналт-шинжилгээний үйл ажиллагаанд талуудыг үр дүнтэй оролцуулах аргуудын талаар нийгмийн эгэх хариуцлагын сургалтыг зохион байгуулсан. Төслийн оролцогч талууд энэ сургалтаас хамтын ажиллагаанаас хүлээгдэж буй үр дүн, зорилтуудын талаар суралцсан. Түүнчлэн БХАН-ын сургагч багш нар асуудлыг тодорхойлох, эрэмблэх, хамтдаа асуудлыг шийдвэрлэх зэрэг олон нийтийн оролцоот сургуулийн аргачлалын талаар оролцогчдод чиглэл өгч ажиллажээ.



2. ОроннуггийнТББ-тайхамтрантөсөл хэрэгжүүлэх багийг бүрдүүлсэн. Бодлогын шинжилгээний баг, хэрэгжүүлэлтийн баг, хэвлэл мэдээлэл/олон нийттэй харилцах баг зэрэг 3 багийг байгуулжээ. АБГ-ын ажилтнууд ТББ-ын сайн дурын багуудтай хамтран ажилласан боловч ихэнхидээ бодлогын болон хэрэгжилтийн багуудтай түлхүү хамтран ажилласан.
3. БХАН-ын сургалтаас сурсан зүйлсээ сумдад хэрэгжүүлэх 20 хүнтэй төслийн хэрэгжүүлэлтийн баг байгуулагдсан. Төсөл хэрэгжүүлэлтийн баг БХАН-ийн боловсруулсан шалгуур үзүүлэлт, оролцоонд суурилсан асуудал шийдвэрлэх аргачлалын дагуу сургуулийн үнэлгээ хийх арга зүйг сургууль болон сумын төсөл хэрэгжүүлэх багуудад сургасан.
3. Сургуулийн түвшинд, орон нутгийн оролцогч талууд (сургуулийн удирдлага, ажилтан, эцэг эхчүүд, сайн дурынхан) “олон нийтийн оролцоот сургуулийн” загвар судалгаа авч сургуулийн үйл ажиллагаа, удирдлагын үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн. Үнэлгээний үр дүнд үндэслэн сургуулийн төслийн баг

судалгаагаар гарч ирсэн асуудлуудыг шийдвэрлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан. 10 сургуулийн олонхи нь сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоо сул гэсэн асуудлыг гол тулгамдсан асуудлаар тодорхойлсон байна.

4. Сургууль бүр өөрсдийн жижиг төслийг төлөвлөж хэрэгжүүлж ажилласан. Төслийн нэг сургуулийн хувьд малчин айлуудад сургуулийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх, мэдээлэл түгээх үйл ажиллагааг сайжруулах зорилготой “явуулын мэдээ” төслийг хэрэгжүүлсэн. Хөндлөнгийн үнэлгээний ярилцлагад оролцсон нэг сургуулийн хувьд аавуудын оролцоог нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлсэн.

Эдгээр аавуудын бүлэг “Амьдралын ухаан: Гэр бүл дэх аавын үүрэг” сэдэвт лекц, спортын тэмцээн, нийгмийн арга хэмжээнүүд, УИХ-ын гишүүний дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын сургуулиудын туршлага судлах танилцах аялалд оролцсон байна.

Дэд төслийн богино, дунд хугацааны үр дүн

Дэд төсөл тус бүрийн нийгмийн эгэх хариуцлагын үр дүнгүүдийг бий болгоход оруулсан хувь нэмрийг үнэлэн баримтжуулсан байдлыг үзүүлвэл:

1. Төрийн байгууллагын эрэлт, нийлүүлэлт, хариуцан тайлагналтыг сайжруулахад чиглэсэн НЭХ-ын үйл ажиллагааг төлөвлөсөн байдал

Олон нийтийн оролцоот сургуулийн загвараар оролцогч талууд ялангуяа эцэг эхчүүд, олон нийт сургуулийн үйл ажиллагааг үнэлэн тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлсон. Нийт төсөл хэрэгжсэн 10 сургууль дээр хөндөнгийн үнэлгээний загваруудыг өөр өөрийн онцлогт тохируулан боловсруулж, үнэлгээ, дүгнэлт өгөх үйл ажиллагааг сургууль өөрөө биш эцэг эхчүүд, төрийн бусад байгууллага болон төрийн бус байгууллагууд хийж, түүнийгээ засан сайжруулах талаар арга хэмжээ авч ажилласан.

Мэдээлэл түгээх, харилцан суралцах, мод бут тарих, сургуулийн орчинг сайжруулах, эцэг эхчүүдийн хөгжлийн төв байгуулах зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан эцэг эхчүүдийг зохион байгуулалтад оруулж (багш нарын, эцэг эхчүүдийн, аав нарын гэх мэт бүлгүүд байгуулан) сургуулийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийлгэн сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхчүүдийг татан оролцуулсан. Хамтдаа асуудлыг шийдвэрлэснээр орон нутгийн бизнес эрхлэгчдийн тусламжтайгаар хөрөнгө, нөөцийг зохион байгуулж сургуулийг сайжруулах санаачлагуудыг (жишээ нь нэг сургууль 24 сая төгрөгийг ийм төсөлд зарцуулсан) хэрэгжүүлсэн.

2. Дунд хугацааны үр дүн: Иргэд чадавхжих, орон нутгийн засаглал болон эрүүл мэндийн үйлчилгээ сайжрах чиглэлээр гарсан тодорхой үр дүн

Засаглал: АБГ сургууль бол хүүхдүүдийн хувьд хүн болж төлөвших орчин гэж үзсэн. Энэ зорилгыг биелүүлэхийн тулд сургуулийн оролцооноос гадна эцэг эхчүүдийн оролцоо чухал юм. Энэ ажлын хүрээнд АБГ дэд хөтөлбөр боловсруулан аймгийн ИТХ-р батлуулсан. Дэд хөтөлбөр эцэг эхчүүдийг сургуулийн өдөр тутмын болон бусад үйл ажиллагаанд хяналт тавиулах, багш нарын хариуцлагыг нэмэгдүүлэх зорилготой.

Төслийн хэрэгжилтэд АБГ-ын мэргэжилтнүүдийн 50 хувь нь оролцож жижиг төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн ажилласнаар тус дэд төслийг хэрэгжүүлж чадсан.

Сумын ЗДТГ-ын дэмжлэгээр сургуулийн түвшний санаачлагууд хэрэгжсэн байна. Жишээ нь 1 сургууль дээр олон нийтийн үнэлгээгээр тодорхойлсон сургуульд хэрэгцээт хөгжмийн хэрэгслийг сумын ЗДТГ-ын нөөц хөрөнгөөс 1,5 сая төгрөг хуваарилан шийдвэрлэсэн. Жижиг төсөл хэрэгжсэнээр сумын захиргаа хүүхдийн хөгжлийн асуудал, сургуулийн үйл ажиллагааг сайжруулснаар сум хөгжихийн ач холбогдлыг ойлгосон.

Чадавхжуулах: Дэд төсөл хэрэгжсэнээр эцэг эхчүүд болон олон нийт хамтаараа асуудал шийдвэрлэх үйл явцад оролцох боломжийг бий болгосон. Жижиг төслүүд нь эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэж (ялангуяа аавуудыг онцолсон байсан) дараах гол үр дүнг бий болгосон. Үүнд:

- Төслийн багийн 80 хүний сургалт, 300 гаруй багш, ажилчдын сургалт зохион байгуулсны дүнд сургуулийн хэрэгцээг хангахад эцэг эхчүүд (ялангуяа аавууд) өөрсдийн хувь нэмрийг чадах хэмжээнд оруулах (жишээ нь нэг ногоочин эцэг эх хүнсний ногоогоо хандивласан гэх мэт), хүүхдийн боловсролын асуудал нь эцэг эхчүүд болон сургуулийн хамтын хариуцлага гэдгийг эцэг эхчүүд ойлгож сэтгэлгээний өөрчлөлт бий болсон.
- Орон нутгийн бизнес эрхлэгчид, бусад байгууллагаас хөрөнгө нөөц төвлөрүүлсэн (Нэг сургууль 25 сая төгрөгийн хандив цуглуулсан)
- 10 сумын 200 эцэг эхийг сурган сургуульд тулгамдсан асуудлыг орон нутгийн санаачлагыг хэрэгжүүлэн шийдвэрлэсэн. (жишээ нь сургуулийн ойр орчимд бут сөөг тарих, хашаажуулах, сургуулийн номын санд ном хандивлах компани ажил гэх мэт)
- Сургуулийн үйл ажиллагаа, хөтөлбөр зэргийн талаар олон нийтийн ойлголт, мэдээллийг сайжруулсан. Нэг сургуулийн эцэг эхийн хяналтын баг үдийн цайнд

хяналт тавьснаар сургуулийн захирлын онцолсоноор сургуулийг шүүмжилж буруутгах нь багассан (өмнө нь байдал эсрэгээр байсан).

- Сурах орчин, сургалтын чанарын талаар хариуцлага нэхэх явдал сайжирсан. Төсөл хэрэгжихээс өмнө эцэг эхчүүд багш нарын [гүйцэтгэлийн] талаар юу бодож байгаагаа ярихаас айдаг байсан. Нэг сургуулийн жишээн дээр төсөл хэрэгжсэний дараа эцэг эхчүүд математикийн хичээлийг сайжруулах талаар хүсэлт тавьсан гэж сургуулийн захирал хэлсэн байна.

Төрийн үйлчилгээ: Сумын удирдлага болон сургуулийн захирлууд АБГ-ын мэргэжилтэн сумдад ажилласнаар орон нутгийн нөхцөл байдалтай танилцах боломжтой болсон ба аймгийн мэргэжилтнүүдийн хувьд хөтөлбөр, хөрөнгө нөөцийг сумын сургуульд чиглүүлэх боломжийг бий болгосон гэж үзэж байна.

Тэдний зүгээс [сумын удирдлага] оролцогч талууд хүүхдүүдийнхээ сургуульд тулгамдсан асуудлыг олж мэдэн асуудлыг шийдвэрлэхэд оролцсоноор сургуулиуд хамтаараа асуудлыг тодорхойлох, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг түгээх, сургуулийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахын ач холбогдлыг ойлгосон гэж үзсэн.

Жижиг төслүүд нь сургуулийн төсвөөс биш орон нутгийн байгууллагууд болон эцэг эхчүүдийн хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжсэн. Ярилцлага хийсэн нэг

сургуулийн жишээгээр тус төсөл нь сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах үйл явцыг илүү оролцоотой болгосон ба төсөл хэрэгжихээс өмнө төлөвлөгөөг зөвхөн сургуулийн захирал ажилтнууд хийдэг байсан байна. Одоогоор тэд багш нарын гүйцэтгэлийг үнэлэхэд эцэг эхийн оролцоог хангах сургуулийн дотоод дүрэм журмыг өөрчлөхөөр ажиллаж байна.

“Олон нийтийн оролцоот сургууль” аймгийн хөтөлбөрийг боловсруулах явцдаа шат шатны олон нийтийн саналыг авч Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээд иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдэд энэ асуудлыг ойлгуулах, тэдний дэмжлэгийг авч, батлуулахад ихээхэн хүчин чармайлт орсон байна. Цаашид энэхүү хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд аймгийн хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, нийт 30 сургууль бүр өөр өөрийн байгууллага дээр төлөвлөгөө гарган ажиллаж эхлээд байна.

3. Тогтвортой байдлыг хангах механизм

Сургуулийн түвшинд зарим сургуулийн захирлууд эцэг эхийн оролцоог сургуулийн үйл ажиллагаанд хангах талаар сургуулийн дотоод дүрэм журмыг судлан өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Оруулах өөрчлөлтийн хувьд сургуулийн төлөвлөлт болон шийдвэр гаргах үйл ажиллагаанд өөрчлөлт оруулахаас гадна багш нарын ажлын байрны тодорхойлолт (эцэг эхийн оролцоог хангах) болон багш нарын

гүйцэтгэлийн үнэлгээнд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг судлаж байна.

Аймгийн ИТХ-р батлуулсан АБГ-ын боловсруулсан дэд хөтөлбөр нь сургуулийн өдөр тутмын болон ерөнхий үйл ажиллагааг сайжруулахын тулд сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн хяналтыг бий болгох, багш нарын гүйцэтгэлийг сайжруулахын тулд багш нарын хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Үнэлгээ, зөвлөмжүүд

Өвөрхангайд хэрэгжсэн дэд төслийн хэрэгжилтэд тулгарсан асуудал нь улирлын шинжтэй цаг хугацааны асуудал байв. Өвлийн саруудад хөдөөгийн оролцогч талуудтай харилцахад хүндрэлтэй байсан ба хаврын улиралд мөн адил малчин өрхүүд мал төллөлттэй холбогдуулан завгүй байсан. Говь, хээрийн бүсэд байрладаг зарим сумдад очиход хол учраас цаг хугацааны хувьд болон тээврийн зардлын хувьд өртөгтэй байв.

Төслийн хэрэгжилтийн явцад зарим ажил дээр цаг хугацаа хоцрох явдал байсан боловч сургуулийн түвшний оролцогч талууд эцэг эхийн үүрэг, оролцоог хүлээн зөвшөөрч, ач холбогдлыг нь ойлгосон.

АБГ-ын хувьд өнгөрсөн 7 дугаар сард ИТХ-р батлуулсан дэд хөтөлбөр нь сургуулийн зөвлөлийг идэвхижүүлэх, байнгын үйл ажиллагааг нь дэмжих зэрэг арга хэмжээнүүдийг агуулсан нь

сайшаалтай байсан. Үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг зорилт нь боловсролын үйлчилгээнд иргэдийн оролцоотой хяналтыг нэвтрүүлэх, сургуулийн төлөвлөлт болон төсвийн үйл явцад иргэдийн оролцоог бий болгох, сургуулийн аудитын үр дүнг олон нийтэд түгээх зэрэгт сургуулийн зөвлөлийг ашиглаж суралцах орчинг бүрдүүлэх юм.

Ижил төстэй нийгмийн эгэх хариуцлагын санаачлагыг бусад сумдад хэрэгжүүлэх тохиолдолд оролцогч талууд дараах асуудлыг шийдвэрлэн ажиллах шаардлагатай. Үүнд:

- Эцэг эхийн оролцоог сургуулийн үйл ажиллагаанд бий болгосноор тулгамдсан асуудлыг тодорхойлох, уг асуудлыг шийдвэрлэх суурь болж чадсан эсэх талаар мэдээллийг цуглуулж нэгтгэх, жижиг төслийн хэрэгжилтийн тайлагнан баримтжуулах
- Сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог хангахаас (энэ нь эцэг эхчүүдийн өөрсдийн хариуцлагын асуудал бөгөөд үйлчилгээ үзүүлэгч хариуцах албагүй) илүүтэйгээр боловсролын үйлчилгээг сайжруулах, хамтаараа асуудал шийдвэрлэх үйл явцад эцэг эхчүүдийг зохион байгуулж оролцуулах

- Дэд төслийн явцад эцэг эхийг идэвхижүүлэх, оролцуулах үйл явцыг зөвхөн сургуулийн арга хэмжээг таниулах, оролцуулах төдий бус иргэдийн зүгээс сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа өөрсдийн хяналт тавих эрхтэй, санал хүсэлтээ хүргэх боломжтойг бодит жишээ, гарсан үр дүнгээр ойлгуулан таниулах. Ингэснээр цуглуулсан мэдээллийн тусламжтай иргэд төрийн үйлчилгээ үзүүлэгч болон орон нутгийн удирдлагаас хариуцлага нэхэх боломж нэмэгдэнэ.
- Орон нутгийн ТББ нь дэд төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд илүү идэвхитэй оролцож манлайлах шаардлагатай. АБГ шийдвэрийг гаргаж, техникийн зөвлөгөөг үндэсний ТББ өгч байгаа боловч төслийн амжилт [хөгжил] болон бүх харилцаа нь орон нутгийнх [орон нутгийн ТББ-нх] юм. Иймээс орон нутгийн ТББ-ын зохицуулагч нар байгаа боломжит туршлага, үр чадвар дээрээ тулгуурлан сумын түвшний хяналт-шинжилгээ, хамтын ажиллагааны үр дүнтэй байдалд хяналт тавих, тогтвортой байдлыг хангах зэрэгт анхаарч, идэвхижүүлэх үүргийг гүйцэтгэх шаардлагатай.

Өвөрхангай аймгийн нэгдсэн үнэлгээ

Нийгмийн эгэх хариуцлагын механизм	Үр дүн			Тогтвортой байдал
	Засаглал	Чадавхжуулах	Төрийн үйлчилгээ	
✓ X	✓	✓ X	✓	✓ X
Орон нутгийн ТББ-ын нотолгоонд суурилсан санал өгөх, хүсэлт гаргах чадавхийг бэхжүүлэх				

ДӨРӨВДҮТЭЭР
ХЭСЭГ.

ДҮТНЭЛТ,
ЗӨВЛӨМЖ

Бүх дэд төслүүд нийгмийн эгэх хариуцлагын санаачилгаа амжилттай хэрэгжүүлж, урьдчилан төлөвлөсний дагуу үйл ажиллагаагаа гүйцэтгэсэн байна. Ерөнхийд нь авч үзэхэд нийгмийн эгэх хариуцлагын талаарх ойлголтын түвшин, төслийн хэрэгжилтийн чанар, үр дүн аймаг тус бүрээр харилцан адилгүй байна.

Дэд төсөл тус бүрээр хийсэн үнэлгээнд суурилан дүгнэн үзэхэд төсөлд хэрэглэсэн загвар хамааралтай асуудлаа (элемент) хангалттай түвшинд хамарч чадсан, төслийн үр дүн, туршлагыг хуулбарлан хэрэглэхэд бэлэн болсон нь илэрхий байна. Цаашид төслийн дэмжлэггүйгээр илүү тогтвортой, илүү үр дүнтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор зарим дэд төслийг бэхжүүлэх, үйл ажиллагааг нь илүү нарийвчлах, төслийн дизайныг тодорхой болгох, нийгмийн эгэх хариуцлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Нийгмийн эгэх хариуцлагын үйл явцыг үр дүнтэй болгох үндсэн элементүүдийг нэгтгэн дүгнэж дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт

Дэд төслийн хэрэгжилт	Нийгмийн эгэх хариуцлагын механизм	Засаглал	Чадавхжуулах	Үр дүн, үйлчилгээ үзүүлэх	Тогтвортой байдал
Дорнод	✓ х	✓	✓ х	✓	✓
Говьсүмбэр	✓ х	✓ х	✓ х	✓	✓ х
Хэнтий	✓	✓	✓ х	✓	✓
Ховд	✓	✓	✓	✓	✓
Хөвсгөл	✓	✓	х	✓	✓ х
Сэлэнгэ	✓	✓	✓	✓	✓
Сүхбаатар	✓	✓	✓	✓	✓ х
Увс	✓ х	✓	✓ х	✓	✓ х
Өвөрхангай	✓ х	✓	✓ х	✓	✓ х

Хүснэгтээс үзэхэд Ховд болон Сэлэнгэ аймагт хэрэгжсэн дэд төсөл үндсэн элементээ бүгдийг нь хамарч чадсан байсан тул үр дүн, туршлагыг нь нэн даруй хуулбарлан хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Дэд төслүүд төрийн үйлчилгээг үзүүлэх, түүний чанар хүртээмжийг сайжруулахтай холбоотой тодорхой үр дүнд хүрсэн хэдий ч төслийг бодитойгоор хэрэгжүүлэх, нийгмийн эгэх хариуцлагын практик үр дүнг сайжруулах, тогтвортой байдлыг хангахтай холбоотой дутагдалтай зүйлс байгааг дурдах хэрэгтэй байна.

Тайлангийн өмнөх хэсэгт дэд төсөл тус бүрээр ямар талбарт, юуг сайжруулах шаардлагатай байгаа тухай зөвлөмжийг тусгасан болно.

Хүснэгт

Дд	Дэд төслийг хэрэгжүүлэгчид	Зөвлөмж
1	Дорнод	Нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор НЭХ-ийн бусад арга хэрэгслийг анхааран үзэх (Нийгмийн аудит)
2	Говьсүмбэр	Хамтран асуудлаа шийдвэрлэх хандлагад суурилан НЭХ-ийн чадавхийг бэхжүүлэн, ойлголтыг сайжруулах
3	Хэнтий	Гишүүдийн холбоо, сүлжээг сайжруулан дэд төслийн хүрээнд хамтран ажиллах, нэгдэх үндсийг бүрдүүлэх
4	Ховд	Аймгийн хэмжээний бүх сургуулиудад хэрэгжүүлэн, үндэсний хэмжээний бодлого боловсруулах талаар сурталчилгаа хийх
5	Хөвсгөл	ИНБ-уудын чадавх, сүлжээ үүсгэх тал дээр чадавхжуулах
6	Сэлэнгэ	Нэн тулгамдсан, эрүүл мэндийн томоохон асуудал, хөтөлбөр, үйлчилгээнд хуулбарлан хэрэглэх
7	Сүхбаатар	Хариу нэхэмжлэх чадавхийг нэмэгдүүлэх, ИНБ-уудын сүлжээ дуу хоолойг нэгтгэх
8	Увс	Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гэрээний хэрэгжилтэд оролцох уялдааг сайжруулан, орон нутгийн ИНБ-уудад технологийг шилжүүлэх
9	Өвөрхангай	Нотолгоонд суурилсан санал асуулга авах, нэхэмжлэх тал дээр орон нутгийн ИНБ-уудыг чадавхжуулах,

Гол сургамж, МУНЭХБТ-ийн дэд төслийн үр дүнг цаашид өргөжүүлэн нэвтрүүлэхэд анхаарах асуудлууд

1. МУНЭХБ төслийн дизайныг боловсруулан, нийгмийн эгэх хариуцлагын санаачилгыг дэмжихийн тулд хамгийн эхлээд аймгийн удирдлагын манлайлал, тэдний НЭХ-ийг хүлээн зөвшөөрч, дэмжин ажиллах байдал нь хамгийн чухал юм. Дэмжлэг нь төслийг хэрэгжүүлэх багийг бүрдүүлэх тухай тушаал захирамж гаргах, төслийн чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай үүрэг, хариуцлагыг ногдуулах байдлаар илэрч байна. Хэд хэдэн аймгийн болон сумын засаг дарга нар орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хувиарлалт болон зарцуулалтын үйл явц, Боловсрол болон Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад иргэдийг татан оролцуулах, орон нутгийн төрийн байгууллагын үйл ажиллагааны хяналт, шинжилгээг иргэдийн зүгээс өгөх үнэлгээтэй хослуулах зэргээр төрөл бүрийн түвшний шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангахыг албан ёсны хэлбэрт оруулахад бэлэн байгаага

илэрхийлжээ. Мөн түүнчлэн зарим аймгийн шийдвэр гаргагчдын дунд иргэдийн оролцоонд талархах, иргэдийн оролцоог хүлээн зөвшөөрч ойлгох хандлага бий болсон байна. Тухайлбал, үнэлгээний судалгаанд оролцож ярилцлага өгсөн хэд хэдэн төрийн албан хаагчид иргэний нийгмийн байгууллагыг төрийн ажлыг гүйцэтгэх нэгэн өргөтөл жигүүр хэмээн үзэж, иргэдэд төрийн үйлчилгээ, хөтөлбөрийн талаар мэдээлэх, төрийн үйлчилгээнд саад болон тулгамдаж байгаа асуудлыг илүү сайн ойлгож, хүлээн зөвшөөрөхөд иргэний нийгмийн байгууллагууд холбох (гүүрийн) үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан мэдээлэл түгээж байгаа нь сайшаалтай эхлэл бөгөөд төрийн байгууллагуудын зүгээс иргэний нийгмийн байгууллагуудыг шийдвэр гаргахад шүүмжлэлт байр сууринаас ханддаг түнш, бэрхшээлийг шийдвэрлэхэд хамтран оролцогч хэмээн харах болжээ. Гэхдээ төрийн бүх

албан хаагчид нийгмийн эгэх хариуцлагыг бүрэн утгаар нь ойлгож, нийгмийн эгэх хариуцлага болон иргэдийн оролцооноос үл эмээн түүнийг хүлээн зөвшөөрөх хандлага тааруу байна. Тэгэхээр МУНЭХБ төсөл болон иргэний нийгмийн байгууллагуудын хувьд нийгмийн эгэх хариуцлагын санаачилгыг дээд хэмжээнд хүртэл дэмжих зорилгоор орон нутгийн удирдлагын манлайллыг бий болгох хэрэгтэй байна. Аймгийн Эрүүл мэнд болон Боловсролын газар, Нийгмийн бодлого, Нийгмийн хамгааллын хэлтэсийн дарга, ахлах тушаалын болон бусад албан хаагчдаас эдгээр манлайлагчдыг сонгож болох юм. Эдгээр манлайлагчид эргээд иргэдийн оролцооны үнэ цэнэ, иргэдийн хяналт болон тэдний санаа бодлын ач холбогдолыг шийдвэр гаргагчдад ойлгуулахад нөлөөлж, бусад арга хэрэгслийг ч эрэлхийлэх болно.

2. Төслийн дизайн боловсруулахдаа төслийн хэрэгжилтийн эхний үе

шатанд чухал албан тушаалын төрийн албан хаагчид болон шийдвэр гаргагчдыг оролцуулах, иргэний нийгмийн байгууллага нь төрийн үйлчилгээ болон хөтөлбөрийн талаар шүүмжлэлт байр сууринаас бус харин бодитой, үндэслэл сайтай санал, нэхэмжлэл гаргах хэрэгтэй байна. Төслийг хэрэгжүүлж бий болсон туршлагын үр дүнд оролцогч талуудын санаа бодлыг сонсох, түүний үнэ цэнийг оролцогч талуудад ойлгуулж чадсан бөгөөд

шийдвэр гаргах болон асуудлыг шийдвэрлэх хамтын ажиллагааны эхлэл цэг болох иргэдийн санал бодлыг тандах үндсэн судалгааг зохион байгуулах, санал цуглуулах, шинжилгээ хийхдээ судалгааны найдвартай байдлыг анхааран, зорилгоо зөв тодорхойлон, асуудалд цэгцтэй хандаж, тухайн судалгааны үр дүнг шийдвэр гаргагчид болон эрх мэдэлтнүүдэд танилцуулах нь тэднээр хүлээн зөвшөөрүүлэх боломж нэмэгддэг болохыг төсөл харуулж чадсан байна.

3. Ихэнх төслийн хувьд иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан асуулгын судалгааг ингэхдээ голдуу иргэдийн онооны карт (ИОК) аргаар оролцогч талуудын санал бодлыг танджээ. Оролцогч талууд болон үйл ажиллагааг гардан хэрэгжүүлэгчид иргэдийн үнэлгээний карт (ИҮК) болон иргэдийн онооны карт (ИОК) ялгааг сайтар ухаарч ойлгож чадсан бол энэ аргыг хэрэглэхэд илүү амархан байх байлаа. Учир нь иргэдийн онооны карт асуулгыг сонгох, өгөгдөл цуглуулах нь хүн хүчний болон санхүүгийн нөөцийг ихээр шаарддаг арга бөгөөд судалгааны арга зүйгээ зөв сонгож, түүврээ зөв тодорхойлж чадалгүйгээр бүрэн төгс зүйл хийж чадахгүй бол төрийн албан хаагчид тухайн судалгааны үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй байдал үүсч, улмаар бүтээлч хамтын ажиллагаагаар дамжуулан иргэдийн санаа бодлыг тандах үйл ажиллагаанд нээлттэй хандах байдал хумигддаг. Иргэдийн үнэлгээний карт (техникийн утгаараа) аливаа төслийн хэрэгжилтэд нэг удаа хэрэглэж болох боловч оролцогч талуудын санал бодлыг тандах урт хугацааны тогтвортой механизм болж чадахгүй юм. Иргэдийн онооны карт (ИОК) ихэвчлэн судалгааны чанарын аргад төвлөрдөг, чиглүүлэгчийн ур чадварыг ихээр шаарддаг боловч оролцооны аргыг хангалттай

ИҮК, ИОК хоёулаа үйлчилгээ үзүүлэгчдээс хариу авдаг НЭХ-ийн арга мөн боловч өөр хоорондоо холигдож хэрэглэгдэж магадгүй байдаг.

Энэ хоёр аргын үндсэн ялгаа:

Иргэдийн онооны карт (CSC) ба Иргэдийн үнэлгээний карт арга (CRC)		
	ИҮК (CRC)	ИОК (CSC)
Шинжилгээний нэгж	Өрх/ Хувь хүн	Орон нутаг
Өгөгдөл цуглуулах	Асуулга	Фокус бүлгийн ярилцлага
Түүвэр	Шаталсан түүвэр	Үгүй/ Зорилго бол оролцоо
Хугацаа	3-6 сар	3-6 долоо хоног
Цар хүрээ	Макро (хот/улс/ үндэсний)	Микро (Орон нутаг/ тосгон)

түвшинд бий болгодог, судалгааг зохион байгуулах цаг хугацааны хувьд богино, нийгмийн эгэх хариуцлагын талаар судалгаа хийх явцад оролцогчид болон төлөөлөх түүвэрт төдийлөн анхаараад байдаггүй онцлогтой. Ихэнх төрийн үйлчилгээ болон хөтөлбөрийн талаарх санаа бодлыг иргэдийн онооны карт (ИОК), иргэдийн үнэлгээний картын (ИҮК) аргаар үнэлэх боломжтой бөгөөд үүний үр дүнд оролцогч талууд тухайн бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх талаар санал гаргах боломж бүрддэг. Орон нутгийн эмзэг бүлгийн иргэдийн нийгмийн даатгалд хамрагдах байдлыг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжсэн дэд төслийн хувьд нийгмийн аудитын арга илүү тохиромжтой байжээ.

4. Зарим төслүүдийн бусдаасаа илүү амжилттай хэрэгжсэн шалтгааныг энгийн, хялбар аргаар судалгаа хийж тухайн үндсэн асуудалдаа төвлөрч чадсан явдалтай холбон тайлбарлаж болох юм (Жишээ нь: Сүрьеэ, дотуур байрны нөхцөл байдал тааруу байсан байдал, амны хөндийн эрүүл ахуй г.м). Иймээс ч гаргасан шийдэл нь илүү байгаа онож, орон нутагт тулгамдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэх зорилго бүхий шинэ санаачилга, хандлага нь дэмжигдэхэд илүү хялбар байсан ажээ. Үүний эсрэгээр худалдан авах ажиллагааны

хяналт нь илүү ярвигтай, хүнд, цаг хугацаа хүний нөөц ихээр шаарддаг техник ажиллагаа ихтэй билээ. Иргэний нийгмийн байгууллагууд цаг хугацаа болон хүний нөөцийн хязгаарлагдмал байдлаа үл хайхран олон асуудлыг шийдвэрлэхэд анхаарлаа (олон онгорхойд оёдол тавих гэж хичээсэн) хандуулсан байна. Худалдан авах ажиллагаанд иргэдийн зүгээс хяналт хийхэд сургалт, техникийн чадавх ихээр шаардагддаг, хэрэглэж буй загвар нь олон хэсгээс бүрддэг бүхэллэг зүйл учраас урт хугацааны дараа үр дүнгээ өгдөг арга юм.

Зөвлөмж

Судалгааны гуравдугаар хэсэгт дэд төсөл тус бүрийн хувьд сайжруулах шаардлагатай талбарууд, тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх зөвлөмжийг бичсэн болно. Тайлангийн дараах хэсэг багц зөвлөмжийг төслийн дараагийн үе шатыг боловсруулахтай холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагаандаа ашиглаасай хэмээн хүсэж МУНЭХБ төслийн дизайныг боловсруулагчид, шийдвэр гаргагчид, хэрэгжүүлэгчдэд зориулан хүргүүлж байна. Энэ нь зөвхөн нийгмийн эгэх хариуцлага гэдэг утгаараа бус цаашдаа ер нь төслийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулах, оролцогч талуудын чадавхийг бүрдүүлэхэд ихээхэн тустай байх болно.

Үүнд:

1. Төслийн үйл ажиллагааг дэмжигчдэд нөхцөл байдалдаа шинжилгээ хийн улмаар тулгамдсан асуудлаа зөв тодорхойлоход нь туслах. Хэрэв төслийн дэмжигчид төрийн үйлчилгээг үзүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг зөв тодорхойлж чадвал чухам аль асуудлыг нийгмийн эгэх хариуцлагын ямар хандлагад суурилан шийдвэрлэх, ингэхдээ оролцогч талуудын саналаар тухайн асуудал үнэхээр тулгамдаж байгаа болохыг тодотгон гаргах, бүх оролцогч талууд нийлээд уг асуудлыг шийдвэрлэхэд бүтээлчээр хамтран оролцох боломж бүрдэх юм.
2. Дэд төслийг хэрэгжүүлэгчид нийгмийн эгэх хариуцлагын бусад хандлага, арга хэрэгслийн талаар ойлголтоо нэмэгдүүлэх нь ихээхэн ач холбогдолтой юм. Иргэдийн онооны картын (ИОК) аргаас гадна (үнэндээ бол хэрэгжүүлэгчид иргэдийн үнэлгээний картын (ИҮК) үндсэн шинжийг оруулсан байсан) оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, төрийн байгууллага болон үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагааны талаарх санаа бодлыг цуглуулах бусад арга технологид суралцах хэрэгтэй байна. Тухайлбал, иргэдийн үнэлгээний картын

аргатай харьцуулахад иргэдийн онооны картын арга нь илүү хялбар, өртөг багатай байдаг. Хэрэгжүүлэгчдийн зүгээс 10 дэд төслийн саналыг боловсруулсан байдлыг судлан үзэхэд зарим тулгамдаж буй асуудлаа төсвийн зарцуулалтыг мөшгих судалгаа, төсвийн хяналт шинжилгээ, нийгмийн аудит зэрэг оролцооны аргаар илүү сайн тодорхойлж болох байсан бөгөөд хэрэв ингэж чадсан байсан бол үйлчилгээг сайжруулах талаар илүү тодорхой объектив саналыг авч улмаар цөөн тооны оролцогчийг судалгаанд хамруулж, судалгааны өртөгийг нь бууруулах боломжтой байсан юм. Үйлчилгээг үзүүлэхэй холбоотой тодорхой асуудлыг үнэлэх, эрэмбэ үүсгэхэд иргэдийн онооны картыг хэрэглэх нь төслийн үйл ажиллагааг дэмжигчдийн хувьд илүү шуурхай, үр дүнтэй, өртөг багатай арга болно.

3. Гуравдугаарт, төслийн дизайны хувьд төрийн байгууллагын дэмжлэгийг авах байдлаар боловсруулагдсан тул аймгийн хэмжээний төрийн албан хаагчдын албан тушаал, эрх мэдэлд өөрчлөлт ороход дэд төслийн хүрээнд бий болсон сайн туршлага үргэлжилж чадахгүй зогсох, тасалдах байдал үүсэж болзошгүй юм. Нэмж хэлэхэд төслийн хүрээнд сонгож авсан асуудал нь төдийлөн ач холбогдол багатай гэж үзэж болохоор байна. Нөхцөл байдал нийгмийн хариуцлагын

практик бүрт ижил байх албагүй учраас иргэний нийгмийн оролцогч талууд бүтээлч хамтын ажиллагааг бүрдүүлэх чадавхиа сайжруулахад анхаарах хэрэгтэй байна (маргаантай асуудлаа зөв чиглүүлэх, төрийн байгууллагатай тогтоох хамтын ажиллагаанд бий болох сорилтыг анхаарах г.м).

4. Аймгийн түвшний төслийг хэрэгжүүлэгчид болон оролцогч талууд түншлэгч үндэсний ТББ-уудад талархалаа илэрхийлж байлаа. Үндэсний ТББ-ууд нийгмийн эгэх хариуцлагын хандлага, арга хэрэгсэлд анхаарахаас гадна төслийн нийт удирдлагын үйл ажиллагаанд анхаарал хандуулах хэрэгтэй байна. Эдгээр үндэсний ТББ-уудын зүгээс орон нутагт хэрэгжиж байгаа төслийн оролцогч талуудад нийгмийн эгэх хариуцлагын практикийн талаар бүрэн дүүрэн мэдлэг эзэмших, санаачилгаа илүү үр дүнтэй үр ашигтай байдлаар хэрэгжүүлэхэд нь туслах, хяналт тавих амин чухал суваг болох учраас эхэнд дугаарлагдсан багц зөвлөмжийг авч хэрэгжүүлэх нь эдгээр үндэсний ТББ-уудыг дэмжих, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй байх болно. Орон нутгийн төсөл хэрэгжүүлэгчдийн хувьд засаглалын асуудлууд, тулгамдаж буй асуудлаа тодорхойлох, тухайн асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх болон төрийн үйлчилгээг

үзүүлэх, засаглалтай холбоотой сорилтуудыг шийдвэрлэх үр дүнтэй, бүтээлч хамтын ажиллагаа бүхий шийдэл гарц хайхад туслах нь хамгийн хэцүү сорилт юм. Энэ байдалтай холбогдуулан тэдэнд нийгмийн эгэх хариуцлагын бусад арга хэрэгсэл, хандлагыг зааж эзэмшүүлэн түүнийгээ орон нутгийн хэрэгцээ, шаардлага, онцлогт тохируулан хэрэглэх нь зөв юм.

5. Эцэст нь тэмдэглэж хэлэхэд хэд хэдэн төрийн албан хаагчид, үйлчилгээг үзүүлэгчид засаглалын албан ёсны үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахад иргэдийг оролцуулах, иргэдийн санал бодлыг хяналт шинжилгээ үнэлгээний аргатайгаа хослуулан үргэлжлүүлэн хэрэглэхийн ач холбогдлыг ойлгон, хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн юм. Цөөн төслийг эс дурдвал ихэнх дэд төслүүдийн хувьд өөрсдийн аймагт хэрэгжсэн дэд төслийн сургамжид суурилан үр дүнг нь бэхжүүлэх, өөрсдийн үйл ажиллагаатайгаа хослуулах талаар албан ёсны институцилагдсан зохицуулалт хийгдээгүй байна. Энэ байдалтай уялдуулан МУНЭХБ төслийн зүгээс орон нутгийн тодорхой бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаанд оролцооны механизмыг идэвхжүүлэх чиглэлийг хэрхэн тусгах талаар орон нутгийн удирдлагын нэгжид дэмжлэг үзүүлэн ажиллах, энэ талаарх сонирхлоо илэрхийлэх нь зүйтэй юм.

Хавсралт 1:

Ярилцлагын удирдамж

1. Ханган нийлүүлэлтийн талаас: Оролцоо/эргэн мэдээллэх үйл ажиллагааг дэмжих ямар албан ёсны механизмуудыг бий болгосон бэ? Энэ асуудлыг хариуцсан албан хаагчид хэн бэ? Ямар шийдвэр гаргаж, ямар арга хэмжээ авсан бэ?
2. Эрэлт хэрэгцээний талаас: Оролцогч талууд хэн байсан бэ? Оролцоо, оролцооны арга хэрэгсэл, үйл явц, оролцоог хангах ба эргэн мэдээллэх механизмууд хэрэгтэй гэдэг талаар тэдний мэдлэг хир түвшинд байсан бэ?
3. Төслийн хэрэгжилтийн үр дүн/гарцын түвшин: Төрийн байгууллага, үйлчилгээ үзүүлэгч нарт ямар мэдээллийг хангаж өгсөн бэ? Үйлчилгээг төлөвлөх, төсөвлөх, хүргэхэд ямар орц, зөвлөмжүүдийг бодолцож үзсэн бэ? Үйлчилгээ, хөтөлбөрийн хүртээмж, чанарын талаар мэдээлэл өгсний үр дүнд иргэд ямар төрлийн үйлчилгээ, хөтөлбөрөөс илүү их ашиг тус хүртсэн бэ? Эргэн мэдээлэл өгөх буюу орцын талаар иргэд болон төрийн байгууллагуудын хооронд албан болон албан бус ямар гэрээнүүдийг байгуулсан бэ?
4. Үр дүн: Тус санаачлага нь засаглалыг сайжруулах тал дээр ямар үр дүнг бий болгосон бэ? Иргэд хүлээж авсан/олж авсан мэдээллээрээ юу хийсэн бэ? Хүртээмж, чанар ба хүлээлгийн цагт ямар нэг эерэг өөрчлөлт гарсан уу?
5. Тогтвортой байдал: Төслийн үр дүн нь төрийн байгууллага болон түүний албан хаагчид, зохион байгуулалтад орсон иргэдийн бүлэг болон нийт иргэдийн үзэл бодол, зан байдал, засаглалын тогтолцоонд хэрхэн нөлөөлсөн бэ? Тус санаачлагыг цаашид үргэлжлүүлэх хүсэл эрмэлзэл, нөөц бололцоо болон албан механизмууд бий болсон уу?